TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

POWERFUL

CONTINUOUS

RELIABLE



SECURE

EXPERIENCED

SUSTAINABLE

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2017

ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА

# АГУУЛГА

## 01 ЕРӨНХИЙ АГУУЛГА


x4 Ерөнхийлөгчийн мэндчилгээ
x6 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
x8 Хөгжил дэвшилд хамтдаа
x9 Банкны бүтэц зохион байгуулалт
x10 Компанийн засаглал
x11 Төлөөлөн удирдах зөвлөл
x14 Гүйцэтгэх удирдлага - удирдлагын хороо
x16 Түүхэн он жилүүдийн хураангуй цагалбар
x18 Олон улсад үнэлэгдсэн шагналууд
x19 Нийгмийн хариуцлага
x23 Санхүүгийн үзүүлэлтүүд
x27 Хүний нөөцийн удирдлага


## 02 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


x29 Иргэдийн зах зээл
x32 Байгууллагын зах зээл
x33 Хөрөнгө зохицуулалтын удирдлага
x37 Гадаад харилцаа, олон улсын банкны үйл ажиллагаа
x40 Ти Ди Би Капитал ҮЦК
x42 Ти Ди Би Лизинг ХХК
x44 Эрсдэлийн удирдлага
x48 Мэдээллийн технологи
x50 Ностро данстай банкууд


## 03 ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН


x54 Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын мэдэгдэл
x55 Хараат бус аудиторын тайлан
x58 Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан
x58 Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан
x59 Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан
x61 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
x62 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт харилцагч, түншүүд, хувь нийлүүлэгчид ээ,

Худалдаа, хөгжлийн банкныхаа амжилт ололт, дэвшлүүдээр дүүрэн 2017 оны үйл ажиллагааг Та бүхэндээ ийнхүү бахархалтайгаар тайлагнаж буйдаа миний бие туйлын таатай байна.

Бид эдийн засгийн ямар ч цаг үед харилцагчиддаа банкны үйлчилгээг найдвартай хүргэн үйлчилж, хамтран ажиллагч түншүүдтэйгээ тогтоосон харилцаагаа бат хадгалан, 27-н жил банк санхүүгийн салбартаа тэргүүлэх байр суурьтай ажиллаж ирсэн Монгол улсын ууган арилжааны банк билээ.

2017 онд бид иргэд, байгууллагын харилцагчиддаа дэвшилтэт олон бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж, шаардлагатай санхүүжилтийг шуурхай олгон, олон төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлснээс гадна гадаад харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд хэд хэдэн томоохон ач холбогдолтой уулзалт, хэлэлцээрүүдийг хийлээ. Тухайлбал, харилцагчдынхаа гадаад шилжүүлгийг ханшийн эрсдэлгүйгээр, үндэснийхээ мөнгөн тэмдэгтээр шуурхай гүйцэтгэх, цаашилбал харилцагчиддаа бага хүүтэй, илүү тааламжтай нөхцөлөөр зээл авах боломжийг нээж, Хятадын хөдөө аж ахуйн банктай Төгрөгийн дансны болон Төгрөгийн зээлийн хамтын ажиллагааг эхлүүлэх, мөн ам.долларын төлбөр тооцооны үйл ажиллагааг өргөжүүлж, хамтран ажиллах болсноор Монгол улс руу чиглэх ам.долларын урсгалыг

> *"Бид иргэд, байгууллагын харилцагчиддаа дэвшилтэт олон бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж, шаардлагатай санхүүжилтийг шуурхай олгон, олон төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ.*

нэмэгдүүлэх боломжийг бий болгон, улс эх орныхоо эдийн засагт хувь нэмрээ оруулаа. Түүнчлэн, БНХАУ–ын Хөгжлийн Банктай байгуулсан гэрээний хүрээнд, анхны санхүүжилт 20 сая ам.долларын эх үүсвэрийг хүлээн авсан бол тайлант онд нийт 770 тэрбум төгрөгийн худалдааны санхүүжилтийн болон төслийн зээлийн эх үүсвэр шинээр татжээ. Ийнхүү 2.5 их наяд төгрөгийн зээлийн том болон жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг хийсэн байна.

ХХБанк байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн системийг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд Нидерландын хөгжлийн банк болон дотоодын байгаль орчны зөвлөх компанийн хамтарсан хөндлөнгийн аудитаар "89.5% буюу САЙН" үнэлгээ авсан баярт мэдээ байна.

Тайлант онд банкны хүртсэн амжилт ололтуудаас товчхон дурдвал, Монгол улсад байгуулагдах Европын холбооны төлөөлөгчийн газраас зарласан тендерт ялалт байгуулж, банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх банкаар сонгогдсон бол Азийн хөгжлийн банкны Худалдааны санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд "Монгол дахь тэргүүлэгч хамтрагч банк"-аар 3 дахь жилдээ дараалан шалгарч энэхүү хөтөлбөрийг хамгийн идэвхтэй ашигласан гурван улсын нэгээр тодорсон. Мөн Монгол улсын банкны салбараа үргэлж тэргүүлсээр ирсэн манай банкны үйл ажиллагааг Дэлхийн банк санхүүгийн байгууллагууд өндрөөр үнэлж, 2017 онд Global Banking & Finance Review байгууллагаас "Монгол улсын шилдэг арилжааны банк"-аар 6 дахь жилдээ шалгаруулсан бол дэлхийд нэр хүнд бүхий Euromoney сэтгүүлийн Awards for Excellence 2017 арга хэмжээний үеэр 2017 оны "Монгол улсын шилдэг банк" шагналыг гардуулсан билээ. 2018 он бидний хувьд өөдрөг, гялалзсан амжилтаар дүүрэн жил байх болно гэдэгт миний бие итгэл дүүрэн байна.

Та бүхэн эрүүл энх байж, зөв бодол, чин шударгаар амжилтын өөд тэмүүлж, цог золбоотой тэмүүлэхийн ерөөлийг өргөн дэвшүүлэхийн ялдамд ХХБанкны удирдлагын баг, нийт захирлууд, ажилтнууддаа шаргуу хөдөлмөрсөнд нь талархал илэрхийлье.

Ерөнхийлөгч

**Балбарын МЭДРЭЭ**



# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт харилцагч, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч байгууллага, аж ахуйн нэгж, түншүүд Та бүхэндээ Худалдаа, хөгжлийн банкныхаа 2017 оны ажлын үр дүн, гүйцэтгэл, амжилт, ололтуудаа толилуулж буйдаа баяртай байна.

Монгол улсынхаа хөгжил дэвшилд ХХБанк 27-н жилийн хугацаанд хувь нэмрээ оруулж, 27-н жил эдийн засгийн тулгуур хүч нь байж ирснээрээ, үе үеийн ахмад ажилтнуудаараа, удирдлагуудаараа, үнэнч харилцагчдаараа, эрч хүчтэй хамт олноороо, хийж бүтээсэн амжилт, ололтоороо бид бахархдаг.

ХХБанк нь харилцагчиддаа итгэл хүлээсэн найдвартай, мэргэжлийн түвшний үйлчилгээг хүргэхийн тулд ажилтнуудынхаа мэдлэг уч чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж ажиллан, 2017 онд давхардсан тоогоор 5’600 гаруй ажилтнаа сургалтанд хамруулсан бол шинээр 238 боловсон хүчнийг ажлын байраар хангаж, 145 ажилтныг албан тушаал дэвшүүлсэн байна.

Тайлант онд түүхий эдийн үнийн өсөлт болон ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн нөлөөгөөр улсын ДНБ өсөлттэй гарсан хэдий ч бизнесийн орчны эрсдэл хэвээр хадгалагдсан жил байлаа. Гэсэн хэдий ч бид харилцагчдынхаа санхүүгийн эрэлтийг хангаан ажиллаж, банкны актив 3.5% хувиар, нийт харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 27.1 хувиар өсөн,

> *“Дижитал банкны эхлэлийг тавьж, төлбөрийн шинэ трэнд TDB Pay үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн даруйдаа 30 мянга гаруй худалдаа, үйлчилгээ эрхлэгчийг элсүүлсэн бол тус үйлчилгээгээр нийт 140 мянган удаагийн 6.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдлээ.*

иргэдийн хугацаатай хадгаламжийн үлдэгдэл III улиралд анх удаа 1.0 их наяд төгрөгт хүрч улмаар оны эцэст 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь банкны нэр хүнд, харилцагчдын банкинд итгэх итгэл нэмэгдсэний илэрхийлэл гэж бодож байна.

2017 онд бид Дижитал банкны эхлэлийг тавьж, төлбөрийн шинэ трэнд TDB Pay үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн даруйдаа 30 мянга гаруй худалдаа, үйлчилгээ эрхлэгчийг элсүүлсэн бол тус үйлчилгээгээр нийт 140 мянган удаагийн 6.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Бид банкны үйлчилгээг харилцагчиддаа улам илүү ойр болгож, харилцагч бүртээ хүрч үйлчлэх чиглэлийн дагуу 7 бүтээгдэхүүн, үйлчилгээг нэгтгэсэн нэг хуудас Мастер гэрээг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр харилцагч нэг л удаа банкинд биеэр ирж энэхүү гэрээг байгуулж, цаашид зайнаас банкны бүхий л үйлчилгээг хурдан шуурхай авах боломжийг бүрдүүлсэн билээ.

ХХБанкны зээлийн багцын чанар, санхүүгийн тогтмол өсөлт, найдвартай байдлыг үнэлж, Азийн хөгжлийн банкнаас жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан төслийн зээлийг Зээлийн батлан даалтын сантай хамтран олгох банкаар манай банкийг сонгосноор 2017 оны 09-р сарын 29-ний өдрөөс эхлэн харилцагчиддаа энэхүү хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлснээр тайлант онд нийт 2.1 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Мөн Замын-Үүд хотод баригдах 15 МВТ-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын төсөлд санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх гэрээг Японы “Shigemitsu Shoji” компанитай байгуулсан зэрэг олон амжилтуудад 2017 онд бид хүрлээ.

Монгол улсын олон талт үйл ажиллагаатай, тэргүүлэх зэргийн банкны зүгээс болон хувиасаа тайлант онд амжилттай хамтран ажилласан ажилтнууд болон итгэл хүлээлгэсэн эрхэм харилцагч Та бүхэндээ талархал илэрхийлье.

2018 онд ХХБанк салбар, сүлжээгээ улам тэлж, цаг хугацаатай өрсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ улам чанаржуулах, дэлхийн жишигт хүрсэн олон бүтээгдэхүүнийг дахин бий болгох зорилтыг тавин ажиллах болно.

Та бүхнийг гүнээ хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал

**Ононгийн ОРХОН**



# ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА

### Банкны лого

Банкны лого нь мөнгөний нэгж болох зоосны хэлбэрт суурилж зохиогдсон бөгөөд түүнд урлаж шингээсэн агуулга нь зоосны голд дүрслэгдсэн мөнгөний авдарт тасралтгүй эргэлдэх мөнгөний эргэлтээр дөрвөн зүг найман зовхисоос мөнгө, эд баялаг хуримтлагдан арвижиж, эд мөнгөөр элбэг дэлбэг байхын утга бэлэгдлийг агуулдаг.

### Уриа

**“Хөгжил дэвшилд хамтдаа”**

Уриа нь банкны ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид зэрэг хүн бүхнийг хөгжил дэвшлийн зүгт хамтдаа алхахыг уриалан дуудах, нэгтгэх, зоригжуулсан утга бэлгэдэлтэй юм.

### Эрхэм зорилго

ХХБанк нь Монгол улсын олон талт үйл ажиллагаатай, тэргүүлэх зэргийн банкны хувьд том, дунд, жижиг харилцагчдын зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэсэн, үнэ цэнэтэй банкны үйлчилгээг хөгжүүлэн хүргэж, үйлчилгээнээс хүртэх сэтгэл ханамжийг байнга, хамгийн өндөр түвшинд байлгахад зорин ажиллана. Бид бүхний амжилт ололт шилдэг сайн үйлчилгээ, өндөр мэргэжлийн боловсон хүчин, хамтын удирдлагын дээд зэргийн арга барилд үндэслэх болно.

### Хэтийн зорилго

ХХБанк нь Монгол улсын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгч, олон улсын шилдэг туршлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэгч, олон талын үйл ажиллагаатай банк, харилцагч үйлчлүүлэгч, хамтрагч түншүүдийнхээ санхүүгийн сайн сайхан, тогтвортой байдалд хүрэхэд тууштай, хариуцлагатай туслагч, итгэл найдварыг нь хүлээсэн түнш нь байсаар байх болно.

# БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХХБанк нь олон улсын туршлагаар шалгарсан компанийн засаглалын бүхий л хэм хэмжээг дэмжин ажилладаг бөгөөд дээд түвшний, сайн байгууллагын засаглал нь бидний үйл ажиллагааны гол чиглүүлэгч болдог.

Бид компанийн засаглалын бүтэцдээ Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) - ийн болон удирдлагын багийн гишүүд, хувь нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа, нягт харилцааг нарийн тодорхойлж, байгууллагынхаа эрхэм зорилго, зорилтдоо хүрэхийн тулд хувь хүн бүр ёс зүйн ямар хэм хэмжээг үйл ажиллагаандаа баримтлахыг нарийвчлан заасан байдаг.

### Төлөөлөн удирдах зөвлөл

ХХБанкны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бүхий бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

### Удирдлагын баг

ХХБанкны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог төдийгүй банкны урт удаан хугацааны ашигт ажиллагаа хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

### Ажилтнууд

ХХБанкны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэдний шударгаар урамшуулж, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчиддаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

### Бид

ХХБанк нь хууль, ёс зүйн хариуцлагын хүрээнд нийцсэн ажиллах орчинг бүрдүүлэхийг үргэлж эрмэлзсээр ирсэн бөгөөд харилцагч, бизнесийн түншүүд болон нийгэмдээ банкны шилдэг үйлчилгээг үзүүлэн, хувь нийлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ аливаа амжилт нь шударга байх ёстой гэдэгт итгэдэг.

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ




**Компанийн засаглалын зорилго**

Компанийн засаглалыг сайжруулан олон улсын шилдэг зарчим, туршлагуудын хэмжээнд хүргэх. Олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, нэр хүндтэй үнэ цэнтэй, хөрөнгө оруулалтыг бодитой татаж чаддаг болох.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ .................

ТУЗ - ийн дарга
Должин **ЭРДЭНЭБИЛЭГ**

ТУЗ - ийн Гүйцэтгэх дэд дарга
Рандолф **КОППА**

ТУЗ - ийн Орлогч дарга
Дамдин **ГАНТӨГС**

ГИШҮҮД ..................................................

Тамир **ЦОЛМОН**
Зуунай **ШАГДАРСҮРЭН**
Жалбаа **БОЛОРМАА**
Жамсрандорж **ДЭЛГЭРСАЙХАН**

БАНКНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА............

Дашзэгвэ **ДАВААЖАВ**

# ДОТООД АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

**Дотоод аудитын үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт**

ХХБанкны дотоод аудитын үйл ажиллагаанг ТУЗ-ийн харъяа Аудитын хороо, Ерөнхий аудитор, Дотоод аудитын газар (ДАГ) нь хариуцан ажиллаж байна. Дотоод аудит нь байгууллагын эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын аливаа үйл ажиллагааны үр өгөөжийг дотоод аудитын мэргэжлийн үүднээс системтэйгээр үнэлж дүгнэн, өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд тусалдаг.

ДАГ-ын үйл ажиллагаа нь банкны бүхий л үйл ажиллагаанд чиглэгдсэн байх ба тухайн газар, хэлтэс, салбар, тооцооны төв, охин, хараат компаниудын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг үр дүнтэй байлгахын тулд бие даасан, бодит байдлаар шинжилсэн, үнэлсэн, зөвлөгөө өгсөн тайлангаар хангадаг.

ХХБанкны дотоод аудитын тогтолцооны удирдлага, зохион байгуулалтын бүтцийг харуулбал:




**Дотоод аудитын газрын үйл ажиллагаа**

ДАГ нь банкны бүхий л үйл ажиллагааны хүрээнд аудит хийх, зөвлөгөө өгөх чиг үүрэгтэйгээр, Ерөнхий аудитороор дамжуулан банкны ТУЗ, Аудитын хороонд тайлагнаж, банкны Гүйцэтгэх удирдлагад мэдээлэх зарчмаар ажилладаг бөгөөд ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан бодлого, журам, төлөвлөгөө, мөн Дотоод аудиторуудын олон улсын институт (IIA Global)-ээс гаргадаг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (IIA Global – International Professional Practice Framework)-г үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.

**Дотоод хяналтын тогтолцоо**

Банкны дотоод хяналтын тогтолцоо нь Гүйцэтгэх удирдлага банкны дотоод хяналтыг хариуцан хэрэгжүүлж, түүний үр дүнтэй, үр ашигтай байдалд Аудитын хороо, ДАГ хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгөх зарчмаар хэрэгжиж байна.
Байгууллагын зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн байгууллагын дээд удирдлага, гүйцэтгэх удирдлага болон

бусад бүх ажилтнууд мөрдөн, биелүүлэх ёстой цогц процессыг дотоод хяналт гэж ойлгоно. Дотоод хяналтын үйл ажиллагаа нь банкны өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бизнесийн бүхий л түвшинд оновчтой хяналтын тогтолцоо бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг. Үүнд, удирдлагын түвшний хяналт, газар, нэгж бүрийн онцлогт тохирсон хяналт, газар дээрх хяналт, комплайнсын хэрэгжилт, зохицуулалтын бодлого, журам, заавар, программд хандах эрхийн зөвшөөрөл өгөх үйл ажиллагаа зэрэг багтана.

Банк нь байгууллагын зохистой засаглалыг бүрдүүлэхэд шаардлагатай дотоод хяналтын тогтолцоог холбогдох хууль, заавар, журмын зохицуулалтад үндэслэж бүрдүүлдэг.

ХХБанкны Гүйцэтгэх удирдлагын зүгээс банкны дотоод хяналтын тогтолцоог оновчтой болгох талаар арга хэмжээ (хяналтын үүрэг бүхий ажлын байрыг бий болгох, заавар журамд дотоод хяналттай холбоотой заалтыг тусгах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод хяналтын ажил, үүргийг тусгах зэрэг) авч, дотоод хяналтын үйл ажиллагаа тасралтгүй, чанартай явагдаж буйд байнга анхаарч, хяналт тавьж ажиллаж байна.

Банкны дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн, үр ашигтай явагдаж байгаа эсэх, Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтаа хэрхэн сайжруулж байгаа, залруулах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж буйд ДАГ- аас аудит хийж үнэлгээ, дүгнэлт өгч, үр дүнг Ерөнхий аудитор, Аудитын хороо болон Гүйцэтгэх удирдлагад мэдээлж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авдаг.

# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА - УДИРДЛАГЫН ХОРОО



1

**Ноён Б.МЭДРЭЭ**
Ерөнхийлөгч



2

**Ноён О.ОРХОН**
Гүйцэтгэх захирал



3

**Ноён Д.ХҮРЭЛБААТАР**
Гүйцэтгэх захирлын орлогч



4

**Ноён С.ОРГОДОЛ**
Гүйцэтгэх захирлын орлогч









5
**Хатагтай Д.ОТГОНБИЛЭГ**
Гүйцэтгэх захирлын орлогч

6
**Ноён Л.СОРОНЗОНБОЛД**
Гүйцэтгэх захирлын орлогч

7
**Хатагтай П.ГАНТУУЛ**
Ерөнхий аудитор

8
**Ноён Л.НЯМСҮРЭН**
Захиргаа, хүний нөөцийн газрын захирал

# 2009-2017 ОНЫ ХУРААНГУЙ ЦАГАЛБАР

## 2009

- Монгол улсаас анх удаа Олон улсын санхүүгийн зах зээл дээр гаргасан 75 сая ам.долларын бондоо хугацаанаас нь өмнө амжилттай эргүүлэн төлөөв.
- "Moneygram" сүлжээгээр Евро валют хүлээн авах шинэ үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүллээ.
- БНСУ-д ажиллаж амьдарч буй Монголчуудад зориулж Солонгосын Hana банк, PayOne компанитай хамтран хямд өртгөөр, түргэн шуурхай мөнгө гуйвуулах боломж бүхий "PayEasy" үйлчилгээ шинээр нэвтрүүлж, харилцагчдын талархлыг хүлээлээ.
- "SMS banking" буюу картын гүйлгээний мэдээллээ гар утсандаа хүлээн авах үйлчилгээг нэвтрүүллээ.

## 2010

- Монголд анх удаа "Мобайл банк" үйлчилгээг бүрэн хэмжээгээр нэвтрүүллээ.
- ХХБанк Олон улсын хөрөнгийн зах зээл дээр дахин нэрээ гаргаж, 175 сая ам.долларын бондыг амжилттай арилжааллаа.

## 2011

- "Bloomberg TV Mongolia"-г үүсгэн байгууллаа.
- Дэлхийн тэргүүлэгч банк болох "Goldman Sachs" групптэй "ХХБанкны 4.78 хувьтай тэнцэх хувьцааг худалдан авах" хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурлаа.

## 2012

- Анх удаа ₮ цахим картыг зах зээлд нэвтрүүллээ.
- Монголд анх удаа гурвалсан валюттай, UnionPay картыг нэвтрүүллээ.
- 300 сая ам.долларын бондоо амжилттай арилжааллаа.

## 2013

- Монгол Улсаас анх удаа олон улсын санхүүгийн зах зээл дээр 82 сая ам.долларын "Хамтын санхүүжилтийн зээл"-ийн гэрээг үзэглэлээ.
- Дэлхийд тэргүүлэгч "Microsoft" корпорацтай "Хамтын ажиллагааны гэрээ"-г үзэглэснээр программ хангамжийн чанар, найдвартай байдал зэргийг цогцоор нь олон улсын түвшинд баталгаажууллаа.
- Finance Asia сэтгүүлээс "Best Bank in Frontier Market" буюу "Хөгжиж буй орнуудын шилдэг банк"-аар Ази тивээс шалгарлаа.

## 2014

- Богино хугацаатай юанийн бонд амжилттай арилжиж, 700 сая юанийн хөрөнгө оруулалт төвлөрүүллээ.
- Олон улс дахь анхны төлөөлөгчийн газраа Япон улсын нийслэл Токио хотод нээлээ.

## 2015

- Таван жилийн хугацаатай 500 сая ам.долларын бондыг амжилттай арилжааллаа.
- Монголд анх удаа Кастодиан банкны үйлчилгээг бүрэн нэвтрүүллээ

- Швейцарын Давос хотноо зохион байгуулагддаг Дэлхийн эдийн засгийн форумд Монгол Улсаа дэлхийн томоохон удирдагчид, хөрөнгө оруулагчдад таниулан сурталчлах Mongolia Night арга хэмжээг 4 – н жил дараалан зохион байгууллаа.
- Олон Улсын Иргэний Агаарын Тээврийн Холбоо (IATA) - ны Монгол Улс дахь Клирингийн үйлчилгээ үзүүлэх банкыг сонгон шалгаруулах тендерт оролцон шалгарлаа.
- Байгууллагынхаа мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, хүүгийн орлогоо нэмэгдүүлэх боломжтой хөрвөх чадвар бүхий байгууллагын хадгаламжийн сертификатын бүтээгдэхүүнийг шинээр зах зээлд нэвтрүүллээ.
- Харилцагчид гадаад, дотоод төлбөр тооцоогоо хялбаршуулан, шуурхай гүйцэтгэх гадаад шилжүүлгийн багц үйлчилгээг шинээр үйл ажиллагаандаа нэвтрүүллээ. Ингэснээр гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гадаадаас дансаа удирдах боломжийг гадаад шилжүүлгийн үйлчилгээндээ амжилттай нэвтрүүллээ.

## 2016

## 2017

- 2014 онд гаргасан 700 сая юанийн буюу 115 сая ам.долларын 3-н жилийн хугацаатай бондыг өөрийн дотоодын эх үүсвэрээр хугацаанд нь амжилттай төлж, санхүүгийн чадавхи, найдвартай байдлаа бататгасан.
- БНХАУ-ын China Construction Bank (CCB)- тай хамтран "Гадаад худалдааг дэмжих зээлийн гэрээ байгуулах" санамж бичигт гарын үсэг зурлаа.
- Хятадын Хөдөө Аж Ахуйн Банктай "Харилцан Ойлголцлын Санамж бичиг"-т гарын үсэг зурж, ам.долларын төлбөр тооцоог өргөжүүлэх гарцыг нээлээ.
- Visa payWave олон улсын дэвшилтэт технологи бүхий олон улсын Алтан кредит, Лэйди премиум кредит картыг анх удаа зах зээлд нэвтрүүллээ.
- Худалдаа эрхлэгч, худалдан авагч хэн бүхэнд тохирох, төлбөрийн цоо шинэ, хялбар шийдэл бүхий дэвшилтэт TDB Pay үйлчилгээг шинээр нэвтрүүллээ.
- Банкны үйлчилгээг хөдөлгөөнт байдлаар харилцагчийн байгаа газарт үзүүлэх, мөн харилцагчийг бүртгэх банкны суурь бүртгэлийн программтай холбогдсон eReg бүртгэлийн аппликейшныг амжилттай нэвтрүүллээ.
- TDB Online цахим үйлчилгээ, ATM ашиглан харилцагч хаанаас ч, хэзээ ч мөнгөн гуйвуулга хийх, хүлээн авах боломжтой MoneyGram self-service үйлчилгээг нэвтрүүллээ. Харилцагчийн санал, хүсэлтэд автоматаар хариулт өгөх AI технологид суурилсан TDB Bot үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.
- TDB Online цахим үйлчилгээгээр харилцах болон хадгаламжийн данс нээх, QR код бүхий баталгаажуулах кодтой дансны тодорхойлолт болон бусад төрлийн тодорхойлолтуудыг онлайнаар авах боломжтой болсон.
- Зээлийн батлан даалтын сантай хамтран Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 60 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох гэрээнд гарын үсэг зурлаа.
- TDB Online цахим үйлчилгээнд банкны үйлчилгээ, даатгалын үйлчилгээ, хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг хамтад хэрэглэх боломжийг хөгжүүлснээр санхүүгийн гурван тулгуурыг харилцагч нартаа онлайнаар хүргэж байгаа анхны банк боллоо.
- Банкны үйлчилгээг харилцагчиддаа улам илүү ойр болгох зорилгоор 7 бүтээгдэхүүн, үйлчилгээний 15 гэрээг нэгтгэн нэг хуудас Мастер гэрээ болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.

# ОЛОН УЛСАД ҮНЭЛЭГДСЭН ШАГНАЛУУД



### “МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ АРИЛЖААНЫ БАНК”

Их Британийн “Global Banking & Finance Review” байгууллагаас 2017 оны “Монгол Улсын шилдэг арилжааны банк” - аар 6 дахь жилдээ дахин шалгарлаа.

***2012, 2013, 2014, 2015, 2016, 2017***



### “МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК”

Дэлхийд нэр хүнд бүхий Euromoney сэтгүүлийн Awards for Excellence 2017 арга хэмжээнээс “Монгол улсын шилдэг банк”-аар тодрууллаа.




### “МОНГОЛ ДАХЬ ТЭРГҮҮЛЭХ ХАМТРАГЧ БАНК”

Азийн хөгжлийн банкны Худалдааны санхүүжилтийг дэмжих хөтөлбөрийн “Монгол дахь тэргүүлэх хамтрагч банк” шагналыг 2 жил дараалан гардан авлаа.

***2016, 2017***




### “BEST INNOVATIVE PRODUCT”

Олон улсын төлбөрийн системээр дэлхийд тэргүүлэгч Visa Worldwide байгууллагаас Visa payWave дэвшилтэт технологитой Алтан кредит картаараа “Best Innovative Product” шагналыг гардан авлаа.



### “ШИЛДЭГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА”

Японы Засгийн газрын “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх” JICA төслийн “Шилдэг санхүүжүүлэгч байгууллага” шагналыг 2 дахь жилдээ гардан авлаа.

***2016, 2017***

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

## Хүүхэд амь төслийг дэмжин оролцлоо

ХХБанк нярайн эндэгдлийг бууруулах зорилгоор JCI Mongolia байгууллагаас зохион байгуулсан **“Save Life”** төсөлд хамтран оролцож, **0.5-3.5 кг** жинтэй, **28 хүртэлх хоногтой** нярайн Монголын хамгийн анхны олон улсын стандартад нийцсэн мэс заслын орчинг бүрдүүлсэн тасгийг тохижуулан, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хүлээлгэн өгсөн юм. Нярайн мэс заслыг зөвхөн нярайд зориулсан өрөөнд, зориулалтын тоног төхөөрөмжөөр хийснээр хагалгааны үед болон хагалгааны дараа гарах аливаа эрсдэлийг бууруулдаг бөгөөд 2016 оны байдлаар энэхүү төслийн хүрээнд Монгол улсын нярайн эндэгдэл түүхэндээ анх удаа **19.1%**-иас **5.6%** хүртэл буурсан байна.




## Мазаалай баавгайн ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор булаг шандны эхийг хамгаалж, дахин тохижуууллаа

ХХБанк нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухаан технологийн сан, ШУА-ийн ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн



амьтан судлалын алба, Говийн Их Дархан цаазат газрын “А” хэсгийн хамгаалалтын захиргаа болон бусад ААН-үүдтэй хамтран Мазаалай баавгайг хамгаалах ажлыг дэмжиж хамтран ажиллалаа. Энэ ажлын хүрээнд ХХБанк дангаараа Мазаалай баавгайн амьдрах орчныг сайжруулах зорилгоор усны хүртээмжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм шинээр байгуулах, ундаалдаг булаг шандны эхийг хамгаалах, дахин тохижуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

## Дижитал банк стратегийн хүрээнд МАСТЕР ГЭРЭЭ-г нэвтрүүлснээр цаасны хэрэглээг үлэмж багасгалаа

Байгаль, экологийн асуудал хурцдаж буй энэ үед ХХБанк ногоон хөгжлийг дэмжиж, байгаль хамгаалах, цаасны хэрэглээг бууруулахад хувь нэмрээ оруулж Зээлийн шийдвэр гаргах процесс, банкны дотоод үйл ажиллагааны шийдвэр гаргах процессийг тус тус цахимжууллаа. Түүнчлэн 7-н бүтээгдэхүүний нийт **15 хуудас** гэрээг нэгтгэж, зөвхөн **1 хуудас МАСТЕР ГЭРЭЭ**-г харилцагчтай байгуулдаг болсноор **жилд 1680 боодол бичгийн цаас** хэмнээд зогсохгүй банкнаас нэмэлт үйлчилгээ авах харилцагчдын цаг завыг хэмнэсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа боллоо. Ингэснээр **жил бүр 100 мод** тайрагдахаас сэргийлэгдэх,



түүнчлэн энэ хэмжээний цаасны импортыг бууруулж байгаа юм.
Мөн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ брошур, харилцагчийн сэтгүүлээ байгаль орчинд ээлтэй төдийгүй харилцагчдынхаа үнэт цагийг хэмнэж хүссэн газраасаа **цахимаар унших боломжтой** болголоо. Цаашид ХХБанк цаасны хэрэглээг шат дараатай халж, бүрэн цахим банк болох зорилт тавин ажиллаж байгаа билээ.

## Эрхтэн шилжүүлэн суулгах холбоог дэмжин ажиллаа

ХХБанк нь Монгол улсын эрүүл мэндийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, нийгмийн хариуцлагын зорилтын хүрээнд Эрхтэн шилжүүлэн суулгах Монголын холбоо, ЭМЯ, УНТЭ, Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгалтын холбоо, Солонгосын эрхтэн шилжүүлэн суулгалтын холбоо, Японы эрхтэн шилжүүлэн суулгалтын нийгэмлэг, “Rafael international” байгууллагатай тус тус хамтран зохион байгуулсан Олон улсын II хурлын ивээн тэтгэгчээр оролцлоо. Манай улсын хувьд эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг сүүлийн жилүүдэд маш амжилттай хийж, туршлагажиж байгаа ба энэхүү хуралдааныг “Эрхтэн шилжүүлэн суулгалтын хүний нөөцийг чадваржуулах нь” сэдвээр зохион байгуулж эмч, мэргэжилтэн, судлаачид зэрэг гадаадын 50 орчим зочид төлөөлөгчид оролцож туршлага солилцсон юм.

## Хүүхдэд ээлтэй банк

Хүүхэд бүрийн хүсэн хүлээдэг шинэ жилийн баярыг тохиолдуулан ХХБанк сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд сурч хүмүүждэг 29-р сургуулийн сурагчдыг **13 дахь** жилдээ баярлуулж сургуулийн шинэ жилийн баярт оролцон, инээд хөөр цалгисан нэг өдрийг хамтдаа өнгөрүүлж, 350-иад хүүхдэд шинэ жилийн баярын бэлгээ түгээлээ.
Мөн ХХБанк Улсын тэргүүний Үндэсний



лаборатори 14 дүгээр сургуулийн хөл бөмбөгийн дөрвөн баг тамирчдыг Дуулиан 2020 тэмцээнд **4 жил** дараалан ивээн тэтгэж, дэмжин оролцуулж байна. Ивээн тэтгэсэн хугацаанд 14 дүгээр сургуулийн өсвөрийн хөл бөмбөгчид маань 15 насны ангилалд эрэгтэй баг 2 удаа “Алтан медаль”, эмэгтэй баг “Мөнгөн медаль” тус тус хүртэж, багийн ахлагч Н.Содбилэг “Шилдгийн шилдэг тамирчин” болж, амжилтын буухиа үргэлжилсээр байна. Мөн тус тэмцээнд 2016 оноос эхлэн 2 жил дараалан Нийслэлийн засаг даргын дэргэдэх “Хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор”-ын гурван багийг ивээн тэтгэж оролцуулаад байна.

## Банкны ажилтнууд ОБЕГ-т тусламж үзүүллээ

Ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй Онцгой байдлын ерөнхий газарт банкны ажилтнуудын зүгээс авран хамгаалах ажиллагаанд хэрэглэхэд нь зориулж 10 сая төгрөгийн хандив цуглуулж, иж бүрэн 4-н монгол гэр гардуулан өглөө. Сүүлийн жилүүдэд манай оронд ой хээрийн түймэр, үер усны аюул, ган, зуд зэрэг гэнэтийн аюулт үзэгдэл ихээр тохиолдож, ОБЕГ-ын ажилтнууд гамшгийн бүсэд үйл ажиллагаагаа явуулахад монгол гэр чухал шаардлагатай байдаг тул ХХБанкны ажилтнууд өөрсдийн санаачлагаар сайн үйлсийн аяныг зохион байгуулж, хандив цуглуулснаа ийнхүү хүлээлгэн өглөө.

## Малчдад туслах аян

Монгол улсын ТоС хөтөлбөрийн "Үлгэрлэн манлайлах зарчим"-ын хүрээнд өвөлжилт хүндэрсэн Дархан-Уул, Орхон, Дорнод аймгууд болон Сэлэнгэ аймгийн Хөтөл, Зүүнхараа сумдын малчдад Аймгийн онцгой байдлын комисс, Онцгой байдлын газар болон Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран **821** ширхэг малын нэмнээ, **1050** гаруй төлийн уут, лаа, чүдэнз, бээлий, гар чийдэн баттерэй мөн 2.0 сая төгрөгийн үнэ бүхий хүүхдийн дулаан хувцас, **400** гаруй боодол өвс, **50** гаруй шуудай хивэг зэрэг нийт 10.0 гаруй сая төгрөгийн үнэ бүхий тусламжийн зүйлсийг орон нутгийн салбаруудаараа дамжуулан малчдад хүргэсэн байна.



## Мод услах аян

Байгаль дэлхий, иргэдийн эрүүл мэндэд чиглэсэн ажлыг хэрэгжүүлдэг "Миний клуб"-ийн үйл ажиллагааг дэмжин, банкны ажилтнууд 3 дахь жилдээ мөнгөн хандив цуглуулж, мод услах ажилд гар бие оролцсон. Худалдаа, хөгжлийн банкны хамт олон өмнөх жилүүдэд Багануур дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ суманд мод усалж байсан бол 2017 оны 5-р сард Төв аймгийн Аргалант сумын модны талбайд **8'000** гаруй модыг усалсан байна.



## Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн ахмадуудыг баярлууллаа

Алтан Унжлагат Тахиа жилийн Сар шинийн баяраар Төв аймгийн Батсүмбэр суманд байрладаг Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвөөр зочлон азай буурлуудаа хүндэтгэж, цагаан сарын тавгийн идээ, бусад шаардлагатай зүйлсийг бэлэглэж, ахмад настнуудаа баярлуулсан.

## Нийслэлийн хот тохижилт үйлчилгээний газрын ажилтнуудыг баярлууллаа

Өвлийн хүйтэнд ажил үүргээ үнэнчээр гүйцэтгэж байгаа Нийслэлийн хот тохижилт үйлчилгээний газрын "Шуурхай бүлэг"-ийн 200 гаруй ажилтанд халуун аарцаар үйлчилж, халуун сэтгэлийн өчүүхэн ч гэсэн дэм өгсөн.

## Залуу гэр бүлд тусламж үзүүллээ

СХД-т амьдардаг 21 настай өрхийн тэргүүн, 19 настай эхнэр, 2 настай хүү, 8 сартай охин, хадам ээж, эхнэрийнх нь 2 дүүгийн хамт амьдардаг айлд банкны ажилтнууд сэтгэлийн хандив цуглуулж, тус гэр бүлийн 1 сар хэрэглэх хоол хүнс, хүүхдүүдэд хэрэгтэй байгаа хичээлийн цүнх, бэлэг, мөнгөн хандив зэргийг өгсөн бөгөөд эхнэр болон охин нь хүнд өвчнөөр шаналж байгаа тул өрхийн тэргүүнийг тогтмол ажлын байртай болгох талаар холбогдох шатны байгууллагад хүсэлт гаргасан байна.

## Туул голын сав газрыг 2 дахь жилдээ цэвэрлэлээ

ХХБанк нь Монгол улсын тогтвортой санхүүжилт хөтөлбөрийн хүрээнд Туул голын сав газрын захиргаатай хамтран



“Туул голын сав газрыг цэвэрлэх байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа”-г **2 дахь** жилдээ амжилттай зохион байгуулж, **400** гаруй ажилтан Туул голын дагуу нийт 6 км газраас **900** орчим шуудай хог хаягдлыг цэвэрлэлээ.

## “Green office” төслийн уралдаан зохион байгуулнлаа

Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудын шинэ санал, санаачлага, бүтээлч сэтгэлгээнд тулгуурлан байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй ногоон ажлын байр бий болгох зорилго бүхий “GREEN OFFICE” төслийн уралдааныг зохион байгуулж, шилдэг төслүүдээ шалгарууллаа. Шилдэгээр шалгарсан Цаас дахин боловсруулах”, “Paperless paper”, “SharePoint” төслүүдийг 2018 онд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Тэрбум төгрөг

| Хөрөнгө | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө | 1,054.7 | 695.0 | 1,188.8 | 1,073.9 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 908.7 | 1,412.5 | 1,525.4 | 2,026.3 |
| Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт | 14.5 | 46.8 | 59.5 | 60.8 |
| Зээл ба урьдчилгаа, цэвэр | 2,777.2 | 2,645.0 | 2,835.2 | 2,765.0 |
| Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас | - | 99.8 | - | 12.0 |
| Хоёрдогч зээл | 4.0 | 4.0 | 4.0 | - |
| Үндсэн хөрөнгө, цэвэр | 298.0 | 204.9 | 333.6 | 324.1 |
| Биет бус хөрөнгө, цэвэр | 4.5 | 1.4 | 5.0 | 2.6 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 33.7 | 99.8 | 88.9 | 92.0 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (цэвэр) | 1.0 | 1.4 | 2.2 | 2.8 |
| Эргэлтийн татварын хөрөнгө | 5.7 | - | - | - |
| Бусад хөрөнгө | 311.0 | 333.5 | 602.5 | 515.4 |
| **Хөрөнгийн дүн** | **5,413.2** | **5,544.1** | **6,645.2** | **6,874.9** |

Тэрбум төгрөг

| Өр төлбөр | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 2,533.6 | 2,210.0 | 2,415.5 | 3,070.2 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 120.0 | 112.8 | 143.2 | 243.9 |
| Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас | - | 99.8 | 130.0 | 130.0 |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | 1,107.3 | 1,012.4 | 1,392.2 | 1,068.7 |
| Орлогын албан татварын өглөг | 0.4 | 4.4 | 1.5 | 0.0 |
| Гаргасан өрийн үнэт цаас | 741.4 | 1,175.9 | 1,569.4 | 1,344.6 |
| Бусад өр төлбөр | 279.2 | 231.0 | 209.4 | 142.0 |
| Хоёрдогч өглөг | 75.4 | 29.9 | 24.9 | - |
| **Өр төлбөрийн дүн** | **4,857.2** | **4,876.2** | **5,886.0** | **5,999.4** |
| **Өөрийн хөрөнгө** | **2014** | **2015** | **2016** | **2017** |
| Хувьцаат капитал | 33.2 | 69.3 | 67.7 | 69.3 |
| Дахин үнэлгээний нөөц | 153.6 | 135.3 | 127.0 | 130.0 |
| Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз) | (27.5) | (23.8) | 30.2 | 13.7 |
| Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хуримтлагдсан хэрэгжээгүй олз | - | 39.9 | 14.9 | 72.4 |
| Хуримтлагдсан ашиг | 395.0 | 445.2 | 516.6 | 590.2 |
| **Группын хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт өөрийн хөрөнгө** | **554.3** | **665.9** | **756.4** | **875.5** |
| Цөөнхийн хувь оролцоо | 1.7 | 2.0 | 2.8 | - |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **556.0** | **667.9** | **759.2** | **875.5** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **5,413.2** | **5,544.1** | **6,645.2** | **6,874.9** |

## Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Тэрбум төгрөг

| | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| Хүүний орлого | 444.7 | 532.9 | 593.2 | 612.9 |
| Хүүний зардал | (296.5) | (358.5) | (400.8) | (434.1) |
| **Цэвэр хүүний орлого** | **148.2** | **174.3** | **192.4** | **178.8** |
| Шимтгэл хураамжийн цэвэр орлого | 27.4 | 29.4 | 30.6 | 37.0 |
| Үйл ажиллагааны бусад орлого (цэвэр) | 30.9 | (15.2) | 12.0 | 48.0 |
| **Цэвэр хүүгийн бус орлого** | **58.2** | **14.2** | **42.6** | **85.0** |
| **Үйл ажиллагааны орлого** | **206.4** | **188.6** | **235.0** | **263.8** |
| Үйл ажиллагааны зардал | (68.8) | (91.4) | (92.7) | (89.9) |
| Хараат болон хамтарсан компанийн ашгаас ногдох хувь | 1.1 | 12.6 | 17.3 | 15.9 |
| Эрсдэлийн сангийн зардал | (44.7) | (47.0) | (92.0) | (115.6) |
| **Татварын өмнөх ашиг** | **94.0** | **62.7** | **67.7** | **74.2** |
| Орлогын татварын зардал | (0.5) | (1.3) | (0.2) | (0.4) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | **93.5** | **61.5** | **67.5** | **73.8** |

## Харьцаа үзүүлэлтүүд

Тэрбум төгрөг

| | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| **Ашигт ажиллагаа** | | | | |
| Зардлын орлогод эзлэх хувь | 33.3% | 48.5% | 39.4% | 34.1% |
| Цэвэр хүүгийн зөрүү | 3.9% | 4.1% | 4.3% | 3.9% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 16.9% | 9.2% | 8.9% | 8.4% |
| Активын өгөөж | 1.7% | 1.1% | 1.0% | 1.1% |
| **Өсөлтийн харьцаанууд** | | | | |
| Активын өсөлт | 5.6% | 2.4% | 19.9% | 3.5% |
| Зээлийн өсөлт | 9.7% | -4.8% | 7.2% | -2.5% |
| Харилцах, хадгаламжийн өсөлт | 18.4% | -12.8% | 9.3% | 27.1% |
| Өөрийн хөрөнгийн өсөлт | 50.9% | 20.1% | 13.6% | 15.8% |
| **Активын чанар** | | | | |
| Зээл / Харилцах, хадгаламж | 111.9% | 124.1% | 123.7% | 98.8% |
| Зээлийн актив эзлэх хувь | 52.4% | 49.5% | 45.0% | 44.1% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар | 41.3% | 44.4% | 47.1% | 45.7% |
| **Өөрийн хөрөнгийн харьцаа** | | | | |
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ | 13.0% | 12.3% | 11.2% | 14.0% |
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээ | 19.2% | 16.7% | 14.6% | 17.0% |

2017 онд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 229.7 тэрбум төгрөг буюу 3.5 хувиар өсч 6’874.9 тэрбум төгрөгт хүрсэн бол хөрөнгө оруулалтын үнэт цаас 32.8 хувиар өсч 2’026.3 тэрбум төгрөгт, зээл ба урьдчилгаа (цэвэр) 2.5 хувиар буурч 2’765.0 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

Нийт өр төлбөрийн дүн өмнөх оноос 1.9 хувиар өсч 5’999.4 тэрбум төгрөгт хүрснээс харилцагчдын харилцах, хадгаламжийн дүн 27.1 хувиар өсч 3’070.2 тэрбум төгрөгт, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн дүн 23.2 хувиар буурч 1’068.7 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Өөрийн хөрөнгийн хувьд өмнөх онтой харьцуулахад 15.3 хувиар өсч 875.5 тэрбум төгрөгт хүрснээс хуримтлагдсан ашиг 14.2 хувиар буюу 73.6 тэрбум төгрөгөөр өсч 590.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2017 онд хүүгийн орлого 3.3 хувиар өсч 612.9 тэрбум төгрөгт, хүүгийн зардал 8.3 хувиар өсч 434.1 тэрбум төгрөгт хүрснээр цэвэр хүүний орлого 178.8 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант жилд үйл ажиллагааны орлого 263.8 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 73.8 тэрбум төгрөгийн дүнтэй гарчээ.

**Нийт хөрөнгө**




**Зээл ба урьдчилгаа (цэвэр)**




**Харилцагчдын харилцах, хадгаламж**




**Өөрийн хөрөнгө**




**Үйл ажиллагааны орлого**




**Тайлант жилийн цэвэр ашиг**





# ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

*ХХБанк нь 2017 онд ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг дэмжих, зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшуулал олгох, сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан урт хугацаанд тогтвортой, бүтээлч, бүтээмж өндөртэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллалаа.*

# ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА



2017 онд хөдөлмөрийн зах зээлээс шинээр 265 ажилтныг сонгон шалгаруулж ажлын байраар хангасан бол ажилтнуудын карьер хөгжлийг дэмжих үүднээс банкинд нээлттэй байгаа ажлын байрны 50 хувийг дотоод эх үүсвэрээс сонгон шалгаруулсан ба нийт ажилтнуудын 10% дэвшин томилогдож, карьераа өсгөсөн байна.

**Ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр**

Банкны мэргэшсэн сургагч багш нар хамтран нийт 215 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд гадаад, дотоодын сургалтын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллалаа. Ийнхүү 2017 онд давхардсан тоогоор 5'600 гаруй ажилтныг сургалтад хамруулж, мэдлэг ур чадварыг нь нэмэгдүүлэх, хөгжих боломжоор хангасан юм.

Түүнчлэн:

- Хувь хүний хөгжлийн нээлттэй сургалтуудыг зохион байгуулж, Barclays, Bank of Tokyo Mitsubishi зэрэг олон улсын банк, санхүүгийн салбарт тэргүүлэгч байгууллагын ажилтнуудыг урьж, олон улсын туршлага солилцох, мэдлэгээ хуваалцах арга хэмжээг амжилттай зохион байгуулан, нийт 600 орчим ажилтнууд хамрагдлаа.

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэнгүүдийг бэлтгэх зорилгын хүрээнд Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч, Certified Retail Banker, мэдээллийн технологийн чиглэлээр ISACA-CISA буюу мэдээллийн технологийн системийн аудитор болон бусад чиглэлүүдийн хүрээнд чадварлаг мэргэжилтэнгүүдийг амжилттай бэлтгэлээ. Тухайлбал, Лондон дахь олон улсад өндөр нэр хүндтэй "Retail Banking Academy"-ийн Certified Retail Banker сургалтын 3-н түвшинг Монгол улсаас анх удаа ХХБанкны менежер Н.Энхзуун амжилттай дүүргэж, Мэргэшсэн банкир болсон юм.

- Мөн ажилтан бүр өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн, "Дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, мэргэжил дээшлүүлж буй болон бусад сургалтад хамрагдаж байгаа ажилтнуууддаа төлбөрийн буцаалтыг олголоо.

**Цалин урамшуулал, нийгмийн халамжийн чиглэлээр**

ХХБанк нь чадварлаг мэргэшсэн боловсон хүчнийг тогтоон барих, ур бүтээлтэй ажиллах хүсэл эрмэлзэлийг төрүүлэхэд түлхэц болгохуйц цалин, урамшууллыг олгох зорилтын хүрээнд 2017 оны 9-р сарын 1-ний өдрөөс нийт ажилтнуудынхаа цалинг нэмлээ.

Ажилтнуудын идэвхийг өрнүүлэх чухал хэрэгслийн нэг болох материаллаг бус урамшууллын хэлбэрийг ашигласнаар нийт ажилтнуудын 20 хувь нь төрийн болон бусад байгууллагын шагналаар шагнагдсан байна.

Мөн тайлант онд ажилтнуудын эрүүл мэндийн асуудлыг дэмжих ажлын хүрээнд хамтын ажиллагаатай эмнэлэгүүдтэй хамтран эрүүл мэндийн өдөрлөгүүдийг зохион байгууллаа.

# 02

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




# ИРГЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

*ХХБанк нь тайлант онд иргэдэд зориулсан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, өгөөжийг сайжруулан, үйлчилгээний хурд, хүртээмжийг нэмэгдүүлэх, зайнаас банкны үйлчилгээг хүргэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллалаа. Тайлант онд иргэдийн банкны зах зээлд үзүүлсэн амжилт ололтоосоо танилцуулж байна.*

ХХБанк нь тайлант онд иргэдэд зориулсан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, өгөөжийг сайжруулан, үйлчилгээний хурд, хүртээмжийг нэмэгдүүлэх, зайнаас банкны үйлчилгээг хүргэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллалаа. Тайлант онд иргэдийн банкны зах зээлд үзүүлсэн амжилт ололтоосоо танилцуулж байна.

**Банкны үйлчилгээг газар дээр нь үзүүлэх eReg бүртгэлийн аппликейшныг амжилттай нэвтрүүллээ.**

Банкны үйлчилгээг хөдөлгөөнт байдлаар харилцагчийн байгаа газарт нь хүргэж үйлчлэх, аливаа өдөрлөг, арга хэмжээн дээр харилцагчийг бүртгэх, банкны үйлчилгээг үзүүлэх зорилгоор банкны суурь бүртгэлийн программтай холбогдсон eReg аппликейшныг зах зээлд туршин нэвтрүүллээ. eReg аппликейшн нь дурын ухаалаг утас, таблет төхөөрөмжүүдэд суулган ашиглах боломжтой тул харилцагчийн бүртгэл хийхийн тулд тухайн байршилд сүлжээ татах, нүсэр компьютерууд зөөвөрлөх шаардлагагүй болж, банкны бүртгэл хийх, данс нээх, цахим үйлчилгээнд бүртгэх зэрэг үйлчилгээнүүдийг амжилттайгаар хүргэх боломжтой боллоо. Ингэснээр орон зай цаг хугацаанаас үл хамааран харилцагчиддаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд бүртгэх боломжтой болсон.

**Зээлийн батлан даалтын сантай хамтран жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгож эхэллээ.**

Азийн хөгжлийн банк, Зээлийн батлан даалтын сантай хамтран "Эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг дэмжих" зорилгын хүрээнд урт хугацаатай, бага хүүтэй төслийн зээл олгох гэрээг байгуулж, уг зээлийг зах зээлд анхлан нэвтрүүллээ. Энэ гэрээ байгуулагдсанаар ХХБанк нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх зорилгоор 10 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 12-15 хувийн хүүтэй зээл олгох таатай нөхцөл бүрдэж байгаа юм. Уг төсөл нь зээлийн барьцаа хөрөнгө дутагдалтай харилцагчдад Зээлийн батлан даалтын сангаас шаардлагатай зээлийн 60% хүртэл дүнд баталгаа гаргаснаар эдгээр харилцагчид банкнаас төслөө хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээ авах боломжтой болсон төдийгүй уг зээл нь арилжааны банкны зээлээс илүү урт хугацаатай, бага хүүтэй гэдгээрээ илүү онцлогтой билээ.




**Монгол Улсын Засгийн Газар, Монголбанкнаас хамтран хэрэгжүүлж буй 8 хувийн орон сууцны зээлийн хөтөлбөрийн хүрээнд үнэт цаасжуулах үйл ажиллагааг дэмжин ажиллаа.**

2017 онд жилийн 8 хувийн хүүтэй ипотекийн орон сууцны зээлийн хөтөлбөрийн хүрээнд 4 удаагийн хэлцлээр 170.6 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийн багцыг МИК ОССК ХХК-д худалдаж үнэт цаасжуулсан байна.

**Visa payWave технологи бүхий олон улсын Алтан кредит карт, Лейди премиум кредит картыг анх удаа зах зээлд нэвтрүүллээ**

ХХБанк олон улсын Алтан кредит, бүсгүйчүүдэд зориулан 100 гаруй байгууллагаар хөнгөлөлт эдлэх боломжтой Лейди премиум кредит картаа шинээр зах зээлд нэвтрүүлэхдээ Visa International байгууллагатай хамтран төлбөрийн картаа зайнаас мэдрэх Visa payWave технологийг Монгол Улсад анх удаа нэвтрүүлсэн юм. Энэхүү технологийг нэвтрүүлснээр төлбөр тооцоо урьд урьдынхаасаа илүү шуурхай, найдвартай хийгдэх ач холбогдолтойгоос гадна ХХБанкны харилцагчид дэлхийн хаана ч очсон Visa payWave технологиор худалдан авалтаа хийх боломж, гарцыг нээж өгч байгаа юм. Үүгээр ч зогсохгүй, Монгол Улсад ирсэн гадаадын иргэд ХХБанкны карт уншигч машинтай аль ч худалдаа, үйлчилгээний газарт payWave технологи ашиглан өөрийн картаараа худалдан авалтаа хийх боломжтой. Энэ нь Монгол Улсын төлбөр тооцооны технологийн хөгжлийг дахин нэг шат урагшлуулж буй нэр хүндтэй үйл явдал болсон байна. Энэ ч үүднээс Visa International

байгууллага 2017 оны "Бүтээгдэхүүний Шилдэг Инноваци" шагналаар Худалдаа, хөгжлийн банкны Visa payWave технологийг шингээсэн Алтан кредит картыг шалгарууллаа.



## TDB Pay үйлчилгээгээ зах зээлд амжилттай нэвтрүүллээ.

Зах худалдааны төв, цэцэрлэгт хүрээлэн, ТҮЦ, мухлаг, интернэт худалдаа, хүргэлт гээд төлбөр тооцоо хийгддэг хаана ч ашиглагдаж болох, хамгийн тохиромжтой төлбөрийн шийдэл болох TDB Pay үйлчилгээг ХХБанк зах зээлд амжилттай нэвтрүүлсэн билээ. TDB Pay үйлчилгээ нь QR код ашиглан дансандаа төлбөр хүлээн авах, шилжүүлэх, худалдаа төлбөр тооцоогоо хийх шуурхай үйлчилгээ бөгөөд QR кодоор төлбөр төлөх боломжтой бүх банкны аппликейшнаар худалдан авалтаа хийх боломжтой юм. Нэвтрүүлсэн даруйдаа худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн хэрэгцээг бүрэн хангаж, 30'000 гаруй бизнес эрхэгч TDB Pay үйлчилгээгээр төлбөр тооцоогоо хийж байгаа бол энэ тоо цаашид ч улам эрчтэй өсөх хандлагатай байгаа билээ.

## "MoneyGram self-service" үйлчилгээг бүрэн нэвтрүүллээ.

ХХБанк нь харилцагчиддаа цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 24 цагийн турш шуурхай мөнгөн гуйвуулгаа хийх боломжийг бүрдүүлж, олон улсын хувийн гуйвуулга MoneyGram self-service үйлчилгээг нэвтрүүллээ. Ингэснээр харилцагч гар утас, компьютер, таблет төхөөрөмж ашиглан ХХБанкны TDB Online цахим үйлчилгээ, мөн ATM-аар хаанаас ч, хэзээ ч гүйлгээгээ хийх боломж бүрдэж, цагийн бүсийн зөрүүнээс үүдэлтэйгээр ажлын бус цагаар гадаад улс руу хувийн гуйвуулга хийх хэрэгцээ бүхий харилцагчид банкны салбар ажиллахыг хүлээлгүйгээр мөнгөн гуйвуулга өөрөө хийх, хүлээн авах боломжтой боллоо.



## "Junior customer"-уудаа 5 дахь жилдээ хүндэтгэн, хүлээн авлаа.

18 настай харилцагчиддаа зориулж Зорилго, тэмүүлэлд хөтлөх "Junior Customers" арга хэмжээгээ 6-р сарын 2-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хүүхдийн хадгаламж эзэмшигчиддээ хүндэтгэл үзүүлдэг энэхүү уламжлалыг бий болгоод 5 дахь жилтэйгээ золголоо. "Junior Customers" арга хэмжээнд ХХБанкны Гүйцэтгэх захирлын орлогч Л.Соронзонболд хүрэлцэн ирсэн залуустаа санхүүгийн мэдлэг, мэдээлэл өгч, урилгаар Сант сургуулийн захирал З.Энхмөнх, бүжигчин Т.Саруултөгс нар мэргэжил боловсрол эзэмших болон зорилгодоо тууштай байх тухай сонирхолтой илтгэлийг тавьсан юм.



**Даатгалын зуучлалын үйлчилгээг амжилттай хүргэж байна.**

Банкаар үйлчлүүлэнгээ аливаа даатгалд хамрагдах боломжийг бүрдүүлж ХХБанк нь нэр хүнд бүхий даатгалын компаниудын бүтээгдэхүүнийг харилцагчиддаа хөнгөлөлттэй нөхцөлөөр зуучлан хүргэдэг билээ. Тайлант онд даатгалын үйлчилгээг илүү бага хураамжаар хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд хураамжаа хэсэгчлэн төлөх боломжийг бүрдүүллээ.

**Мөн дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар үзүүлж эхэллээ:**

- Харилцагч TDB Online цахим үйлчилгээг ашиглан өөрөө харилцах, хадгаламжийн дансаа нээх, хадгаламжийн хугацаагаа сунгах, хугацааны эцэст шилжих бүтээгдэхүүнийг сонгодог болсон.

- Тогтмол шилжүүлгийн үйлчилгээнд TDB Online цахим үйлчилгээ болон банкны 1900-1977 лавлах утсаар холбогдон бүртгүүлэх, хугацаагааа сунгах боломжтой болсон юм.

- ХХБанкаар дамжуулан авсан даатгалын үйлчилгээгээ цахимаар хянах боломжийг нэвтрүүллээ.

- Сошиал сувгаар харилцагчийн асуулт хариултад автоматаар хариулт өгөх AI технологид суурилсан TDB Bot үйлчилгээг банкны салбарт анх удаа нэвтрүүллээ.

## *ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД БОЛОН ХАРИЛЦАГЧДЫНХАА САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭРЭГЦЭЭТЭЙ ЗӨВЛӨМЖ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ.*

**Өнөөдрийн хуримтлал, маргаашийн ирээдүй” сургалтыг 4 дахь жилдээ зохион байгууллаа**

Жил бүрийн 3 дугаар сард тохиодог “Global Money Week” буюу Хүүхэд залуучуудад санхүүгийн боловсрол олгох олон улсын хөдөлгөөнд 4 жил дараалан оролцож “Өнөөдрийн хуримтлал – Маргаашийн ирээдүй” сэдвийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 2’000 гаруй сурагчдад сургалт, мэдээлэл хүргэлээ.

**Санхүүгийн боловсролын аян”-д оролцон Санхүүгийн боловсролыг дэмжигч банкаар шалгарлаа**

Монголбанкнаас санаачлан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд зарласан “Санхүүгийн боловсролын аян”-д ХХБанк манлайлан оролцож, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 2’000 гаруй сурагчдад санхүүгийн мэдлэг олгох анхан шатны сургалт, их дээд сургуулийн 600 гаруй оюутан залууст хуримтлал, хувийн санхүү, даатгал, үнэт цаасны талаарх мэдлэг олгох ахисан түвшний сургалт, харилцагч байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан өдөрлөг, уулзалтуудыг тус тус зохион байгуулж, Санхүүгийн боловсролыг дэмжигч банкаар шалгарлаа.

**Дэлхийн хадгаламжийн өдрийг 6 дахь жилдээ тэмдэглэн өнгөрүүллээ**

Дэлхийн Хадгаламжийн Өдөр”-ийг 6 дахь жилдээ харилцагчидтайгаа тэмдэглэн өнгөрүүлж, Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны Олон улсын хамтын ажиллагааны сан хамтран зохион байгуулсан “Дэлхийн хуримтлалын өдөр” нэвтэй арга хэмжээ, “Таны санхүүгийн боловсролд: Мөнгөө хэрхэн зөв удирдах вэ?” сэдвт санхүүгийн боловсрол олгох лекц, нэвтэй арга хэмжээнүүдээд оролцон, харилцагчдад газар дээр нь данс нээх, онлайн үйлчилгээнд бүртгэх, карт захиалах үйлчилгээг үзүүлж, 800 гаруй харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, хуримтлалын мэдээллийг хүргэж, түрүүлж данс нээлгэсэн 5 хүүхдэд хүүхдийн хадгаламжийн гарын бэлгийг гардууллаа.



# БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

*Тайлант онд байгууллагын бизнесийн зах зээлд тэргүүлэгч ХХБанк нь үйлдвэрлэл, барилга, уул уурхай, худалдаа, эрчим хүч, харилцаа холбоо, боловсруулах үйлдвэрлэл, эрүүл мэнд, боловсрол, аялал жуулчлал, хөдөө аж ахуй гэх мэт Монгол Улсын хөгжлийг тодорхойлогч бүхий л салбаруудад санхүүгийн түргэн шуурхай, найдвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ажиллалаа.*

2017 онд эдийн засгийн нөхцөл байдлын хувьд таатай бус, сорилтын жил байсан хэдий ч банк өөрийн харилцагчдад бага хүүтэй, урт хугацаатай зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, тэдгээрийг дэмжих зорилтын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/, Азийн хөгжлийн банк /ADB/, Солонгос /KEXIM/ болон Тайваний /TEXIM/ экспорт, импортын банк, Коммерз банк зэрэг гадаад, дотоодын 30 гаруй банк, санхүүгийн байгууллагын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, оны эцсийн байдлаар дээрх банк, санхүүгийн байгууллагуудаас зээлийн эх үүсвэр хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 1'068.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ХХБанк хямд өртөгтэй бүхий л төрлийн эх үүсвэртэй зээлийг харилцагчдад санал болгосоноор харилцагч байгууллагуудад санхүүгийн зардлаа бууруулж, төлбөрийн чадвараа нэмэгдүүлж, бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжийг бүрдүүлж, үүний үр дүнд харилцагчид эдийн засгийн хүндрэлтэй жилийг амжилттай давж чадлаа.

2017 онд бид зах зээл дээрх тэргүүлэгч байр сууриа хадгалж, амжилттай ажилласнаар банкны том болон жижиг, дунд сегментийн хөрөнгө 2.4 их наяд төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байлаа.

Том болон жижиг, дунд зээлийн нийт үлдэгдэл /тэрбум төгрөг/




Улс орны хөгжил дэвшилд өндөр ач холбогдол бүхий төр засгийн бодлогыг амжилттай хамтран хэрэгжүүлэгч банкны хувьд ХХБанк нь 2017 онд Монгол Улсын Хөгжлийн банкны хэрэгжүүлсэн "Мах хөтөлбөр"-ийн хүрээнд 5.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, ХХААХҮЯ-с хэрэгжүүлсэн "Өвөлжилт хүндэрсэн орон нутгаас мал, мах худалдан авах" хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд бэлтгэх 15,800.0 тонн махнаас 9,638.0 тонн буюу 61%-ийг бэлтгэхэд зориулж 38.4 тэрбум төгрөгийн дүнтэй хүүний хөнгөлөлттэй зээлийг өөрийн харилцагчдад тус тус олгосон.

Мөн онд ХХБанк Оюу Толгой компанийн бэлтгэн нийлүүлэгчдийн санхүүгийн хэрэгцээг хангах зориулалтаар бэлтгэн нийлүүлэгчдийн зээл, зээлийн шугамын бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж, нийт 40 гаруй бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгжүүдэд 12.3 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

Банкны олон улсын болон дотоодын зах зээл дээрх нэр хүнд, харилцагч иргэд, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, зөв зохистой удирдлага, багийн амжилттай ажиллагааны үр дүнд 2017 онд том болон жижиг, дунд харилцагчдаас олсон зээлийн хүүний орлого 293.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Том болон жижиг, дунд зээлийн хүүгийн орлого /тэрбум төгрөг/




2018 онд ХХБанк нь зах зээлд тэргүүлэгч байр сууриа бататгаж, харилцагчдад банкны уламжлалт болон уламжлалт бус бүх төрлийн дэвшилтэт, цогц бүтээгдэхүүн үйлчилгээг, чанартай, түргэн шуурхай хүргэж ажиллахын зэрэгцээ байгаль орчинд ээлтэй, нийгэм, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөллийг үзүүлэх төсөл хөтөлбөрүүдэд онц ач холбогдол өгч, дэмжиж ажиллах болно.




# ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА

### Валютын зах зээл

ХХБанк нь тайлант онд дотоодын валютын зах зээл дээрх нийт арилжааны 30 орчим хувийг дангаар гүйцэтгэн, тэргүүлэх байр сууриа хадгалан ажиллалаа. Хэдийгээр Монгол Улсын гадаад зээлжих зэрэглэл буурч, хөрөнгө оруулалтын эрсдэл нэмэгдсэнтэй холбогдуулан олон улсын санхүүгийн байгууллагууд дотоодын арилжааны банкуудтай хийх валют арилжааны хэмжээгээ хязгаарлаж эхэлсэн ч тайлант онд гадаад валютын арилжааны шугам, харилцагч банкуудын тоог нэмэгдүүлэх зорилт тавин ажилласаны хүрээнд дахин 2 олон улсын банктай шинээр харилцаа тогтоон, валют арилжааны мастер гэрээг байгуулсан. Ингэснээр бүх төрлийн чөлөөт хөрвөх валютуудаар арилжаа хийх боломжтой харилцагч банкны тоо нэмэгдсэний зэрэгцээ, рублийн арилжааг харилцагч банктай 24 цагаар хийх боломж бүрдсэн нь харилцагчдад цагийн зөрүүнээс үл хамааран арилжаа хийх давуу талыг бий болголоо. Түүнчлэн, Монголбанкнаас санаачлан ашиглалтанд оруулсан банк хоорондын цахим арилжааны системд нэгдэж, анхны үндсэн дилерийн эрхтэй банкаар сонгогдсон ба банк хоорондын цахим арилжааны системд харилцагчдыг зуучлан оролцуулах боломжийг бүрдүүллээ.

### Мөнгөний зах зээл

ХХБанк нь тайлант онд Монголбанкнаас тогтоодог зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган, мөнгөний зах зээл дэх өөрийн байр сууриа хадгалахын зэрэгцээ, олон улсын мөнгөний зах зээлд идэвхтэй ажилласан жил боллоо. Хэдийгээр тайлант онд гадаад зах зээл дэх хүүний түвшин дотоод зах зээлээс бага байсан ч гадаад харилцаагаар тэргүүлэгч банкны хувьд олон улсын томоохон арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр харилцан хадгаламж байршуулах, сул чөлөөтэй гадаад валютын эх үүсвэрийг өндөр өгөөж бүхий богино хугацаатай, эрсдэл багатай актив хөрөнгө оруулан хүүний орлогыг нэмэгдүүллээ.



### Актив пассивын удирдлага

Тайлант онд түүхий эдийн үнийн өсөлт болон ОУВС-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн нөлөөгөөр улсын ДНБ-ний өсөлт 2016 оноос өндөр гарсан хэдий ч уул уурхайгаас бусад салбарын бизнесийн орчны эрсдэл өндөр хэвээр хадгалагдсан жил байлаа. Гэсэн хэдий ч харилцагчдынхаа бизнесийн эрэлтийг хангахын сацуу зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг зөв хэрэгжүүлсний үр дүнд нийт харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 27.1 хувиар өссөн нь банкны нэр хүнд, харилцагчдын банкинд итгэх итгэл нэмэгдсэний илэрхийлэл болсон. Түүнчлэн банкны дунд болон урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага, хүүгийн эрсдэлийн удирдлага, балансын зохистой бүтцийн удирдлага, төлөвлөлт зэрэг үндсэн үйл ажиллагааны тооцоолол, аргачлалыг сайжруулан, мэдээллийн түвшинд бүрэн автоматжуулалт хийсэн нь томоохон шинэчлэл болсон юм.

### Кастодиан үйлчилгээ

Монгол Улсад кастодиан банкны үйл ажиллагааг анхлан нэвтрүүлэгч ХХБанк нь тайлант онд цахим банкны үйлчилгээг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын санд үзүүлэх үйлчилгээг сайжруулах болон гадаад харилцаагаа тэлэх зорилготой ажиллалаа. Тус зорилгын хүрээнд үнэт цаасны компаниудтай хийх "Үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэх гэрээ"-г шинэчилж, программ хангамжийг сайжруулан, үнэт цаасны компанийн харилцагчдыг онлайн үйлчилгээг ашиглан, зайнаас данс хооронд мөнгө шилжүүлэх боломжийг нээж өглөө.
Мөн Санхүүгийн зохицуулах хорооны дугаар 235 тоот тогтоолоор "Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх нэмэлт" тусгай зөвшөөрлийг авсан анхны кастодиан банк болж, олон улсын нэр хүнд бүхий кастодиан банкуудтай хамтран ажиллаж эхэллээ.



# ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Худалдааны санхүүжилт, гадаад төлбөр тооцоо

ХХБанк нь Монгол Улсын гадаад худалдааны төлбөр тооцооны дийлэнх хувийг дангаар гүйцэтгэж ирсэн туршлагатай банкны хувьд тайлант онд Монгол улсын нийт гадаад худалдааны төлбөр тооцооны 57%-ийг дангаар гүйцэтгэж, зах зээлд тэргүүлэгч байр суурьа бататгаж ажиллалаа. Олон улсад нэр хүнд бүхий 52 банк, санхүүгийн байгууллагуудаас 701.2 сая ам.долларын худалдааны санхүүжилтийн шугам батлуулан, 754.9 тэрбум төгрөгийн эх үүсвэргүй аккредитив, баталгаа нээж, байгууллагуудын импортын аккредитив, давхар баталгаа, гадаад худалдааг санхүүжүүлэх импортын зээл хэлбэрээр харилцагч иргэд, байгууллагуудын худалдан авалт, ажил үйлчилгээ, мөнгөн урсгал, санхүүгийн чадамжийг нь дэмжиж ажиллалаа.

Мөн олон улсын нэр хүнд бүхий 150 гаруй банк болон санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, өндөр зэрэглэлийн 31 банкинд нээлгэсэн 15 төрлийн валютын 45 ностро дансаар дамжуулан харилцагчийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэж ажиллалаа.

### ОХУ-ын томоохон арилжааны банкуудтай гадаад худалдааны санхүүжилтийн гэрээ байгууллаа

ХХБанк 2017 онд ОХУ-ын ВТБ банк, Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банк, Транскапиталбанк, Промсвязьбанк зэрэг томоохон арилжааны банкуудтай худалдааны санхүүжилтийн зээлийн гэрээг байгууллаа. Эдгээр санхүүжилтийн гэрээнүүдийг байгуулснаар банкуудын харилцаа холбоо өргөжих, хамтын ажиллагааг улам бэхжүүлэх суурийг тавьж, ОХУ болон Монгол улсын хоорондох экспорт болон импортын хэмжээг нэмэгдүүлэх, хоёр улсын хооронд худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийг дэмжин бага хүүтэй, урт хугацаат санхүүжилт олгох боломж бүрдэж байна.

### China Construction Bank (CCB)-тай хамтран гадаад худалдааны санхүүжилт олгож эхэллээ

БНХАУ-ын China Construction Bank (CCB) нь Хятад улсын барилгын салбарыг санхүүжүүлэгч хамгийн том банк бөгөөд ХХБанктай 2007 оноос эхлэн төгрөг, юанийн төлбөр тооцооны чиглэлээр хамтран ажилласаар ирсэн. ХХБанк болон CCB банкууд гадаад худалдааг санхүүжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа




цаашид өргөжүүлэхээр 2017 оны 8-р сард "Гадаад худалдааг дэмжих зээлийн гэрээ байгуулах" санамж бичигт гарын үсэг зурснаар 2017 оны 12-р сард тус банкнаас ХХБанкинд зээлийн шугамын лимит батлагдлаа. Уг зээлийн шугамын хүрээнд форфэйтинг, БНХАУ-ын экспортын санхүүжилтийн зээл, баталгаа дамжуулах, худалдааны санхүүжилтийн зээл олгох бөгөөд гадаад худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгох боломж дахин нэгээр нэмэгдлээ.

### Хятад-Монголын Санхүүгийн Хамтын Ажиллагааны Холбоо

БНХАУ-ын Баошан банкны санаачилгаар БНХАУ-ын 27 банк, санхүүгийн байгууллагууд Монгол Улсын талаас ХХБанк тэргүүтэй арилжааны 6 банкууд хамтран 2017 оны 9-р сарын 26-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод "Хятад-Монголын Санхүүгийн Хамтын Ажиллагааны Холбоо"-г үүсгэн байгуулсан.

"Хятад-Монголын Санхүүгийн Хамтын Ажиллагааны Холбоо"-ны үйл ажиллагаагаар дамжуулан Монгол улсад хэрэгжиж буй томоохон төсөл хөтөлбөрүүд, бүтээн байгуулалтын ажлуудад санхүүжилт, хөрөнгө оруулалт татах, уул уурхай, дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг хамтран санхүүжүүлэх боломжтой болж байгаа юм.



**БНХАУ-ын Хөдөө Аж Ахуйн Банктай "Харилцан Ойлголцлын Санамж бичиг"-т гарын үсэг зурж, ам.долларын төлбөр тооцоог өргөжүүлэх гарцыг нээлээ**

ХХБанк болон Хятадын Хөдөө Аж Ахуйн Банк (Agricultural Bank of China) –ууд ам.долларын төлбөр тооцооны үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор 2017 оны 10-р сарын 13-нд "Хамтран Ажиллах Санамж бичиг"-т гарын үсэг зурсны дагуу тус банкны ам.долларын дансыг ХХБанкинд нээсэн бөгөөд уг дансаар хийгдэх гүйлгээгээр дамжуулан Монгол Улс руу чиглэх ам.долларын урсгал нэмэгдэх боломжтой болж байгаа өндөр ач холбогдол бүхий үйл явдал боллоо.

**Хамтарсан төслийн зээлүүд амжилттай үргэлжилж байна**

ХХБанк нь Азийн хөгжлийн банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA), Японы Олон улсын хамтын ажиллагааны Банк (JBIC), Германы КФВ банкны төслийн зээлийн хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүдэд бизнесээ өргөтгөж, цар хүрээгээ тэлэхэд нь нэн шаардлагатай санхүүжилтийг олгож, дотоодод төдийгүй экспортод бүтээгдэхүүнээ гаргахад нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Тухайлбал, JICA-гийн хоёр үе шаттай төслийн зээлийн санхүүжилтээр ХХБанк нийт 130 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд 47.0 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилтийг олгож, 2500 гаруй ажлын байр шинээр бий болгосон бодит хувь нэмрийг нийгэм эдийн засагтаа оруулсан байна. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд 2017 онд нийт 37.0 тэрбум төгрөгийн зээлийг батлан, харилцагчдын төслүүдийг санхүүжүүллээ.

**Токио дахь төлөөлөгчийн газраараа дамжуулан Япон улсаас Монгол Улсад хийх хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлж, Японы харилцагчидтай явуулж буй бизнес харилцааг эрчимжүүллээ**

ХХБанкны Токио хот дахь төлөөлөгчийн газар нь Япон улсаас Монгол Улсад хийгдэх хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэхийн тулд Японы Эдийн Засаг Үйлдвэрийн Яамны харъяа "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих нэгдэл", "Жижиг дунд үйлдвэрийн дэд бүтцийг хөгжүүлэх байгууллага" болон "Хилийн чанад дахь аж үйлдвэрийн хүний нөөцийг хөгжүүлэх холбоо"-ноос олгодог буцалтгүй тусламжуудыг ашиглан, Японы жижиг дунд бизнес эрхлэгчдийг Монголын зах зээлд гаргах, бүтээгдэхүүний борлуулалтын сувгийг нээхэд дэмжлэг үзүүлэн амжилттай хамтран ажиллаж, Япон харилцагчдад банкны иж бүрэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж эхэллээ.

**Европын холбооны Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын төлбөр тооцоог дамжуулагч банкаар сонгогдлоо**

ХХБанк нь Европын холбооны Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын төлбөр тооцоог дамжуулагч банкийг сонгон шалгаруулах тендерт ялалт байгуулж, банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх банкаар сонгогдсноор Монгол Улс болон Европын холбоотой хийх түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр хүчин төгөлдөр болж буй энэ цаг үед Европын холбооны Монгол Улс дахь төлөөлөгчийн газраар дамжин явуулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэвшилтэт, иж бүрэн үйлчилгээг үзүүлэх боломжтой боллоо.





# ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК

*ХХБанкны охин компани болох Ти Ди Би Капитал ҮЦК ХХК нь харилцагчдынхаа бизнесийн өсөлт болон санхүүгийн зах зээлд оролцох идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор корпорацийн санхүүжилт, үнэт цаасны зуучлал, мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл зэрэг олон улсын жишигт нийцсэн хөрөнгө оруулалтын банкны цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэн ажиллаж байна.*

## Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа

Ти Ди Би Капитал ҮЦК ХХК нь нэр хүнд бүхий олон улсын хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран ажилладаг туршлага дээрээ үндэслэн үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүд, хувьцаа, бонд, өрийн хэрэгслийг нээлттэй болон хаалттай зах зээлд гарган санхүүжилт татах, компанийг өөрчлөн байгуулах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлж байна. Тайлант онд харилцагчдынхаа нийт 270.0 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийн төсөлд зөвлөхөөр ажиллалаа.

## Үнэт цаасны зуучлалын үйл ажиллагаа

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн санхүүгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд бодит хувь нэмрийг оруулж буй “Ти Ди Би Брокер” онлайн арилжааны систем нь харилцагчиддаа Монголын хөрөнгийн биржийн арилжаанд цаг хугацаа, орон зайг үл харгалзан дэлхийн аль ч өнцгөөс, хүссэн газраасаа арилжаанд шууд оролцох, үнэт цаасны дансаа хянах боломжийг олгодог бөгөөд 2017 онд онлайн арилжааны системийн хөгжүүлэлтийг үргэлжлүүлэн, үнэт цаасны төлбөр тооцооны мөнгөн хөрөнгийн данснаас зарлага гаргах үйл ажиллагааг хялбаршуулж, харилцагчдын мөнгө хүсэх өргөдлийг онлайнаар авах үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүллээ. Мөн ХХБанкны TDB Online цахим үйлчилгээгээр дамжуулан үнэт цаасны арилжаанд гар утаснаасаа оролцох боломжийг бий болгосон нь харилцагчдын цаг завыг хэмнэх дэвшилтэт технологи боллоо.

Үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)




Монголын хөрөнгийн бирж Хувьцааны арилжаа




Ти Ди Би Капитал ҮЦК ХХК нь дотоодын хөрөнгийн зах зээлийн тэргүүлэх оролцогчдын нэг бөгөөд 2017 онд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 89.4 тэрбум төгрөгийн арилжааг хийж, хувьцааны арилжааны 49.4 хувийг дангаар гүйцэтгэлээ.



# ТИ ДИ БИ ЛИЗИНГ ХХК

*"Ти Ди Би Лизинг" ХХК нь харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурласан, бизнесийн таатай нөхцөлийг хангах санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор ХХБанк, Ти Ди Би Капитал ҮЦК ХХК болон Япон улсын Эм Жи Лизинг Корпорацийн хамтарсан хөрөнгө оруулалттайгаар байгуулагдаж, 2013 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.*

Ти Ди Би Лизинг ХХК нь Япон улсын Эм Жи Лизинг Корпораци болон ХХБанк, түүний санхүүгийн үйлчилгээний дэд бүтцийн харилцан хамтын ажиллагаанд тулгуурласан бүтээлч, шинийг санаачлагч Санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг компани бөгөөд 2017 онд 44.0 тэрбум төгрөгийн санхүүгийн түрээсийг харилцагчиддаа олгоод байна. Ингэснээр нийт санхүүгийн түрээсийн хэмжээг 77.5 тэрбум төгрөгт хүргэн, Монгол Улсын тэргүүлэх лизингийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын нэг болж чадлаа.

Ти Ди Би Лизинг ХХК нь Монгол Улсын дэд бүтэц болон барилга, зам тээвэр, уул уурхай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл болон эмнэлэг зэрэг өргөн хүрээний салбаруудад тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээг үзүүлж байна.

Санхүүгийн түрээсийн хэмжээ /тэрбум төгрөг/




## Хамтран ажиллагч, нийлүүлэгч байгууллагууд

Ти Ди Би Лизинг ХХК нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж буй дэд бүтэц, барилга угсралт, зам тээвэр, уул уурхай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл зэрэг бүхий л салбаруудад тоног төхөөрөмж нийлүүлж буй салбартаа тэргүүлэгч нийлүүлэгч байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээг байгуулан нягт хамтран ажиллаж байна.

| | |
|---|---|
| Shima Seiki | |
| United Belaz machinery | |
| Za Mine | |
| Transwest Mongolia LLC | |
| Monnis group | |
| Ensada | |

| | |
|---|---|
| Wagner | |
| Ammac MGL | |
| Sandvik | |
| Хера Холдинг | |
| Everdigm | |
| Hyunday | |
| AODE | |
| MSM | |
| Bridge goup | |
| Proliance | |





# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

*ХХБанкны бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг олон улсын стандартын дагуу тодорхойлж үнэлэн, эрсдэлийн уршигт байдал, эрсдэл гарах магадлал, хяналтын үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийж эрсдэлийн түвшинг тодорхойлсны үндсэн дээр эрсдэлийг бууруулах арга хувилбарыг боловсруулах замаар үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.*

## ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

### Банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж ажиллалаа

Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд тайлант онд Зохицуулагч байгууллага болон гадаадын хамтран ажилладаг түнш байгууллагуудаас тавьдаг зээлийн шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд барьж ажилласнаас гадна эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийг урьдчилан тодорхойлох, эрсдэлийн түвшинг үнэлж бууруулах арга хэмжээг төлөвлөн, бүх шатны хяналтыг хэрэгжүүллээ. Тухайлбал, тайлант оны байдлаар банкны зээлийн эрсдэлийн сан, чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт 119.1 хувь буюу зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг чанаргүй зээлийн түвшинг бүрэн хамгаалах хэмжээнд хүргэн ажиллалаа.

### Зээлийн эрсдэлийн удирдлагыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгын хүрээнд бодлого, журам, арга, аргачлалыг сайжрууллаа

2020 онд арилжааны банкуудад санхүүгийн тайлагналын олон улсын тайлагналын IFRS9 стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хүрээнд зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох аргачлалыг боловсрууллаа. Базелийн хорооноос гаргасан шинэчлэлийг банкны зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагааны журмуудад тусган, дотооддоо зээлийн эрсдэлийг тооцох арга, аргачлалыг сайжруулж, барьцаа хөрөнгийн үнэлгээний бодлого, үнэлэх арга аргачлалыг олон улсын стандартын дагуу ахисан түвшинд хүрэх бэлтгэл ажлын суурийг тавьлаа.

## ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

### Зах зээлийн эрсдэлийг үнэлэх загвар, арга аргачлал болон тайлагналын системийг боловсронгуй болголоо

Банкны үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, ашигт ажиллагааг зорилтод түвшинд байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд зах зээлийн эрсдэлийн оновчтой удирдлага чухал байдаг. Тайлант онд зах зээлийн эрсдэлийн удирдлагыг арилжааны эрсдэл, макро хүчин зүйлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүний эрсдэл, харилцагч тал улс орны эрсдэлийн хүрээнд хэрэгжүүлэн ажилласан. Эрсдэлүүдийг үнэлэх арга аргачлал, загварыг судлан сайжруулах, улмаар банкны хүлээж болзошгүй эрсдэлд дүгнэлт гарган банкны удирдлагад цаг тухайд нь тайлагнах тал дээр онцгой ач холбогдол өгч ажиллалаа.

Эдийн засгийн таатай бус нөхцөл байдалд банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь макро хүчин зүйлээс банкны бүхий л үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, ялангуяа зээлийн багцын эрсдэлийн хамаарлыг тодорхойлж, нөлөөлөх нөлөөллийг тогтооход чиглэсэн билээ. Тухайлбал, банкны зээлийн багцад төвлөрөл өндөртэй эдийн засгийн салбарууд олгосон зээлийн багцын чанарт илүү анхаарч, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, бууруулах зорилготой голлох эдийн засгийн салбаруудын судалгаа болон макро эдийн засгийн судалгааг тогтмол хийж гүйцэтгэж байна. Түүнчлэн макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд үргэлжлэн муудах нөхцөлийг тодорхойлон, банкны зээлийн багцад стресс тест хийж, нөлөөллийг тооцож ажиллалаа. Банкны валютын ханшийн тэгшитгэлээс гадна гадаад валютаарх зээлийн багцад шинжилгээ хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн тухай бүр тайлагнаж байна.

ХХБанк нь Базелийн хорооноос нийтэлсэн Базел II, III шаардлагууд, олон улсын практик зөвлөмжүүд дээр үндэслэн банкны нэр хүнд, ашигт ажиллагаа мөн харилцагчийн итгэл зэрэгтэй шууд уялдаг хөрвөх чадварын эрсдэл болон хүүний эрсдэлийг удирдах арга, аргачлалыг шаардлагатай үе тутамд шинэчлэн, хөгжүүлэлтийг хийн ажилласаар байгаа билээ.

### Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг хангалттай түвшинд биелүүлж ажиллалаа

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын зорилго нь банкны хөрвөх чадварт үүсч болох асуудал, хүндрэлийг шийдэх, актив болон пассивын удирдлагын үр ашгийг нэмэгдүүлэх ба цаашлаад хадгаламж эзэмшигчид болон харилцагчдын эрх ашгийг хамгаалахад оршдог. Тайлант онд Монголбанкны хөрвөх чадварын зохистой түвшинг барьж ажиллахаас гадна Базелийн шалгуур үзүүлэлт болох LCR>100%, NSFR>100% харьцаануудыг бүрэн хангаж, банкны хөрвөх чадварын эдгээр 2 харьцаа үзүүлэлтүүд 153.1%, 124.7%-тай байна.

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛЭЭР

### Зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлж, бууруулах арга хэмжээ авч ажиллалаа

Нийгмийн хариуцлагаа ухамсарласан бодлого хэрэгжүүлэх нь банкны соёл, зохистой засаглалын нэг хэлбэр байдаг. Харилцагчийн Байгаль, орчин нийгмийн хариуцлагын эрсдэлийг бодитоор үнэлэх нь харилцагчийн нөхцөл байдалд тохирсон нөхцөл шаардлага тавих, цаашлаад “НОГООН” санхүүжилтийн боломжийг харилцагчдад таниулж, харилцагчийн бизнесийг дэмжих, банкны эрсдэлийг хаах зорилготой байдаг билээ.

Банк нь өөрийн зээлдэгчдэд Байгаль орчин, нөлөөллийн үнэлгээ гаргуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, хүний нөөц, Байгаль, орчин нийгмийн хариуцлагын бодлого, хөдөлмөрийн аюулгүй байдал, хог хаягдлын менежментийн бодлого, заавар, журам боловсруулах, мэргэжлийн хяналтын шинжилгээ дүгнэлтийг хэрэгжүүлэх болон бусад холбогдох нөхцөл шаардлагыг тавьж, хэрэгжилтийг хянаж ажилласан ба эдгээр нөхцөл, шаардлагын хэрэгжилт 75%-тай биелсэн байна.

### Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн системдээ 2 дахь удаагаа аудит хийлгэлээ

Тайлант онд Нидерландын хөгжлийн банк болон дотоодын байгаль орчны зөвлөх компани Эс И Си ХХК-аар Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн системдээ 2 дахь удаагаа хөндлөнгийн аудит хийлгэж, 90.04 хувь буюу “Сайн” үнэлгээ авлаа. Энэхүү аудитын үр дүнд одоогийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх, мэргэжлийн экспертүүдээс зөвлөх үйлчилгээ авснаар байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн системийг сайжруулж, олон улсын ахисан түвшинд хүргэх, дотоодын хууль эрх зүйн орчинтой нийцүүлэх зэрэг ач холбогдолтой байлаа.

### “ШИЛДЭГ ТОС БАНК”-аар шалгарлаа

2017 онд Монголын Банкны Холбооноос банкны системийн хэмжээнд үлгэр жишээ болохуйц Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн системийг бий болгосон, ТоС-ын зарчмуудыг амжилттай хэрэгжүүлэн, өндөр ач холбогдол бүхий олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлж, манлайлан ажилласныг үнэлж “Шилдэг ТоС Банк”-аар 2 дахь жилдээ шалгарлаа.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

ХХБанк нь гадаад хүчин зүйлүүд болон программ, системийн доголдол, дотоод үйл ажиллагаанаас үүсэх аливаа эрсдэлийг зохистой удирдаж, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант онд эрсдэлийн үнэлгээний аргачлалыг сайжруулах зорилгоор Олон улсын стандарт аргачлал болох “Эрсдэл хяналтын өөрийн үнэлгээ”-г нэвтрүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангаж, үйл ажиллагаанд туршиж ажиллалаа. Энэхүү аргачлалыг нэвтрүүлснээр үйл ажиллагааны эрсдэлийг эрсдэл хүлээгч ажилтан, нэгжийн түвшинд илрүүлэх, үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог улам сайжруулах ач холбогдолтой юм.

Мөн банк харилцагчдаа цахим эрсдэлээс хамгаалах зорилгоор “Цахим эрсдэлээс сэргийлж ажиллах, гадаад төлбөр тооцоо хийхдээ анхаарах асуудлын талаар” зөвлөмж, мэдээлэл бэлтгэн хүргүүллээ.



## КОМПЛАЙНС, МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

ХХБанк нь үйл ажиллагаандаа олон улсын стандарт, шилдэг туршлагыг нэвтрүүлж, нийгмийн хариуцлага, засаглалын бодлогоо улам нээлттэй байлгах зорилгоор ТУЗ-ийн шийдвэрээр тайлант онд Комплайнсын хэлтсийг шинээр байгуулж, комплайнсын бодлогын баримт бичгүүдийг боловсруулан Банкны комплайнсын чиг үүрэг, хамрах хүрээ, үндсэн зарчмуудыг тодорхойлж гаргалаа. Ингэснээр цаашид үндэсний хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журмыг Банкны үйл ажиллагаанд дагаж мөрдөх, дотоодын бодлого, журмаа тэдгээрт нийцүүлэх, хэрэгжилтийг хангуулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн бусад тусгайлсан зохицуулалтуудыг хангаж ажиллах юм.

Монгол улсын арилжааны банкуудаас анх удаа ХХБанк нь Know Your Customer (KYC) буюу "Харилцагчаа таньж мэдэх" зарчимд тулгуурласан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хөтөлбөрийг олон улсын стандартад нийцүүлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд харилцагчиддаа санхүүгийн олон талт үйлчилгээг хүргэх, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллахдаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль дүрэм, олон улсын журам, стандартыг мөрдөн хэрэгжүүлж ажиллаж байгаа билээ. Тухайлбал, Нэгдсэн үндэстний байгууллага, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (FATF), АНУ-ын гадаад хөрөнгийн хяналтын алба (OFAC) зэрэг зохицуулагч байгууллагаас гаргасан тусгай хөтөлбөрүүдийн хүрээнд тэдгээрээс гаргасан зөвлөмж, шаардлагыг мөрдөж ажиллаж байна.

Тайлант онд, ХХБанк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр болон харилцагчийг таньж мэдэх талаар гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай уулзалт хийх, танилцуулга мэдээлэл өгөх зэргээр найдвартай, тогтвортой корреспондент харилцааг дэмжин ажиллалаа.

Мөн, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтыг сайжруулах хүрээнд "Хар дэвтэр" хяналтын модулийг нэвтрүүлж, гүйлгээний онлайн хяналтыг олон улсын стандартын дагуу цогцоор хийж эхэллээ.

2017 онд олон улсын SWIFT сүлжээний "The KYC Registry" мэдээллийн санд Банкны комплайнсын баримт, мэдээллүүдийг оруулж нэгдснээр стандарт KYC мэдээллийг шуурхай солилцох, харилцагчаа таньж мэдэн ажиллах боломжийг сүлжээний хэрэглэгчдэд бий болгосон юм.



# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

*ХХБанк нь тайлант онд олон улсын стандарт шаардлагад нийцсэн мэдээллийн технологи, техник хэрэгслүүдийг ашиглан банкны үйлчилгээг харилцагчдад чанартай, түргэн шуурхай эрсдэлгүй хүргэх, дотоод үйл ажиллагааг автоматжуулж, ажилтнуудынхаа хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч, мэдээллийн технологийн хэд хэдэн ажил, төслүүдийг хэрэгжүүлж ажиллалаа.*

ХХБанк нь Олон улсын стандарт шаардлагад нийцсэн мэдээллийн технологийн дэвшилтэт техник, арга хэрэгсэлд тулгуурлан банкны үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангах, ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхэд онцгойлон анхаарч, мэдээллийн технологийн хөгжилдөө хөрөнгө оруулалтыг тогтмол хийж ажилладаг. Тайлант онд харилцагч банкны үйлчилгээний өөрт шаардлагатай мэдээллийг интернэтээр авах, төлбөр тооцоог хялбар гүйцэтгэх программ хангамж, технологийн боломжийг хангах мэдээллийн технологийн олон төсөлт ажлуудыг хэрэгжүүллээ.

***Банкны үйлчилгээг харилцагчдад ойр, хялбар болгох үндэс мэдээллийн технологийн дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.***

- Visa International байгууллагатай хамтран, төлбөрийн картыг зайнаас мэдэрч гүйлгээ хийх Visa payWave технологи;
- QR код ашиглан дансандаа төлбөр хүлээн авах, шилжүүлэх хялбар, шуурхай, найдвартай үйлчилгээ болох TDB Pay үйлчилгээ;
- Банкны үйлчилгээг зөвхөн банкны салбар нэгжүүдээр биш харилцагчийн байгаа газар нь очиж үйлчлэх боломжийг бүрдүүлсэн eReg программ хангамж;
- Сошиал сувгаас банкны бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг хормын төдийд авах боломж бүхий автомат туслах буюу TDB Bot үйлчилгээ зэрэг томоохон төсөлт ажлуудыг ХХБанкны мэдээллийн технологийн чадварлаг баг амжилттайгаар гүйцэтгэлээ.

Түүнчлэн, TDB Online цахим үйлчилгээнд банкны үйлчилгээ, даатгалын үйлчилгээ, хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг хамтад хэрэглэх боломжийг хөгжүүлснээр санхүүгийн гурван тулгуурыг харилцагч нартаа онлайнаар хүргэж байгаа анхны банк болоод байна. Мөн TDB Online цахим үйлчилгээнд харилцагч өөрөө шинээр харилцах болон хадгаламжийн данс нээх, QR код бүхий баталгаажуулах кодтой дансны тодорхойлолт болон бусад төрлийн тодорхойлолтуудыг онлайнаар авах боломжтой болсны зэрэгцээ хадгаламж барьцаалсан зээл зэрэг бусад үйлчилгээг авах боломжийг хангахаар ажиллаж байна.

Банкны мэдээллийн технологийн найдвартай байдлыг сайжруулсаар байна

Банкны үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж, систем, мэдээллийн сан, сүлжээ, холбоо, сервер, тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн үйлдлийн систем, мэдээллийн аюулгүй байдал, ажилтны үйл ажиллагаа төлбөрийн картын системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах стандарт болох PCI-DSS (Payment Card Industry Data Security Standard)-т бүрэн нийцүүллээ.



# НОСТРО ДАНСТАЙ БАНКУУД

| Currency | No | Correspondent Banks | SWIFT CODE |
|---|---|---|---|
| USD | 1 | STANDARD CHARTERED BANK | SCBLUS33 |
| | 2 | CHINA CONSTRUCTION BANK | PCBCUS33 |
| | 3 | COMMERZBANK AG | COBADEFF |
| | 4 | ZAO UNICREDIT BANK | IMBKRUMM |
| | 5 | OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE | SABRRU66 |
| | 6 | JSC RUSSIAN AGRICULTURAL BANK | RUAGRUMM |
| | 7 | PJSC TRANSKAPITALBANK | TJSCRUMM |
| | 8 | JSC VTB Bank | VTBRRUMM |
| | 9 | Russian Export Import Bank (ROSEXIM Bank) | EXIRRUMM |
| | 10 | OCBC BANK | OCBCSGSG |
| | 11 | KEB HANA Bank | KOEXKRSE |
| | 12 | Kookmin Bank, Seoul | CZNBKRSE |
| | 13 | CHINA CONSTRUCTION BANK, NEIMENGGU BRANCH | PCBCCNBJNME |
| | 14 | INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA | ICBKCNBJNMA |
| | 15 | BANK OF CHINA (HONG KONG) LIMTED | BKCHHKHH |
| | 16 | BAO SHANG BANK | ABOCCNBJ050 |
| | 17 | BANK OF INNER MONGOLIA | HSSYCNBH |
| EUR | 18 | COMMERZBANK AG | COBADEFF |
| | 19 | ING BELGIUM NV/SA | BBRUBEBB010 |
| | 20 | Russian Export Import Bank (ROSEXIM Bank) | EXIRRUMM |
| JPY | 21 | BANK OF TOKYO-MITSUBISHI UFJ LTD | BOTKJPJT |
| | 22 | SUMITOMO MITSUI BANKING CORPORATION | SMBCJPJT |
| | 23 | MIZUHO CORPORATE BANK LTD | MHCBJPJT |

| | | | |
|---|---|---|---|
| GBP | 24 | STANDARD CHARTERED BANK PLC | SCBLGB2L |
| | 25 | BANK OF TOKYO-MITSUBISHI UFJ LTD | BOTKGB2L |
| CHF | 26 | COMMERZBANK AG | COBADEFF |
| AUD | 27 | AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING GROUP LIMITED | ANZBAU3M |
| KRW | 28 | KEB HANA Bank | KOEXKRSE |
| | 29 | Kookmin Bank, Seoul | CZNBKRSE |
| CNY | 30 | AGRICULTURAL BANK OF CHINA, NEIMENGGU BRANCH | ABOCCNBJ050 |
| | 31 | CHINA CONSTRUCTION BANK, ERLIANHAOTE SUB BRANCH | PCBCCNBJNME |
| | 32 | BAO SHANG BANK | BTCBCNBJ |
| | 33 | Pudong Development Bank of Shanghai | SPDBCNSH |
| | 34 | BANK OF CHINA (HONG KONG) LIMTED | BKCHHKHH |
| | 35 | BANK OF CHINA, ERLIAN BRANCH | BKCHCNBJ89N |
| | 36 | INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA | ICBKCNBJNMA |
| | 37 | BANK OF INNER MONGOLIA | HSSYCNBH |
| CAD | 38 | COMMERZBANK AG | COBADEFF |
| RUB | 39 | ZAO UNICREDIT BANK | IMBKRUMM |
| | 40 | OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE | SABRRU66 |
| | 41 | JSC VTB Bank | VTBRRUMM |
| | 42 | PJSC TRANSKAPITALBANK | |
| | 43 | JSC RUSSIAN AGRICULTURAL BANK | RUAGRUMM |
| | 44 | Russian Export Import Bank (ROSEXIM Bank) | EXIRRUMM |
| NZD | 45 | ANZ Bank New Zealand Limited | ANZBNZ22 |
| HKD | 46 | THE BANK OF TOKYO-MITSUBISHI UFJ | BOTKHKHH |
| SGD | 47 | OCBC BANK | OCBCSGSG |
| SEK | 48 | NORDEA BANK AB | NDEASESS |
| TRY | 49 | TURKIYE IS BANKASI A.S. | ISBKTRIS |

# 03

# ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

# ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

**2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

KPMG

## Худалдаа Хөгжлийн Банк ХХК Группийн мэдээлэл

| | |
|---|---|
| **Албан ёсны хаяг:** | Монгол Улс, Улаабаатар хот 14210,<br>Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,<br>Энхтайваны өргөн чөлөө 19 |
| **Төлөөлөн Удирдах Зөвлөл:** | Д. Эрдэнэбилэг (Дарга)<br>Р. Коппа<br>Д.Гантөгс<br>Т. Цолмон<br>З. Шагдарсүрэн<br>Ж. Болормаа<br>Ж. Дэлгэрсайхан |
| **Нарийн бичгийн дарга:** | Д. Даваажав |
| **Хараат бус аудитор:** | Кэй Пи Эм Жи Аудит ХХК, Монгол Улс,<br>Улаанбаатар хот |

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Эрдэнэбилэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Р.Коппа, Гүйцэтгэх Захирал О.Орхон, Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал Д.Янжмаа бид энд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группын 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилж байна.

ТУЗ-ийн дарга
Д. Эрдэнэбилэг

ТУЗ-ийн дэд дарга
Р. Коппа

Гүйцэтгэх Захирал
О. Орхон

Санхүүгийн Удирдлага,
Хяналтын Газрын Захирал
Д. Янжмаа

Монгол Улс, Улаанбаатар хот

Огноо: 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдөр

KPMG

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

## Хараат Бус Аудиторын Тайлан

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

### *Дүгнэлт*

Бид Худалдаа Хөгжлийн Банк ХХК (цаашид "Банк" гэх) болон түүний охин компаниуд (цаашид "Групп" гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС")-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү нэгтгэсэн тайлангийн Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НБЁЗОУСЗ")-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Группээс хараат бус байж, эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

### *Асуудлыг онцлон тэмдэглэх нь*

Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 39-ийг онцолж байна. 2017 оны 5 дугаар сард Олон Улсын Валютын Сангийн Захирлуудын Зөвлөлөөс Монгол Улсын эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийг гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн хүрээнд, Монгол Улсын Арилжааны Банкуудын Төлбөрийн Чадварын Үнэлгээг (АЧҮ-г хамруулаад) Монголбанк зохион байгуулсан. АЧҮ-г Европын Төв Банкны Активын Чанарын Үнэлгээний Удирдамж 2-ын дагуу гүйцэтгэсэн ба Монголбанк нь тодорхой зүйлсийг Монгол Улсын нөхцөл байдалд тохируулан тусгайлан тодорхойлсон. Дээрх үнэлгээний урьдчилсан үр дүнг арилжааны банкуудад 2018 оны 01 дүгээр сард танилцуулсан. Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг батлан гаргах өдрөөр, АЧҮ болон стресс тестийн эцсийн үр дүн гараагүй байсан бөгөөд Монгол Улсын санхүүгийн сектор болон Группт үнэлгээний үр дүн хэрхэн нөлөөлөх нь хараахан тодорхой болоогүй байсан. Энэ нь зах зээлийн, хууль эрх зүйн, зээлийн болон бусад эрсдэлд (хөрөнгийн хангалттай байдлын эрсдэл үүнд хамаарна) ихээхэн хэмжээний тодорхойгүй байдлыг бий болгож байгаа бөгөөд Групп эдгээр эрсдэлд хэрхэн өртөх болон үр дүн нь хэрхэх нь зөвхөн цаг хугацааны туршид тодорхой болох юм. Группын нэгтгэсэн санхүүгийн тайланд АЧҮ болон стресс тест санхүүгийн хувьд хэрхэн нөлөөлөхийг одоогоор тодорхойлох боломжгүй байна. Бидний дүгнэлт энэхүү асуудлаас хамаарч хязгаарлагдаагүй болно.

KPMG-ийн сүлжээний бие даасан гишүүн байгууллагууд нь Швейцарь улсын хуулийн этгээд KPMG International Cooperative ("KPMG International")-ийн гишүүн юм. KPMG-ийн гишүүн байгууллага бүр хуулийн тусдаа этгээд болно.

KPMG

***Асуудлыг онцлон тэмдэглэх нь (Үргэлжлэл)***

Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 42-ыг мөн онцолж байна. 2017 оны 02 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас ажлын хэсэг томилогдож Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн 49 хувийг худалдан авсан Монголын Зэс Корпораци ХХК-ийн худалдан авалтын хэлцлийг шалгасан ба Групп Монголын Зэс Корпораци ХХК ("МЗК")-д шаардлагатай санхүүжилтийн зээлийг олгосон байсан. Үүний үр дүнд, Группт аливаа боломжит сөрөг нөлөө үзүүлэх эсэх нь тодорхойгүй байна. Бидний дүгнэлт энэхүү асуудлаас хамаарч хязгаарлагдаагүй болно.

***Аудитын гол онцлох зүйлс***

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Эдгээр онцлох зүйлс нь бидний нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх болон дүгнэлт өгөх явцад шийдвэрлэгдсэн бөгөөд бид эдгээр асуудлуудад тусдаа дүгнэлт өгөхгүй юм.

<u>Зээлийн болзошгүй эрсдэлийн сан</u>

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 7-д хамаарна.

| Аудитын гол онцлох зүйлс | Аудитын гол онцлох зүйлсийг хэрхэн шийдвэрлэсэн талаар |
|---|---|
| СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу Групп нь зээлийн ангилал болон шаардлагатай болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээг тодорхойлохдоо чанарын болон цаг хугацааны хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байдаг. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлийн болзошгүй эрсдэлийн сан 267,932,462 мянган төгрөг байсан ба энэ нь нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг тул аудитад нилээд ач холбогдолтой байсан. Түүнчлэн, зээлийн эрсдэлийн сан байгуулах удирдлагын үнэлгээний үйл явц нь нарийн төвөгтэй, үнэлэмж их шаарддаг бөгөөд эргэн төлөлтийн хуваарийн зөрчил гэх мэт цаг хугацааны хүчин зүйлс, зээлдэгчийн санхүүгийн болон эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт чанарын хүчин зүйлсээс хамаарсан байдаг. | Зээлийн ангилалын зохистой байдлыг шалгахдаа бид зээлийн хувийн хэргүүдээс түүвэрлэн шалгаж аудитын горимыг гүйцэтгэсэн. Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн зөрчлийн талаарх мэдээллийн найдвартай байдлыг холбогдох мэдээллийн технологийн хяналтуудыг шалгах байдлаар, зээлийн чанарын хүчин зүйлсийн талаар хийсэн Группын үнэлгээг шалгахдаа удирдлагын гаргасан таамаглал, үндэслэлийг холбогдох салбар болон бизнесийн орчны талаарх өөрсдийн ойлголт, Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журмын шаардлагуудтай харьцуулах байдлаар шалган үзсэн. |

KPMG

***Аудитын гол онцлох зүйлс (Үргэлжлэл)***

<u>Дуусаагүй барилга</u>

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 10-д хамаарна.

| Аудитын гол онцлох зүйлс | Аудитын гол онцлох зүйлсийг хэрхэн шийдвэрлэсэн талаар |
|---|---|
| 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусаагүй барилга дансны үлдэгдэл 142,820,691 мянган төгрөг байсан ба энэ нь нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй байсан. | Бид Группын удирдлагууд болон барилгын ажлын гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай тухайн барилгын ажлын явцын талаар ойлголт авах зорилгоор ярилцлага хийж, барилгын гэрээ хэлцлүүд, төлбөр төлсөн нотлох баримтыг шалгаж, хийгдсэн төлбөр болон барилгын явцын талаар барилгын төслийн төлөвлөгөө, барилга угсралтын ажилд шаардлагатай зөвшөөрлийн явцыг хараат бус байдлаар тулган баталгаажуулсан. |

***Бусад мэдээлэл***

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангийн өдрөөс хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм.

Жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг алдаа байна гэж үзвэл энэ талаар бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх үүрэгтэй.

***Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага***

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-д тулгуурлан Монголбанкны баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь Группын удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группын тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулж, Группыг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх үүргийг Группын удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

KPMG

***Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага***

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нэгтгэсэн дүнгээрээ уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.

- Группын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Группын тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ хязгаарлах шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Группыг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд Группт хамаарах аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаарх хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Бид группын хэмжээний аудитыг удирдан чиглүүлж, хяналт тавьж, мөн гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн гаргасан аудитын дүгнэлтийнхээ хүрээнд хариуцлага хүлээнэ.

KPMG

***Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага (Үргэлжлэл)***

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн тухай мэдэгдэл хийдэг бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудал, зарим тохиолдолд түүний эсрэг үзүүлсэн хариу үйлдлийн талаар мэдэгдэл хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

***Бусад асуудлууд***

Энэхүү тайлан нь зөвхөн Группын гишүүдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Г. Соёлмаа болно.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК

КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК
KPMG AUDIT LLC
УЛААНБААТАР ХОТ
ТТ33977 ☎ 5543495

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

| |
|---|
| Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүй болохыг анхаарна уу. |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
**Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

| | Тодруулга | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө | 4 | 1,073,933,382 | 1,188,822,410 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 5 | 2,026,286,707 | 1,525,435,217 |
| Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт | 6 | 60,841,264 | 59,490,789 |
| Зээл ба урьдчилгаа, цэвэр | 7 | 2,764,974,569 | 2,835,167,306 |
| Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас | 8 | 11,981,945 | - |
| Хоёрдогч зээл | 9 | - | 4,000,000 |
| Үндсэн хөрөнгө, цэвэр | 10 | 324,138,590 | 333,559,483 |
| Биет бус хөрөнгө, цэвэр | 11 | 2,587,186 | 5,048,116 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 12 | 91,951,413 | 88,923,950 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө, цэвэр | 13 | 2,808,306 | 2,194,609 |
| Бусад хөрөнгө | 14 | 515,421,954 | 602,543,026 |
| **Нийт хөрөнгө** | | 6,874,925,316 | 6,645,184,906 |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгө** | | | |
| **Өр төлбөр** | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 15 | 3,070,233,636 | 2,415,529,106 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 16 | 243,907,591 | 143,207,671 |
| Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас | 17 | 129,960,388 | 129,960,388 |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | 18 | 1,068,669,444 | 1,392,176,891 |
| Орлогын албан татварын өглөг | | 20,303 | 1,524,308 |
| Гаргасан өрийн үнэт цаас | 19 | 1,344,633,676 | 1,569,366,930 |
| Хоёрдогч өглөг | 20 | - | 24,895,300 |
| Бусад өр төлбөр | 21 | 141,967,647 | 209,373,587 |
| **Нийт өр төлбөр** | | 5,999,392,685 | 5,886,034,181 |
| **Өөрийн хөрөнгө** | | | |
| Хувьцаат капитал | 22 | 50,000,011 | 50,000,011 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 19,272,456 | 19,272,456 |
| Капитал тохируулга | 24 | - | (1,583,600) |
| Дахин үнэлгээний нөөц | 10, 25 | 130,014,323 | 126,992,124 |
| Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз) | 25 | 13,721,669 | 30,219,254 |
| Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хуримтлагдсан хэрэгжээгүй олз | 25 | 72,371,681 | 14,905,402 |
| Хуримтлагдсан ашиг | | 590,152,491 | 516,572,740 |
| **Группын хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт өөрийн хөрөнгө** | | 875,532,631 | 756,378,387 |
| **Хяналтын эрхгүй хувь оролцоо** | | - | 2,772,338 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | | 875,532,631 | 759,150,725 |
| **Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө** | | 6,874,925,316 | 6,645,184,906 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
**Нэгтгэсэн Дэлгэрэнгүй Орлогын Тайлан**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

| | Тодруулга | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 26 | 612,882,220 | 593,217,355 |
| Хүүгийн зардал | 27 | (434,121,831) | (400,832,691) |
| **Хүүгийн цэвэр орлого** | | 178,760,389 | 192,384,664 |
| Шимтгэл, хураамжийн цэвэр орлого | 28 | 37,039,956 | 30,618,600 |
| Үйл ажиллагааны бусад орлого, цэвэр | 29 | 47,974,223 | 12,021,005 |
| **Хүүгийн бус цэвэр орлого** | | 85,014,179 | 42,639,605 |
| **Үйл ажиллагааны орлого** | | 263,774,568 | 235,024,269 |
| Үйл ажиллагааны зардал | 30 | (89,930,081) | (92,650,037) |
| Хараат компани, хамтарсан компанийн ашгийн эзлэх хувь | 6 | 15,858,850 | 17,296,485 |
| Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал | 31 | (115,562,031) | (91,997,632) |
| **Татварын өмнөх ашиг** | | 74,141,306 | 67,673,085 |
| Орлогын татварын зардал | 33 | (381,360) | (212,876) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | 73,759,946 | 67,460,209 |
| **Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| **Ашиг, алдагдлаар дахин ангилагдахгүй зүйлс** | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн цэвэр өөрчлөлт | 10, 25 | 3,022,199 | (7,317,887) |
| **Ашиг, алдагдлаар дахин ангилсан эсвэл ангилж болох зүйлс** | | | |
| Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт | 25 | (16,497,585) | 54,050,383 |
| Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хэрэгжээгүй цэвэр олз (гарз) | 25 | 57,466,279 | (25,032,960) |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | 43,990,893 | 21,699,536 |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого** | | 117,750,839 | 89,159,745 |
| **Ашигийн хамаарал:** | | | |
| Группын хувьцаа эзэмшигчид | | 73,759,946 | 67,965,541 |
| Хяналтын эрхгүй эзэмшигчид | | - | (505,332) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | 73,759,946 | 67,460,209 |
| **Нийт дэлгэрэнгүй орлогын хамаарал:** | | | |
| Группын хувьцаа эзэмшигчид | | 117,750,839 | 89,665,077 |
| Хяналтын эрхгүй эзэмшигчид | | - | (505,332) |
| **Тайлант жилийн нийт нэгтгэсэн орлого** | | 117,750,839 | 89,159,745 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
**Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

| | | Группын хувьцаа эзэмшигчдэд хамаарах | | | | | | | | | (Мян.төг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Тод.** | **Хувьцаат капитал** | **Нэмж төлөгдсөн капитал** | **Капитал тохируулга** | **Дахин үнэлгээний нөөц** | **Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз** | **Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний олз** | **Хуримт-лагдсан ашиг** | **Нийт** | **Хяналтын эрхгүй хувь оролцоо** | **Нийт өөрийн хөрөнгө** |
| **2017 оны 01 дүгээр сарын 01** | | 50,000,011 | 19,272,456 | (1,583,600) | 126,992,124 | 30,219,254 | 14,905,402 | 516,572,740 | 756,378,387 | 2,772,338 | 759,150,725 |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | | | | | | | | - | | - |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | - | - | - | - | - | - | 73,759,946 | 73,759,946 | - | 73,759,946 |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт | 25 | - | - | - | - | (16,497,585) | - | - | (16,497,585) | - | (16,497,585) |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн цэвэр өөрчлөлт | 10, 25 | - | - | - | 3,022,199 | - | - | - | 3,022,199 | - | 3,022,199 |
| Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хэрэгжээгүй цэвэр гарз | 25 | - | - | - | - | - | 57,466,279 | - | 57,466,279 | - | 57,466,279 |
| Нийт бусад дэлгэрэнгүй орлого | | - | - | - | 3,022,199 | (16,497,585) | 57,466,279 | - | 43,990,893 | - | 43,990,893 |
| **Бусад** | | | | | | | | | | | |
| Нэгтгэлийн цар хүрээний өөрчлөлт | 24 | - | - | 1,583,600 | - | - | - | (180,195) | 1,403,405 | (2,772,338) | (1,368,933) |
| **2017 оны 12 дугаар сарын 31** | | 50,000,011 | 19,272,456 | - | 130,014,323 | 13,721,669 | 72,371,681 | 590,152,491 | 875,532,631 | - | 875,532,631 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
**Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан (үргэлжлэл)**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

| | | Группын хувьцаа эзэмшигчдэд хамаарах | | | | | | | | | (Мян.төг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Тод.** | **Хувьцаат капитал** | **Нэмж төлөгдсөн капитал** | **Капитал тохируулга** | **Дахин үнэлгээний нөөц** | **Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз)** | **Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний олз** | **Хуримт-лагдсан ашиг** | **Нийт** | **Хяналтын эрхгүй хувь оролцоо** | **Нийт өөрийн хөрөнгө** |
| **2016 оны 01 дүгээр сарын 01** | | 50,000,011 | 19,272,456 | - | 135,298,874 | (23,831,129) | 39,938,362 | 445,209,993 | 665,888,567 | 2,043,974 | 667,932,541 |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | | | | | | | | | | |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | - | - | - | - | - | - | 67,965,541 | 67,965,541 | (505,332) | 67,460,209 |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | | | | | | | | | | |
| Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт | 25 | - | - | - | - | 54,050,383 | - | - | 54,050,383 | - | 54,050,383 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн цэвэр өөрчлөлт | 10, 25 | - | - | - | (8,306,750) | - | - | 988,863 | (7,317,887) | - | (7,317,887) |
| Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хэрэгжээгүй цэвэр олз | 25 | - | - | - | - | - | (25,032,960) | - | (25,032,960) | - | (25,032,960) |
| Нийт бусад дэлгэрэнгүй орлого | | - | - | - | (8,306,750) | 54,050,383 | (25,032,960) | 988,863 | 20,115,936 | - | 21,699,536 |
| **Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ** | | | | | | | | | | | |
| Бизнесийн нэгдлээс шалтгаалсан өөрчлөлт | | - | - | - | - | - | - | 586,060 | 586,060 | 2,814,643 | 3,400,703 |
| Охин компанийн худалдаж авсан халаасны хувьцаа | 24 | - | - | (1,583,600) | - | - | - | - | (1,583,600) | - | (1,583,600) |
| Бусад өөрчлөлт | | - | - | - | - | - | - | 1,822,283 | 1,822,283 | (1,580,947) | 241,336 |
| **2016 оны 12 дугаар сарын 31** | | 50,000,011 | 19,272,456 | (1,583,600) | 126,992,124 | 30,219,254 | 14,905,402 | 516,572,740 | 756,378,387 | 2,772,338 | 759,150,725 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
**Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

| | Тодруулга | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | | |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | 73,759,946 | 67,460,209 |
| Тохируулга: | | | |
| Элэгдэл, хорогдуулга | 10, 11, 30 | 9,605,279 | 12,310,763 |
| Хараат болон хамтарсан компанийн ашгаас ногдох хувь | 6 | (15,858,850) | (17,296,485) |
| Үнэт цаас борлуулсаны олз | 29 | (14,168,548) | (21,827,163) |
| Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтыг борлуулсаны олз | 29 | (8,556,355) | (8,907,904) |
| Хүүгийн цэвэр орлого | 26, 27 | (178,760,389) | (192,384,664) |
| Орлогын албан татварын зардал | 33 | 381,360 | 212,876 |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны гарз (олз) | 29 | (4,868) | 9,348 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсаны гарз | 29 | - | 1,252,400 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 30 | 140,534 | 9,380 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө хассаны гарз | 30 | - | 1,151,774 |
| Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан | 31 | 115,562,031 | 91,997,632 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний гарз (олз) | 12, 29 | (3,027,463) | 7,792,650 |
| Үндсэн хөрөнгийн үнэлгээний олз | 11, 30 | (117,643) | - |
| Цалингийн зардал | 30 | - | 404,458 |
| **Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг:** | | (21,044,966) | (57,814,726) |
| Монголбанкинд заавал байлгах нөөцийн өсөлт | 4, 35 | (70,864,203) | (746,435) |
| Зээл ба урьдчилгааны өсөлт | | (45,631,007) | (343,124,012) |
| Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаасны бууралт (өсөлт) | 8 | (11,981,945) | 99,799,000 |
| Хоёрдогч зээлийн бууралт | 9 | 4,000,000 | - |
| Бусад хөрөнгийн бууралт (өсөлт) (*) | 14 | 176,213,881 | (194,115,525) |
| Харилцагчийн харилцах, хадгаламжийн өсөлт | 15 | 654,704,530 | 205,575,643 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжийн өсөлт | 16 | 100,699,920 | 30,452,699 |
| Бусад өр төлбөрийн бууралт (*) | 21 | (60,443,040) | (42,727,799) |
| Хүлээн авсан хүү | | 579,971,677 | 548,122,973 |
| Төлсөн хүү | | (435,529,091) | (379,865,380) |
| Төлсөн орлогын албан татвар | | (374,540) | (3,074,551) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | 869,721,216 | (137,518,113) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | | |
| Худалдан авсан хөрөнгө оруулалтын үнэт цаас | 5 | (734,444,700) | (373,254,578) |
| Худалдсан хөрөнгө оруулалтын үнэт цаас | 5 | 231,267,801 | 344,557,792 |
| Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө | 6 | - | (292,383) |
| Худалдсан хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө | 6 | 24,387,146 | 13,769,849 |
| Худалдсан хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 12 | - | 161,600 |
| Худалдан авсан үндсэн хөрөнгө | 10 | (3,980,119) | (146,672,015) |
| Худалдсан үндсэн хөрөнгө | 10 | 7,710 | 420,866 |
| Худалдан авсан биет бус хөрөнгө | 11 | (446,628) | (5,436,596) |
| Худалдсан өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | 13 | - | 618,077 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | (483,208,790) | (166,127,388) |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
**Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан (үргэлжлэл)**
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

| | Тодруулга | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|---|
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | | |
| Буцаан худалдан авах гэрээгээр борлуулсан үнэт цаасны цэвэр өсөлт | 17 | - | 30,161,388 |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | 18 | 529,125,941 | 1,040,459,826 |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эргэн төлөлт | 18 | (851,763,044) | (660,677,024) |
| Гаргасан өрийн бичиг | 19 | 9,978,539 | 482,023,478 |
| Гаргасан өрийн бичгийн эргэн төлөлт | 19 | (234,711,793) | (88,577,893) |
| Хоёрдогч өглөгийн бууралт | 20 | (24,895,300) | (5,044,400) |
| Охин компанийн худалдаж авсан халаасны хувьцаа | 24 | - | (1,583,600) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | (572,265,657) | 796,761,775 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)** | | (185,753,231) | 493,116,274 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 891,288,457 | 398,172,183 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 35 | 705,535,226 | 891,288,457 |

(*) Хуримтлагдсан хүүгийн авлага, хуримтлагдсан хүүгийн өглөгийн өөрчлөлтөөс өөр бусад хөрөнгө, өр төлбөрийн хэлбэлзлийг тус тус илэрхийлнэ.

*Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

1 **Үйл ажиллагаа ба зохион байгуулалт**

Толгой компани болох Худалдаа Хөгжлийн Банк ХХК (“Банк”) болон нэгтгэлд хамрагдсан түүний охин компаниуд (хамтад нь “Групп” гэх)-ийн талаар мэдээллийг дор хураангуйлан харуулав.

**Толгой Компани**

Банк нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд юм. Банк нь Монгол Улсын Банкны тухай хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн №3/149 тоот тушаалаар банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд Монголбанкнаас 2002 оны 02 дугаар сарын 27-ны өдөр №8 тоот тусгай зөвшөөрлийг шинэчилж олгосон.

Дээрх шийдвэрээр тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон дүрмийн дагуу Банк нь мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо, гадаад валют худалдан авах, худалдах болон бусад үйл ажиллагааг өөрийн 23 салбар, 28 тооцооны төвөөр дамжуулан эрхэлж байна.

Банкны нийт хувьцааны 65.83%-ийг толгой компани болох Люксембург хотод үүсгэн байгуулагдсан Globull Investment and Development SCA (“Globull ”) эзэмшдэг. Globull нь бүхэлдээ Америкийн Нэгдсэн Улсад үүсгэн байгуулагдсан US Global Investment LLC (“US Global”)-ийн эзэмшил болно.

**Нэгтгэлд хамрагдсан охин компаниуд**

***(i) Ти Ди Би Капитал ХХК***

Групп өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалттай Ти Ди Би Капитал ХХК-ийг 2008 оны 8 дугаар сарын 14-ний өдөр үүсгэн байгуулсан. Ти Ди Би Капитал ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд Компанийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд брокер диллер, андеррайтер болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа эрхэлдэг.

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн охин компанийн хураангуй санхүүгийн тайлан дараах байдалтай байна:

| | **2017** | | **2016** | |
|---|---|---|---|---|
| | **Мян.төг** | | **Мян.төг** | |
| Охин компаниуд | Хөрөнгө | Өр төлбөр | Хөрөнгө | Өр талбөр |
| Ти Ди Би Капитал ХХК | 39,274,828 | 7,658,573 | 39,188,526 | 6,095,058 |

| | **2017** | | **2016** | |
|---|---|---|---|---|
| | **Мян.төг** | | **Мян.төг** | |
| Охин компаниуд | Үндсэн үйл ажиллагаа-ны орлого | Цэвэр орлого | Үндсэн үйл ажиллагаа-ны орлого | Цэвэр орлого |
| Ти Ди Би Капитал ХХК | 1,649,325 | 1,240,529 | 1,403,632 | 618,589 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

1 **Үйл ажиллагаа ба зохион байгуулалт (үргэлжлэл)**

**Хараат компани болон хамтарсан компаниуд**

***(i) Монгол Женерал Лизинг ХХК***

Монгол Женерал Лизинг ХХК (“Эм Жи Эл Эл”) нь Банк, Ти Ди Би Капитал ХХК болон Японы Эм Жи Лизинг Корпорацийн хамтын эзэмшлийн компани бөгөөд Ти Ди Би Лизинг ХХК-ийн цорын ганц хувьцаа эзэмшигч юм. Эм Жи Эл Эл нь 2013 оны 6 дугаар сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан Хувьцаа Эзэмшигчдийн Гэрээний дагуу ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэхээр байгуулагдсан ба Монгол Улсын Иргэний хууль, Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа эрхэлдэг.

Холбогдох хуулийн дагуу компанийн явуулдаг үйл ажиллагаа нь санхүүгийн түрээсийн үйлчилгээ, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх юм.

***(ii) МИК Холдинг ХК***

Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК нь 2008 онд “Тусгай Зориулалтын Компани А” хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. МИК Холдинг ХК нь “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн толгой компани юм.

Компанийн үндсэн зорилго нь дотоодын болон Олон Улсын зах зээл дээр орон сууцаар баталгаажсан үнэт цаас гаргах, ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх, Монгол Улсын ард иргэдийг орон сууцаар хангах болон орчин үеийн хотуудыг бий болгох зорилго бүхий урт хугацааны санхүүжилтийн тогтолцоог бий болгоход оршино.

***(iii) Нэйшнл Ньюс Корпорэйшн ХХК***

Нэйшнл Ньюс Корпорэйшн ХХК (“ННК”, хуучин Ти Ди Би Медиа ХХК) нь 2011 онд үүсгэн байгуулагдсан. Групп нь 2011 оноос хойш Блүүмберг ТВ Монголиа-ийн үйл ажиллагааг эрхлэхээр Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны тусгай зөвшөөрөл бүхий медиа компани ННК-аар дамжуулан Олон Улсын санхүүгийн мэдээг бэлтгэн дамжуулахаар Блүүмберг Эл-Пи-тэй хамтран ажиллаж байна. 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Групп нь Ти Ди Би Медиа ХХК-ийн хяналтыг авсан. 2016 оны 3 дугаар сард Ти Ди Би Медиа ХХК нь 340,400 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган ННК-тай нэгдсэн. Бизнесийн нэгдлийн дараа Ти Ди Би Медиа ХХК нэрээ ННК болгон өөрчилсөн. 2017 оны 9 дүгээр сард ННК нь шинээр 1,746,900 ширхэг энгийн хувьцаа гаргасан ба Банк болон Ти Ди Би Капитал ХХК нь хөрөнгө оруулалтад оролцоогүй тул Групп нь ННК дахь хяналтын эрхээ алдсан. Хөрөнгө оруулалт нэмж хийсний дараа Групп нь ННК-д мэдэгдэхүйц нөлөөлөлтэй хэвээр байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

1 **Үйл ажиллагаа ба зохион байгуулалт (үргэлжлэл)**

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группын охин компани, хараат компани болон хамтарсан компаниуд дараах байдалтай байна:

| Толгой компани | Нэр | Ангилал | Группын Эзэмшилийн хувь (%) | | Байршил | Тайлагналын өдөр | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 | 2016 | | | |
| Банк | Ти Ди Би Капитал ХХК | Охин компани | 100.00 | 100.00 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Санхүү |
| | ННК ХХК (*1) | Охин компани | 38.64 | 75.89 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Хэвлэл, мэдээлэл |
| | Эм Жи Эл Эл (*2) | Хараат компани | 55.00 | 55.00 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Санхүү |
| | МИК Холдинг ХК (*3) | Хамтарсан компани | 21.85 | 31.27 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Ипотек |
| | JCDecaux ХХК (*4) | - | - | 49.00 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Маркетинг |
| | Таймс Медиа Корпораци ХХК (*4) | - | - | 100.00 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Хэвлэл, мэдээлэл |
| | ННК УБ Омнимедиа ХХК (*4) | - | - | 51.00 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Хэвлэл, мэдээлэл |
| | ЗГММэдээлэл ХХК (*4) | - | - | 100.00 | Монгол Улс | 12 дугаар сарын 31 | Хэвлэх, нийтлэх |

(*1) 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ННК ХХК-ийн хувьцааны 9%-ийг Банк, 66.89%-ийг Ти Ди Би Капитал ХХК тус тус худалдан авсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ННК ХХК-ийн хувьцааны 4.58%-ийг Банк, 34.06%-ийг Ти Ди Би Капитал ХХК тус тус эзэмшиж байна. 2017 онд хувь тэнцүүлээгүй хөрөнгө оруулалтын үр дүнд ННК ХХК нь охин компаниас хараат компани болж өөрчлөгдсөн.
(*2) Хувьцааны 10%-ийг Банк, 45%-ийг Ти Ди Би Капитал ХХК тус тус худалдан авсан.
(*3) 2017 онд Банк нь МИК Холдинг ХК-ийн хувьцааны 9.42%-ийг борлуулж, Группын МИК Холдинг ХК-ийн эзэмшлийн хувь 21.85% болж буурсан.
(*4) 2017 онд ННК дахь хяналтаа алдсантай холбоотойгоор эдгээр аж ахуйн нэгжүүд нь охин болон хараат компаниас хасагдсан болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

2 **Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь**

**Санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн зарчим**

Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-д нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэгдсэн.

СТОУС-д нийцэхгүй, Монголбанкны журмаар зохицуулсан дараах зүйлс байгаа бөгөөд холбогдох тодруулгуудад дэлгэрэнгүй тайлбарласан болно. Үүнд:

- Зээлийн болзошгүй эрсдэлийн сан, авлага, аккредитив, ашиглаагүй зээлийн үүрэг болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн хасагдуулга
- Хойшлогдсон татварын нягтлан бодох бүртгэл

Нэгтгэсэн санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс зөвшөөрч баталсан.

**Хэмжилтийн суурь**

Дараахаас бусад зүйлсийн хувьд нэгтгэсэн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн:

- Бодит үнэ цэнээр хэмжигдэх үүсмэл санхүүгийн хэрэгслүүд
- Бодит үнэ цэнээр хэмжигдэх борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Худалдан авсны дараа бодит үнэ цэнээрээ хэмжигдэх зарим үндсэн хөрөнгө
- Бодит үнэ цэнээр хэмжигдэх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- Бодит үнэ цэнээр хэмжигдэх үнэт металл

**Үйл ажиллагааны болон толилуулгын валют**

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг нэгжийн оронг мянгачилан төгрөгөөр бэлтгэсэн. Группын үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт Төгрөг юм.

**Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ**

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийн дунд нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно. Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг өөрчлөлт хийсэн тухайн жилд болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнд нөлөөлөхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх Группын ашигласан чухал үнэлэмж болон тооцооллын тодорхойгүй байдлын чухал хэсэг нь зээлийн эрсдэлийн сан, санхүүгийн хэрэгслүүдийн үнэлгээ, үндсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ зэрэгтэй холбоотой байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд**

Групп тайлант жилд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хэрэгжүүлж эхэлсэн бодлогоос бусдаар доор хураангуйлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг энд үзүүлсэн бүх тайлант жилүүдэд тууштайгаар мөрдсөн болно.

**Нэгтгэлийн үндэслэл**

***(i) Охин компаниуд***

Охин компаниуд гэж Группын хяналтан дор байдаг аж ахуйн нэгжүүдийг хэлнэ. Групп бусад аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас өгөөж хүртэх зорилгоор санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод нөлөөлөх эрх мэдэлтэй болсон үед хяналт бий болно. Группын өөр компани дахь хяналтыг үнэлэхэд одоогийн байдлаар хэрэгжүүлж эсвэл хөрвүүлж болохуйц боломжит саналын эрх болон түүний нөлөөллийг харгалзан үздэг. Охин компаниудын санхүүгийн тайлангууд нь Группын охин компаниуд дахь хяналт эхэлснээс дуусгавар болох өдөр хүртэл нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулагдсан байна.

***(ii) Хяналтаа алдах***

Групп нь охин компани дахь хяналтыг алдах үед, охин компанийн хөрөнгө болон өр төлбөрийг, мөн бусад холбогдох хяналтын эрхгүй хувь оролцоо болон бусад өмчийн бүрэлдэхүүн хэсгийг үл хүлээн зөвшөөрнө. Үр дүнд үүссэн олз болон гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хяналт алдагдах үед өмнөх охин компанийн авч үлдсэн хувийг бодит үнэ цэнээр хэмжинэ.

***(iii) Групп хоорондын ажил гүйлгээ***

Группын компаниудын дотоодоо буюу өөр хоорондоо хийсэн ажил гүйлгээ, дансны үлдэгдэл болон түүнээс үүссэн хүлээн зөвшөөрөөгүй аливаа орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх явцад устгах бичилт хийн цэвэрлэж тайлагнадаг. Нэгтгэсэн санхүүгийн тайланд групп хоорондын алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх үнэ цэнийн бууралт үүссэн тохиолдолд уг алдагдлыг зардлаар хүлээн зөвшөөрнө.

***(iv) Хяналтын эрхгүй хувь оролцоо***

Охин компани дахь хяналтын эрхгүй хувь оролцоог түүний толгой компанийн эзэмшлийн хувь оролцооноос тусад нь авч үзнэ. Цэвэр ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын бусад хэсгийн бүрэлдэхүүн бүр нь толгой компанийн эзэмшигчид болон тухайн хяналтын эрхгүй хувь оролцоонд хамааралтай байдаг. Үүнд хяналтын эрхгүй хувь оролцоог тэгээс бага болтол бууруулсан нөхцөл мөн адил хамаарна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Бизнесийн нэгдэл**

***(i) Бизнес нэгдэл***

Нэгдмэл хяналтанд байдаг аж ахуйн нэгж болон бизнесийн шинж агуулаагүй нэгдлээс бусад бизнесийн нэгдлийг худалдан авалтын аргаар бүртгэлд тусгана.

Тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

Худалдан авалтын өдрөөр, нэгдэгчийн хяналтын эрхгүй хувь оролцоог нэгдэгчийн цэвэр хөрөнгөд ногдох хяналтын эрхгүй хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хэмжээгээр тодорхойлно.

Бизнесийн нэгдэл дэх шилжүүлсэн зүйлсийг бодит үнэ цэнээр хэмжих ба энэ нь нэгтгэгчээс шилжүүлсэн зүйлсийн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ, нэгтгэгчээс нэгдэгч талын өмнөх эзэмшигчдэд олгох өр төлбөр болон нэгтгэгчийн гаргасан өмчийн хувь оролцооны нийлбэр байдаг.

Аливаа болзошгүй төлбөрийг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ. Санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтонд хамрагдах болзошгүй өр төлбөрийг төлөх үүрэг үүссэн ба энэ нь эздийн өмчөөр ангилагдсан бол дахин хэмжихгүй бөгөөд төлбөр төлсөн тохиолдолд өмчийн бууралтаар бүртгэнэ. Өөрөөр хэлбэл, болзошгүй өр төлбөрийн бодит үнэ цэнийн дараа үеийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

***(i) Гүүдвилл***

Групп нь худалдан авалтын өдрөөрх гүүдвиллийг хэмжихдээ:
- Шилжүүлсэн зүйлсийн бодит үнэ цэнэ; нэмэх нь
- Нэгдэгч талын хяналтын эрхгүй хувь оролцооны хүлээн зөвшөөрсөн дүн; нэмэх нь
- Үе шаттайгаар байгуулсан бизнесийн нэгдлийн хувьд, нэгдэгч талд өмнө эзэмшиж байсан хөрөнгийн хувь оролцооны бодит үнэ цэнэ; хасах нь
- Худалдан авч эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө болон өр төлбөрийн хүлээн зөвшөөрөгдсөн цэвэр дүн (ихэнхдээ бодит үнэ цэнэ)-г оруулан тооцоолно.

Сөрөг гүүдвиллийн үед, тохиролцоот худалдан авалтаас үүссэн олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Групп нь нэмэлт хяналтын эрхгүй хувь оролцоо худалдан авсан тохиолдолд тухайн гүйлгээг өмчийн гүйлгээ гэж үзэх тул гүүдвилл хүлээн зөвшөөрөхгүй.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 <u>Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)</u>**

**Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт**

Хараат компани гэж хөрөнгө оруулагчийн охин компани эсвэл хамтарсан компанийн аль нь ч биш бөгөөд хөрөнгө оруулагч мэдэгдэхүйц нөлөөтэй байдаг аж ахуйн нэгжийг хэлнэ. Мэдэгдэхүйц нөлөөлөл гэж санхүүжигчийн санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны бодлогын талаар шийдвэр гаргахад оролцох эрхтэй бөгөөд өмчийн 20%-иас 50%-ийг эзэмшихийг хэлнэ

Хамтарсан компани гэдэг нь хэлцэлд талууд харилцан ижил эрхтэй бөгөөд цэвэр хөрөнгийн хувьд тэнцүү хариуцлага хүлээхийг хэлнэ. Хамтын хяналт гэж эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг гэрээгээр тохиролцон хуваалцдаг бөгөөд зөвхөн санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны талаар стратегийн шийдвэр гаргахад хяналтыг хуваалцдаг бүх талуудаас нэгдсэн саналтай байхыг шаарддаг тохиолдолд биелдэг.

Хараат болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх ба худалдан авалтын дараа өдрөөс эхлэн хараат болон хамтарсан компанийн ашиг, алдагдал болон өмчийн өөрчлөлтөөс Группт ногдох хувь хэмжээгээр дансны үнийг нэмэгдүүлж, бууруулна. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх үед Групп хоорондын үлдэгдэл, гүйлгээ болон Групп хоорондын ажил гүйлгээнээс үүссэн хэрэгжээгүй орлого ба зарлагыг нэгтгэсэн санхүүгийн тайланд цэвэрлэдэг. Нэгтгэсэн санхүүгийн тайланд Групп хоорондын алдагдлаар хүлээн зөвшөөрөх шаардлагатай үнэ цэнийн бууралт үүссэн тохиолдолд энэхүү Групп хоорондын алдагдлыг зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хэрэв Группын гишүүн компани нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулагдсан ижил нөхцөл байдал бүхий ажил гүйлгээ болон үйл явдлуудыг тухайн нэгтгэсэн тайланд толилуулагдсанаас өөр нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримтлан тайлагнадаг бол нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх явцад өөрийн тусдаа санхүүгийн тайланд зохих залруулгыг хийнэ.

Өмчийн аргаар бүртгэсэн хараат компанийн алдагдлаас Группт ногдох хэсэг нь оруулсан хөрөнгө оруулалтын дүнгээс хэтэрсэн тохиолдолд урт хугацаат хөрөнгө оруулалт гэх мэт хөрөнгө оруулалтын дансны үнийг тэг болтол бууруулах ба үлдсэн алдагдлыг Групп санхүүжүүлсэн эсвэл санхүүжүүлэх үүрэг хүлээснээс бусад тохиолдолд хүлээн зөвшөөрөхгүй.

**Гадаад валютын ажил гүйлгээ**

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар холбогдох Группын компаниудын бүртгэлийн валют руу хөрвүүлэн бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлтийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

Харин борлуулах боломжтой өмчийн хөрөнгө оруулалтын хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү (үнэ цэнийн бууралтаас бусад тохиолдолд, хэрэв үнэ цэнийн бууралтаас үүссэн бол бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн гадаад валютын ханшийн зөрүүг ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилна)-г бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 <u>Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)</u>**

**Санхүүгийн хэрэгслүүд**

***(i) Ангилал***

Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь Группын богино хугацааны дотор худалдах зорилгоор худалдан авч, эзэмшиж байгаа өрийн бичиг, өмчийн үнэт цаас болон бусад үнэт цааснуудаас бүрддэг. Эдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн үүсмэл хэрэглүүрүүдэд үр ашигт хейджийн хэрэгсэл гэж ангилагдаагүй тодорхой үүсмэл хэрэглүүрийн гэрээ хэлцлүүд хамаарч байдаг. Цэвэр авлага (эерэг бодит үнэ цэнэтэй) байдалтай бүхий л арилжааны үүсмэл хэрэглүүрүүд, мөн худалдан авсан опционуудыг арилжааны хөрөнгөөр бүртгэдэг. Харин цэвэр өглөг (сөрөг бодит үнэ цэнэтэй)-ийн байдалтай арилжааны үүсмэл хэрэглүүрүүд болон гаргасан/худалдсан опционуудыг арилжааны өр төлбөрөөр бүртгэдэг.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрт анхны хүлээн зөвшөөрөлтийн үед уг ангилалаар ангилагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд багтдаг. Учир нь 1) энэхүү ангилал нь нягтлан бодох бүртгэлийн үл нийцэх байдлыг үлэмж хэмжээгээр бууруулах буюу цаашлаад арилгадаг, 2) холбогдох санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь ямар нэгэн бүлэг санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн эсвэл хоёулангийн бүлэгт багтдаг, тэдгээрийн гүйцэтгэл нь баримтжуулсан эрсдэлийн менежментийн эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу бодит үнэ цэнийн сууриар үнэлэгддэг, 3) агуулагдсан үүсмэл хэрэглүүр нь нэгтгэсэн байх шалгуурыг хангаагүй байдаг. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь бүртгэж, бодит үнэ цэнэд орсон өөрчлөлтийг тухайн тайлант жилийн үр дүнгээр тусгадаг.

Богино хугацаанд арилжаалах зорилгоор бус харилцагчдад олгосон мөнгийг зээл ба авлага гэж үздэг. Зээл ба авлага нь харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанаас бүрдэх ба буцаан цуглуулах боломжтой дүнгээр буюу эрсдэлийн санг хассан дүнгээр тайлагнадаг. Эрсдэлийн санг Сангийн Яам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу тооцдог. (цаашид “Монголбанкны Эрсдэлийн сан байгуулах журам” гэх)

Дуусах хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгүүд нь тогтмол буюу тодорхой төлбөртэй, тодорхой хугацаатай, Групп нь хугацааг нь дуустал эзэмших зорилготой бөгөөд эзэмшиж боломжтой ба анхнаасаа борлуулах боломжтой эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд юм. Үүнд Группын эзэмшиж буй зарим хөрөнгө оруулалтын үнэт цааснууд багтана.

Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгө гэж санхүүгийн хөрөнгийн бусад ангилалаар ангилагдаагүй, борлуулах боломжтой гэж үзсэн үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

***(ii) Анхдагч хүлээн зөвшөөрөлт***

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан түүний бодит үнэ цэнэ дээр санхүүгийн хөрөнгийг худалдан авах болон санхүүгийн өр төлбөр гаргахтай шууд холбоотой ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэдэг. Энэ тохиолдолд санхүүгийн хөрөнгө нь дараагийн тайлант үед ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэхгүй байх ёстой. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд шууд холбоотой гарах ажил гүйлгээний зардлыг гарсан үед нь ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

***(iii) Дараах үеийн хүлээн зөвшөөрөлт***

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед арилжааны зориулалтаар эзэмшиж буй бүхий л санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн деривативууд, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд, мөн борлуулах боломжит хөрөнгүүдийг үнэ цэнийн бууралтын гарзыг хассан бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэдэг. Харин идэвхитэй зах зээл дээр зарлагадсан үнэ ханшгүй ба бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй хэрэгслүүдийг өртгөөр нь бүртгэдэг. Арилжааны хэрэгслүүд болон борлуулах боломжит хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх олз, гарзыг ашиг, алдагдал болон шууд өмчид тус тус хүлээн зөвшөөрдөг.

Арилжааны бус бүхий л санхүүгийн өр төлбөрүүд, зээл ба авлага, дуусгавар хугацаа дуусах хүртэл эзэмших хөрөнгүүдийг үнэ цэнийн бууралтын гарзыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолдог. Анхны ажил гүйлгээний зардлыг хамруулаад урамшуулал ба хөнгөлөлтийг холбогдох санхүүгийн хэрэгслийн дансны үнэд оруулдаг ба үр ашигт хүүгийн түвшинд үндэслэн хорогдуулдаг.

**Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт**

***(i) Санхүүгийн хөрөнгө***

Групп тухайн санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл тухайн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг эзэмших гэрээний эрхээ бусдад шилжүүлсэн, эсвэл үг мөнгөн гүйлгээг нэг ба түүнээс дээш этгээдэд тодорхой шалгуур хангасан тохиолдолд төлөх үүрэг хүлээх болсон, эсвэл хөрөнгийг эзэмшихтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг бусдад бодитойгоор шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Группын хувьд өмнө нь бүртгэлдээ тусгасан байсан санхүүгийн хөрөнгийг бусдад шилжүүлэх боловч тэдгээр санхүүгийн хөрөнгийн бараг бүх өгөөж болон эрсдэлийг хадгалсан хэвээр үлдэх хэлцэл хийх тохиолдол байдаг. Харин санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой өгөөж болон эрсдэлийг шилжүүлээгүй ч бас өөртөө хадгалж үлдээхгүйгээр тохирсон хэлцлийн хувьд тухайн хөрөнгөнд хяналт тавьж чадахгүй, тухайлбал тухайн шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдаж чадахгүй болсон бол шилжүүлсэн хөрөнгийг бүртгэлээс хасдаг. Харин хөрөнгөд хяналт тавих эрхийг хадгалж үлдсэн бол Групп үг хөрөнгийг өөрийн оролцооны хувь хэмжээгээр, өөрөөр хэлбэл шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөнд хэдий хэмжээгээр өртсөн хувь хэмжээгээр нь бүртгэлдээ хэвээр үлдээнэ.

Дээрх бүртгэлээс хасах шалгуурыг заавал тухайн хөрөнгийн хувьд бүхэлд нь эсвэл бүлэг ижил төстэй санхүүгийн хөрөнгийн хувьд хэрэглэнэ гэхээс илүү хэрвээ тохиромжтой бол хөрөнгийн зарим хэсгийг хэсэгчлэн шилжүүлэх үед ч баримтална. Хөрөнгийн хэсгийг шилжүүлэхэд тэрхүү хэсэг нь тусгайлан тогтоосон мөнгөн урсгал, тухайн хөрөнгийн тодорхой хувь хэсэг эсвэл тусгайлан тогтоосон мөнгөн урсгалын тодорхой хувь хэсэг байх ёстой.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

***(ii) Санхүүгийн өр төлбөр***

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө. Хэрэв одоогийн санхүүгийн өр төлбөрийг ижил зээлдүүлэгчтэй нилээд өөр нөхцөл бүхий өөр санхүүгийн өрийн хэрэгслээр солих, эсвэл одоогийн өр төлбөрийн нөхцлийг нилээд өөрчлөх үед анхны өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч, шинэ өр төлбөр хүлээн зөвшөөрөх ба үүссэн дансны үнийн зөрүүг нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

**Мөнгөн гүйлгээний хейдж**

Хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөртэй, ашиг, алдагдалд нөлөөлөх өндөр магадлалтай төлөвлөгөөт ажил гүйлгээтэй холбоотой тодорхой эрсдэлд хамаарч болзошгүй мөнгөн гүйлгээний хувьсах чанарт хамаарах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн үр нөлөөтэй хэсгийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ дэх өөрчлөлтийн үр ашиггүй хэсгийг шууд ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Хэрэв хейджийн хэрэглүүрийн хугацаа дууссан, худалдсан, дуусгавар болсон эсвэл хэрэгжүүлсэн, мөнгөн гүйлгээний хейджийн шалгуурыг цаашид хангахгүй болсон, мөн хейджийн ангилал хүчингүй болсон тохиолдолд хейджийн нягтлан бодох бүртгэлийг цаашид зогсоодог. Төлөвлөгөөт ажил гүйлгээний хейджийг зогсоох тохиолдолд хейдж үр ашигтай байхад бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан дүнг төлөвлөгөөт ажил гүйлгээ хэрэгжих үед өмчөөс ашиг, алдагдлын тайланд дахин ангилалаар залруулна. Хэрэв төлөвлөгөөт ажил гүйлгээ цаашид хэрэгжихгүй болсон бол бусад дэлгэрэнгүй орлогын үлдэгдлийг шууд дахин ангиллын залруулгаар ашиг, алдагдлын тайлан руу залруулна.

**Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс**

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс нь касс дахь бэлэн мөнгө болон анхны гэрээний хугацаа нь гурван сараас богино хугацаатай, бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд бага өртдөг, богино хугацаат үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг, хязгаарлагдаагүй, банк болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэж байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

3 **Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Үндсэн хөрөнгө**

***(i) Хүлээн зөвшөөрөлт ба дараа үеийн хэмжилт***

Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авалтын үнэ, импортын татвар, нөхөн олгогдохгүй худалдан авалтын татварууд болон хөрөнгийг байршуулах газар болон зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой гарах зардлуудаас бүрддэг. Анх бүртгэлд тусгаснаас хойш бодит үнэ цэнийг нь найдвартай тодорхойлох боломжтой хөрөнгүүдийг дахин үнэлгээний дүнгээр буюу дахин үнэлгээ хийсэн өдрийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг ашиглалтанд оруулснаас хойш гарсан зардлуудыг, тухайлбал засвар үйлчилгээний зардлыг, тухайн зардал гарсан жилийн үр дүнгийн тайланд тусгадаг. Харин тухайн зардал гарснаар хөрөнгийг анх авах үеийн тооцоолсон бүтээмж нэмэгдэж, хөрөнгөөс олох эдийн засгийн ирээдүйн үр өгөөж нэмэгдсэн байвал гарсан зардлыг хөрөнгийн өртөг дээр нэмж капиталжуулна.

Групп дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг дансны үнээс материаллаг зөрүүтэй болгохгүйн тулд дахин үнэлдэг. Дахин үнэлгээний нэмэгдлийг эздийн өмчийн дахин үнэлгээний нөөц дансанд тусгадаг. Харин дахин үнэлгээний бууралтыг тухайн хөрөнгийн хувьд үүссэн өмнөх жилийн нэмэгдлийн дүнг тэг болтол дахин үнэлгээний нөөц дансыг бууруулна. Бусад бүх тохиолдолд дансны үнийн бууралтыг үнэ цэнийн бууралтаар ашиг, алдагдалд бүртгэдэг.

***(ii) Элэгдэл***

Үндсэн хөрөнгийг түүний ашиглагдахаар хүлээгдэж буй ирээдүйд авч ирэх эдийн засгийн үр өгөөжийг нь харгалзсан тооцсон ашиглалтын жилийн хугацаанд нь шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Үндсэн хөрөнгийн тооцсон ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна:

- Барилга — 40-60 жил
- Оффисын тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл — 10 жил
- Компьютер — 3-5 жил

Тайлант үе бүрийн эцэст элэгдэл тооцох арга, ашиглахаар тооцсон жил болон үлдэх өртгийг хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг. Өөрчлөлтийг нь нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж бүртгэдэг.

**Дуусаагүй барилга**

Дуусаагүй барилга нь шинээр барьж эхэлсэн боловч ашиглалтанд ороогүй байгаа барилгын өртгийг илэрхийлдэг. Дуусаагүй барилгад элэгдэл тооцдоггүй.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

3 **Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Биет бус хөрөнгө**

***(i) Худалдан авсан биет бус хөрөнгө***

Худалдан авсан биет бус хөрөнгийг түүний анхны өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнадаг.

***(ii) Хорогдуулга***

Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийг тэдгээрийн тооцоолсон ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулж нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг. Биет бус хөрөнгийн тооцсон ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна:

- Программ хангамж — 3 жил
- Патент — 10 жил

Тайлант үе бүрийн эцэст хорогдуулга тооцох арга болон хугацааг хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг. Өөрчлөлтийг нь нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж бүртгэдэг.

**Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

Түрээсийн орлого болон капиталын үнийн өсөлтөөс ашиг хүртэх зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж үзнэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Ажил гүйлгээтэй холбоотой гарсан зардал нь анхны өртөгт багтана. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг дараа үед бодит үнэ цэнээр нь хэмжиж бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь эзэмшигчийн өөрийн ашиглах үндсэн хөрөнгө рүү эсвэл бараа материал руу шилжихэд бодит үнэ цэнээр тооцогдох өртөг нь тухайн хөрөнгийн ашиглалтын өөрчлөлт гарсан өдрөөрх бодит үнэ цэнэ байна.

Хэрвээ эзэмшигчийн өөрийн ашиглаж буй үндсэн хөрөнгө нь бодит үнэ цэнээр бүртгэгдэх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө рүү шилжих тохиолдолд Групп тухайн хөрөнгийг ашиглалтын өөрчлөлт гарсан өдрөөрх бодит үнэ цэнээр дахин үнэлгээ хийж хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө рүү ангилна.

**Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө**

Барьцааны зүйлийг олж авах эрх үүссэнээр эзэмшсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөр бүртгэнэ. Эрсдэлийн санг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн Яамны хамтарсан тушаалаар батлагдсан Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журмын дагуу тооцоолно. Уг журмын дагуу Группын өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг цаг хугацааны хүчин зүйлд үндэслэн хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй болон муу гэж ангилан 0%, 25%, 50%, 75% болон 100%-ийн болзошгүй эрсдэлийн сан байгуулдаг.

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Үнэ цэнийн бууралт**

Группын активын дансдад үнэ цэнийн бууралт үүссэн шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд тайлант хугацааны эцэст хөрөнгийн дансдын бүртгэлийн дүнг үнэлж, хянадаг. Хэрвээ үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх үнэ цэнийг тооцоолдог.

***(i) Зээл ба авлага***

Зээл ба авлагыг зээлийн болзошгүй эрсдэлийн санг хассан дүнгээр тайлагнадаг. Зээл ба авлагын үлдэгдэлд хийх байнгын хяналт шалгалтын үр дүнд зээл ба авлагын үнэ цэнэ буурсан гэж үзвэл Монголбанкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу болзошгүй эрсдэлийн сан байгуулж, зээл ба авлагын дансны үнийг нөхөгдөх дүн хүртэл нь бууруулдаг. Болзошгүй эрсдэлийн санг нэмэгдүүлэх бичилтийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Зээл төлөгдөхгүй нь тодорхой болсон ба шүүх, эрх зүйн арга хэмжээнүүд дуусгавар болсон үед эцсийн алдагдлын хэмжээг тогтоосон тохиолдолд зээлийг данснаас хасдаг.

Монголбанкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам нь 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр шинэчлэгдсэн бөгөөд уг журмын дагуу Групп нь хугацааны ба чанарын үзүүлэлтүүд дээр үндэслэн зээл ба авлагын чанарыг тодорхойлох ба түүнд үндэслэн нөөц байгуулдаг. Энэхүү аргачлалын дагуу зээлийг ангилах ба хэвийн зээлд 0.5%, хугацаа хэтэрсэн зээлд 1%-5%, хэвийн бус зээлд 5%-25%, эргэлзээтэй зээлд 15%-50%, муу зээлд 50%-100%-аар тус тус эрсдэлийн санг байгуулдаг. Энэ хувь хэмжээ өмнө нь хэвийн зээлд 1%, хугацаа хэтэрсэн зээлд 5%, хэвийн бус зээлд 25%, эргэлзээтэй зээлд 50%, муу зээлд 100% байсан. Өмнөх Монголбанкны Эрсдэлийн сан байгуулах журмын дагуу Групп нь 2014 оны 8 дугаар сарын 27 болон түүнээс хойш олгогдсон хэвийн зээлд 1%-аар (өмнө нь 0% байсан) эрсдэлийн сан байгуулах шаардлагатай ба хадгаламж барьцаалсан зээл болон овернайт зээлийн хувьд 1%-ийн эрсдэлийн сан байгуулдаггүй.

Зээлийг чанарын үзүүлэлтээр ангилахад зээлийн баримтын бүрдүүлэлт, зээлдэгчийн санхүүгийн үзүүлэлтүүд, барьцаа хөрөнгийн үнэлгээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөрчилсөн эсэх зэргийг харгалзан үздэг.

2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр шинэчлэгдсэн Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журмын дагуу Групп нь тэнцлийн гадуур бүртгэлтэй хөрөнгө болон болзошгүй өр төлбөрийн ангилалыг хариуцагчийн чанарын хүчин зүйлд үндэслэн тодорхойлж, эрсдэлийн сан байгуулах үүрэгтэй. Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журам нь тухайн гэрээг хэрэгжүүлэх үлдсэн хугацаанаас хамааран эрсдэлийн хувь хэмжээг тодорхойлох загварыг тогтоосон. Энэхүү загварын дагуу Групп нь 1 жил хүртлэх хугацаанд хэрэгжих тэнцлийн гадуур бүртгэлтэй хөрөнгө болон болзошгүй өр төлбөрийн алдагдалд эрсдэлийн ангилалын хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй болон муу ангилалд тохирох 0%, 25%, 50%, 75% болон 100%-ийн болзошгүй эрсдэлийн санг, 1 жилээс дээш хугацаанд хэрэгжих тэнцлийн гадуур бүртгэлтэй хөрөнгө болон болзошгүй өр төлбөрийн алдагдалд эрсдэлийн ангилалын хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй болон муу ангилалд тохирох 0%, 1%, 15%, 35% болон 75%-ийн болзошгүй эрсдэлийн санг байгуулдаг.

Хэрвээ тайлант хугацааны дараагийн үеүдэд үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан тохиолдолд ашиг, алдагдлын тайланд бүртгэсэн үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаах байдлаар тусгадаг.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

***(ii) Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө***

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн ба үнэ цэнийн бууралтыг нотлох баримт байгаа тохиолдолд бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан алдагдлыг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй байсан ч өөрийн хөрөнгөөс ашиг, алдагдлын тайланд дахин ангилалын залруулгаар ангилна. Ашиг, алдагдлын тайланд бүртгэгдсэн борлуулах боломжтой гэж ангилагдсан өмчийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлын тайлангаар дамжуулан буцаахгүй. Хэрэв дараагийн тайлант хугацаанд борлуулах боломжтой гэж ангилагдсан өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өсөх бөгөөд уг өсөлт нь үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсний дараах үед гарсан тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах ба буцаалтын дүнг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Мөн түүнчлэн, өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө мэдэгдэхүйц хэмжээгээр буурах нь үнэ цэнийн бууралтын үндэслэлтэй нотолгоо болно.

***(iii) Дуусах хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө***

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн дуусах хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг дансны үнэ ба хөрөнгийн анхны үр ашигт хүүгийн хувиар бууруулсан ирээдүйд тооцогдох мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр тооцох бөгөөд ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралттай хөрөнгийн хүү нь хөнгөлөлтийн буцаалтаар дамжуулан хүлээн зөвшөөрөгдсөөр байна. Дараа үед үнэ цэнийн бууралтын гарзын хэмжээ буурах үед үнэ цэнийн бууралтын гарзын бууралтыг ашиг, алдагдлаар буцаана.

***(iv) Санхүүгийн хэрэгслүүдээс бусад хөрөнгө***

Групп тухайн хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст үнэлж тодорхойлдог. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинэ тэмдэг илэрвэл эсвэл тухайн хөрөнгийн хувьд жил бүр үнэ цэнийн бууралтыг үнэлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн хөрөнгийн ирээдүйд нөхөгдөх дүнг тооцоолдог. Нөхөгдөх дүн нь тухайн хөрөнгийн буюу мөнгө үүсгэгч нэгжийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн ба ашиглагдах үеийн үнэ цэнийн аль ихээр тодорхойлогдоно. Ашиглагдах үеийн үнэ цэнийг тодорхойлохдоо тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан өнөөгийн үнэ цэнээр тогтооно. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой үүсэх эрсдэлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Бусад хөрөнгүүдээс хамааралгүйгээр бие даасан мөнгөн урсгалыг бий болгодоггүй хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн харъяалагдах мөнгө үүсгэгч нэгжийн хувьд нөхөгдөх дүнг тодорхойлно. Мөнгө үүсгэгч нэгж буюу хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс их байвал үнэ цэнийн бууралтын гарз үүснэ. Үнэ цэнийн бууралтын гарзыг нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Нөхөгдөх дүнг тооцоход ашигласан үнэлгээ, тооцоололд өөрчлөлт гарсан тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаадаг. Ингэхдээ хөрөнгийн байх байсан дансны үнэ буюу өмнөх үнэ цэнийн бууралтыг оруулахгүйгээр тооцвол байх байсан хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлэхгүй байхаар тооцоолж буцаана. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын бичилтийг нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

3 <u>**Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**</u>

**Буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээнүүд**

Групп нь хоорондоо ижил төстэй хөрөнгө оруулалтыг ирээдүйд тогтмол үнээр, тогтоосон хугацаанд дахин худалдах (худалдан авах) зорилгоор хөрөнгө оруулалтыг худалдан авах (борлуулах) гэрээ хийдэг. Ирээдүйд буцаан худалдах үүрэг амлалттайгаар худалдан авсан хөрөнгө оруулалтыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Харин тэдгээрийг худалдан авахад төлсөн дүнгээр банк болон харилцагчдад олгосон зээл гэж бүртгэдэг. Зээлийн авлагыг худалдан авсан үнэт цаасаар баталгаажсан гэж үзнэ. Репо гэрээний дагуу худалдсан хөрөнгө оруулалтыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөөр байх ба борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө эсвэл борлуулах боломжтой хөрөнгийн аль тохирохоор нь бүртгэж, тайлагнана. Хөрөнгө оруулалтыг худалдсанаар хүлээн авсан мөнгийг бусад банк эсвэл харилцагчдад төлөх өр гэж бүртгэнэ. Хөрөнгө оруулалтыг худалдах, буцаан худалдан авснаас үүсэх зөрүүг хүүгийн орлого эсвэл зардал гэж бүртгэх ба гэрээний хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар хуримтлуулан бүртгэдэг.

**Хувьцаат капитал**

***(i) Энгийн хувьцаа***

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Энгийн хувьцаа, энгийн хувьцааны опцион гаргахтай шууд холбоотой гарсан зардлуудыг татварыг нь суутгасан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг.

***(ii) Халаасны хувьцаа***

Өөрийн хөрөнгөөр бүртгэсэн энгийн хувьцааг эргүүлэн худалдан авахдаа төлсөн, ийнхүү худалдан авахтай холбоотой гарсан бүх зардлуудыг, татварыг нь хассан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг. Эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны хувьцаагаар ангилах ба нийт өөрийн хөрөнгийн бууралт байдлаар харуулдаг. Харин халаасны хувьцааг дахин гаргасан, худалдсан бол хүлээн авсан мөнгөн дүнгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ба тухайн гүйлгээнээс бий болсон илүү ба дутуугийн зөрүүг хуримтлагдсан ашгаас нөхөх эсвэл хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлэх байдлаар бүртгэдэг.

***(iii) Хяналтын эрхгүй хувь оролцоо***

Охин компани дахь өмчийн хөрөнгийг илэрхийлэх, хяналтын эрхгүй хувь оролцоо нь шууд эсвэл шууд бусаар үл хамаарах, толгой компанийн өмчлөх хувьд, СТОУС 3-ийн дагуу анхны нэгдлийн өдөр тооцоолсноор эдгээр хяналтын эрхгүй хувь, анхны нэгдлийн өдрөөс хойш өөрчлөлтүүд 'Бизнес нэгдэл' болон хяналтын эрхгүй хувиас бүрдэнэ.

**Нөөц**

Групп нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед нөөцийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй бол ирээдүйн мөнгөн зарлагын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан нөөцийн дүнг тодорхойлдог. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн өр төлбөртэй холбоотой эрсдэлийн өнөөгийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

3 <u>**Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**</u>

**Сегментийн тайлагнал**

Үйл ажиллагааны сегмент гэж орлого олж, зардал гаргадаг Группын бүрэлдэхүүн хэсгийг хэлэх бөгөөд Группын доторхи бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй хийсэн орлого, зардлын ажил гүйлгээ мөн хамаарна. Сегментэд нөөц хуваарилах, гүйцэтгэлийг үнэлэхтэй холбоотой шийдвэр гаргах зорилгоор Группын үйл ажиллагааны шийдвэр гаргагч ахлах ажилтны зүгээс үйл ажиллагаа нь тогтмол хянаж байдаг ба үйл ажиллагааны сегментийн талаар нэгтгэсэн санхүүгийн мэдээлэл бэлтгэх боломжтой байдаг.

**Орлого**

***(i) Хүүгийн орлого***

Хүүгийн орлого, зардлыг нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг ба хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт өгөөжийг харгалзан үздэг. Хүүгийн орлого, зардал нь хөнгөлөлт ба урамшууллын хорогдол буюу хүүтэй зээлийн хэрэгслийн дансны үнэ ба үр ашигт хүүгийн аргаар хорогдуулснаар төлөгдөх хугацааны эцэст гарах дүн хоорондын зөрүүгээс бүрдэнэ. Гэхдээ Групп зээл олгохтой холбоотой зардлууд болон үйлчилгээний шимтгэлийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулдаггүй, харин төлөгдсөн үед нь ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

***(ii) Хураамж, шимтгэлийн орлого***

Хураамж, шимтгэлийн орлого нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр авч байгаа төлбөр юм. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсэн үед хүлээн зөвшөөрдөг.

***(iii) Түрээсийн орлого***

Түрээсийн орлогыг түрээсийн гэрээний хугацааны туршид нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд шулуун шугамын аргаар бүртгэдэг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн орлогын бүрдэл хэсэг гэж үздэг.

***(iv) Ногдол ашиг***

Ногдол ашгийн орлогыг ногдол ашиг хүртэх эрх нь үүссэн үед бүртгэдэг.

**Үйл ажиллагааны түрээсийн төлбөр**

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн гэрээний хугацааны туршид нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд шулуун шугамын аргаар бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын бүрдэл хэсэг гэж үзэх ба түрээсийн гэрээний хугацааны туршид хорогдуулан бүртгэнэ.

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Орлогын албан татвар**

Орлогын албан татвар нь зөвхөн тайлант жилд ногдуулсан орлогын албан татвараас бүрдэнэ.

Тайлант жилийн татвар гэдэг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод балансын өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын хүлээгдэж буй өр эсвэл авлага болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

2010 оны 5 дугаар сард Сангийн Яамнаас хойшлогдсон татварын зөрүүг зохицуулах тухай журам гаргасан. Гэвч Монгол Улсын татварын алба уг журмыг хэрэгжүүлж эхлээгүй, Татварын хууль тогтоомжид оруулж тусгаагүй. Энэ нь аж ахуйн нэгжүүд, арилжааны банкууд болон татварын байгууллагууд хойшлогдсон татварын талаарх мэдлэг дутмаг байдлаас үүдэлтэй. Энэ журмыг хэрэгжүүлж эхлэхийн тулд тооцооллын аргачлал гаргах, татварын зөвлөхүүдтэй ярилцлага хийх, сургалт зохион байгуулах шаардлагатай. Монголбанк нь хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тооцоолох журам аргачлал боловсруулахаар төлөвлөж байгаа ба арилжааны банкуудын хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн бүртгэл СТОУС-д нийцэхгүй байгаа гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Монгол Улсын Засгийн Газраас зах зээлийн эдийн засаг руу шилжих явцад бизнес болон худалдааны дэд бүтцийн шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлэн хийсээр байна. Үүний үр дүнд, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх хууль, дүрмүүд маш хурдацтай өөрчлөгдсөөр байна. Эдгээр хууль, дүрмийн өөрчлөлтүүд заримдаа төслийн хувьд муу хийгдсэн, өөр өөрөөр тайлбарлаж болохуйц эсвэл татварын албаны үйл ажиллагаатай нийцэхгүй байх тохиолдол байдаг. Ялангуяа, татварууд нь хуулийн дагуу хяналт шалгалт хийх эрх бүхий татварын байгууллагуудын торгууль, шийтгэл ногдуулах үйл ажиллагаатай холбоотой байдаг. Группын удирдлага нь татварын хууль эрх зүйн орчны талаар өөрсдийн мэдлэг, ойлголтон дээр үндэслэн тайлант жилийн эцсээр татвартай холбоотой бүхий л үүрэг хариуцлагаа тооцоолсон гэж үзэж байна. Гэхдээ дээр дурьдсан нөхцлүүдээс шалтгаалан Группт ямар нэг татварын эрсдэл учирч болох ч тэдгээрийг одоогоор тоогоор илэрхийлэх боломжгүй юм.

**Ажилчдын тэтгэмж**

Групп нь улсын нийгмийн даатгалын санд ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс өөр бусад тэтгэмжийг олгодоггүй. Группээс төлөх шимтгэлийг төлөгдсөн үед нь нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

**Мөрдөж эхлээгүй байгаа шинээр гарсан стандартууд ба тэдгээрийн тайлбарууд**

2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хэд хэдэн шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд нь эдгээр санхүүгийн тайланг бэлтгэхэд мөрдөгдөөгүй болно. Группын үйл ажиллагаатай холбогдох стандарт, түүний өөрчлөлтийг доор тусгасан ба эдгээрийг Групп эрт хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй байна.

***(i) СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр***

2015 оны 12 дугаар сард хэвлэгдсэн СТОУС 9 нь одоо мөрдөгдөж байгаа НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт-ийг орлох болсон. СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгийн ангилал, хэмжилтийн талаарх шинэчилсэн удирдамж, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварыг ашиглах талаар болон хейджийн нягтлан бодох бүртгэлийн ерөнхий шинэ шаардлагуудыг агуулсан. Мөн санхүүгийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон үл хүлээн зөвшөөрөлтийн талаарх СТОУС 9-ийн удирдамжийг агуулсан. СТОУС 9 нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн боловч Монголбанкнаас СТОУС 9-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацааг Монгол Улсын арилжааны банкуудын хувьд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулах шийдвэр гаргасан.

Групп нь СТОУС 9-ийн хэрэгжилтээс нэгтгэсэн санхүүгийн тайланд үзүүлэх боломжит нөлөөллийг үнэлж байна.

***(ii) СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого***

2016 оны 01 дүгээр сард хэвлэгдсэн СТОУС 15 нь хүлээн зөвшөөрөх орлогын хэмжээ болон хугацааг тодорхойлсон иж бүрэн тогтолцоог бий болгосон. Энэхүү стандарт нь НББОУС 18 Орлого, НББОУС 11 Барилгын Гэрээ болон СТОУТХ 13 Хэрэглэгчийн урамшууллын хөтөлбөр зэрэг орлого хүлээн зөвшөөрөх удирдамжуудыг орлох болно. СТОУС 15 нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.

Групп нь СТОУС 15-ыг мөрдсөнөөр нэгтгэсэн санхүүгийн тайланд томоохон нөлөө орохгүй гэсэн хүлээлттэй байна.

***(iii) СТОУС 16 Түрээс***

2016 оны 01 дүгээр сард хэвлэгдэн гарсан СТОУС 16 нь НББОУС 17 стандартыг орлоно. СТОУС 16 нь түрээслүүлэгч санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийн аль нэгээр ангилан бүртгэх стандартыг хассан. Оронд нь, бүх түрээсийг НББОУС 17-ын дагуу санхүүгийн түрээстэй адилтган үзэхээр заасан. Өмнө нь үйл ажиллагааны түрээс гэж ангилагдаж байсан түрээсийн хувьд гарсан томоохон өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг өсгөж, зардлын шинж чанар өөрчлөгдөнө. СТОУС 16 нь түрээслэгчийг богино хугацаат түрээс болон бага дүнтэй хөрөнгийн түрээсийн хувьд хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийг шаардаагүй. СТОУС 16 нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эсвэл түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн. Групп нь СТОУС 16-г мөрдсөнөөр үүсэх боломжит нөлөөллийг үнэлж байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**3 <u>Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)</u>**

**Мөрдөж эхлээгүй байгаа шинээр гарсан стандартууд ба тэдгээрийн тайлбарууд (үргэлжлэл)**

***(iv) СТОУС 17 Даатгалын гэрээ***

2017 оны 05 дугаар сард хэвлэгдсэн СТОУС 17 нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, танилцуулга ба тодруулгыг хамарсан нягтлан бодох бүртгэлийн шинэ цогц стандарт юм. Хэрэгжсэн цагт, СТОУС 17 нь 2005 онд хэвлэгдсэн СТОУС 4 Даатгалын Гэрээ (СТОУС 4)-ийг орлох болно. СТОУС 17 нь бүх төрлийн даатгалын гэрээн (амь насны, амь насны бус, шууд даатгал, давхар даатгал гэх мэт)-нд хэрэгжинэ, тэдгээрийг гаргадаг аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамаарах бөгөөд тодорхой баталгаа болон санхүүгийн хэрэгсэлд анхааруулгын оролцооны шинж чанартай.

Хэд хэдэн хамрах хүрээний үл хамаарах зүйлс хэрэгжих болно. СТОУС 17-гийн ерөнхий зорилго нь даатгагчдын хувьд илүү хэрэглээ сайтай, тогтвортой даатгалын гэрээний нягтлан бодох бүртгэлийн загварыг танилцуулах явдал юм. Өмнөх СТОУС 4-ийн дотоод бүртгэлийн бодлогод түлхүү суурилах шаардлагатай харьцуулахад СТОУС 17 нь даатгалын гэрээнүүдийн хувьд бүхий л нягтлан бодох бүртгэлийн чухал хүчин зүйлүүдийг хамарсан дэлгэрэнгүй загвараар хангасан. СТОУС 17-ийн гол цөм нь ерөнхий загварчлал ба энэ нь дараах нэмэлтүүдтэй:

- Шууд оролцооны хүчин зүйл бүхий гэрээний хувьд тусгай зохицуулалт (хувьсах төлбөрийн аргачлал).
- Ихэвчлэн богино хугацаат гэрээний хувьд хялбаршуулсан аргачлал (шимтгэл хуваарилах аргачлал)

СТОУС 17 нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэнэ. Групп СТОУС 9 болон СТОУС 15-ыг хэрэгжүүлж эхэлсэн тохиолдолд СТОУС 17-ийг заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.

Групп нь СТОУС 17-г хэрэгжүүлсэнээр нэгтгэсэн санхүүгийн тайланд томоохон нөлөө үүсэхгүй гэсэн хүлээлттэй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**4 <u>Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө</u>**

| | **2017 Мян.төг** | **2016 Мян.төг** |
|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 62,641,118 | 73,377,054 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө | 218,623,755 | 658,425,089 |
| Монголбанк дахь харилцах (*) | 792,668,509 | 457,020,267 |
| | 1,073,933,382 | 1,188,822,410 |

(*) 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкны шаардлагын дагуу харилцагчаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн хоёр долоо хоногийн дундаж үлдэгдлийн 12 хувиас багагүй нөөцийг Монголбанкинд байршуулах ёстой. Өдрийн дундаж үлдэгдлийн хувьд Групп нь өдөр бүрийн эцэст заавал байлгах нөөцийн 50 хувиас багагүй дүнг байлгах ёстой. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар заавал байх нөөцийн дүн 368,398,156 мянган төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 297,533,953 мянган төгрөг тус тус байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**5 Хөрөнгө оруулалтын үнэт цаас**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| **Борлуулах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас** | | |
| Хаалттай компанийн өмчийн үнэт цаас, өртгөөр (*1) | 443,430 | 443,430 |
| Өмчлөх эрхтэй хөрөнгө, өртгөөр (*2) | 92,257,890 | 92,257,890 |
| Өмчийн үнэт цаас, бодит үнэ цэнээр (*3) | 22,898,445 | 103,732,318 |
| Засгийн Газрын бонд (*4) | 1,870,111 | 55,462,606 |
| Монголбанкны үнэт цаас (*5) | 684,543,820 | 99,891,902 |
| Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас (*6) | 105,177,000 | 57,919,000 |
| | 907,190,696 | 409,707,146 |
| **Дуустал хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас** | | |
| Засгийн Газрын бонд | 992,667,318 | 992,594,073 |
| Монгол Улсын Хөгжлийн Банкны бонд | 126,428,693 | 123,133,998 |
| | 1,119,096,011 | 1,115,728,071 |
| | 2,026,286,707 | 1,525,435,217 |

(*1) Хаалттай компанид оруулсан хөрөнгө оруулалт нь хөрөнгийн биржид бүртгэлгүй компаниудад оруулсан хөрөнгө оруулалтууд бөгөөд өртгөөр нь бүртгэсэн. Тэдгээрийг нийтэд арилжаалдаггүй, зах зээлийн идэвхтэй үнэ байхгүй тул бодит үнэ цэнийг найдвартай тооцоолох боломжгүй юм.

(*2) Групп нь Монголиан Нэйшнл Рийр Ийрт Корпораци ХХК (‘МНРИК’)-ийн хувьцааг Групп болон МНРИК-ийн хувьцаа эзэмшигчийн хооронд байгуулсан гэрээнд МНРИК нь зээлийг эргэн төлөөгүй тохиолдолд хувьцааг Групп руу шилжүүлнэ гэсэн нөхцлийн дагуу худалдан авсан. Групп МНРИК-гийн хувьцааг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөр 100% эзэмшсэн бөгөөд Монголбанкны журмын дагуу борлуулах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас гэж ангилсан. Өмчлөх эрхтэй хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох боломжгүй байсан тул өртгөөр нь бүртгэсэн.

(*3) 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн 4,184,221 мянган төгрөг болон 38,872,036 мянган төгрөгийн хэрэгжээгүй олзыг өмчийн хэсэгт тус тус бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн.

(*4) 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс (3,790) мянган төгрөгийн болон 2,325,918 мянган төгрөгийн хэрэгжээгүй олз (гарз) -ыг тус тус өмчийн хэсэгт бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн.

(*5) Монголбанкны үнэт цаас нь 1-3 долоо хоног хүртэлх богино хугацаатай. Дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо байдаг.

(*6) Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас нь МИК ТЗК-аас гаргасан Монгол Улсын арилжааны банкнуудын шилжүүлсэн 8 хувийн хүүтэй орон сууцны зээлийг илэрхийлнэ. Үнэт цаасныудын хүүгийн хувьд 2017 онд хоёрдогч өр төлбөрт 4.5 хувь, анхдагч өр төлбөрт 10.5 хувь, 2016 онд анхдагч өр төлбөрт 10.5 хувь байна. Дуусах хугацаа нь 20-30 жилийн хугацаатай.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**6 Хараат компани болон хамтарсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалт**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| МИК Холдинг ХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*1) | 44,331,909 | 52,912,775 |
| Эм Жи Лизинг ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*2) | 5,480,743 | 3,562,516 |
| ННК ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*3) | 11,028,612 | - |
| JCDecaux Mongolia ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*4) | - | 3,015,498 |
| | 60,841,264 | 59,490,789 |

(*1) Групп нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд МИК Холдинг ХК-ийн хувьцааг худалдсан. Улмаар дансны дүн нь 20,043,321 мянган төгрөгөөр, Группын МИК Холдинг ХК дахь эзэмшлийн хувь ойролцоогоор 21.85% болж буурсан. 2017 онд ногдол ашиг хүлээн авснаар хөрөнгө оруулалт 2,749,555 мянган төгрөгөөр буурсан. Групп нь МИК-д эзэмших хувьцаанд ногдох ашиг болох 14,212,010 мянган төгрөгийг 2017 онд, 14,335,894 мянган төгрөгийг 2016 онд тус тус хүлээн зөвшөөрсөн. Өмчийн аргыг ашиглахдаа Групп нь МИК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн мэдээллийг ашигласан.

(*2) 2013 онд Групп нь Групп болон Эм Жи Эл корпорацийн хамтарсан компани болох Монгол Женерал Лизинг ХХК (“Эм Жи Эл Эл”)-ийн өмчийн хувь оролцооны 55 хувийг худалдан авах 1,773,610 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан. Гэсэн хэдий ч, холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад хамтын хяналттай талуудыг санал нэгтэй байхыг шаарддаг тул Групп нь Эм Жи Эл Эл-ийг охин компани бус хамтарсан компани гэж үзсэн. Групп нь өмчийн аргыг хэрэгжүүлэхдээ Эм Жи Эл Эл-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн мэдээллийг ашигласан. Групп нь Эм Жи Эл Эл-д эзэмших хувьцаанд ногдох ашиг болох 1,918,227 мянган төгрөгийг 2017 онд, 2,690,677 мянган төгрөгийг 2016 онд тус тус хүлээн зөвшөөрсөн.

(*3) Групп нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ННК ХХК-ийн өмчийн 75.89 хувийг эзэмшиж байна. 2017 оны 9 дүгээр сард ННК нь шинээр 1,746,900 ширхэг энгийн хувьцаа гаргасан ба Групп нь уг хөрөнгө оруулалтанд оролцоогүй тул Групп нь ННК дахь хяналтын эрхээ алдсан. Хөрөнгө оруулалт хийсний дараа Группын ННК дахь хувь оролцоо ойролцоогоор 38.64% болж буурсан. Хувь тэнцүүлээгүй уг хөрөнгө оруулалтын үр дүнд ННК нь охин компаниас хараат компани болж өөрчлөгдсөн. Групп нь энэхүү ажил гүйлгээний дараа ННК дахь эзэмшлийн хувьд ногдох 271,388 мянган төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн.

(*4) 2017 онд ННК ХХК дахь хяналтаа алдсаны үр дүнд JCDecaux Монголиа ХХК нь хараат компаниас хасагдсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**6 Хараат компани болон хамтарсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалт (үргэлжлэл)**

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилүүдийн хараат компаниудын хураангуй санхүүгийн үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

| | 2017 Мян.төг | | 2016 Мян.төг | |
|---|---|---|---|---|
| Санхүүжигч | Хөрөнгө | Өр төлбөр | Хөрөнгө | Өр төлбөр |
| МИК | 2,778,947,860 | 2,612,635,129 | 2,322,484,358 | 2,187,354,486 |
| Эм Жи Эл Эл | 87,739,238 | 77,774,249 | 79,795,265 | 73,317,964 |
| ННК | 41,893,789 | 13,351,833 | 19,870,788 | 7,911,428 |

| | 2017 Мян.төг | | 2016 Мян.төг | |
|---|---|---|---|---|
| Санхүүжигч | Үйл ажиллагааны орлого | Цэвэр орлого | Үйл ажиллагааны орлого | Цэвэр орлого |
| МИК | 216,078,035 | 65,032,240 | 192,685,281 | 50,737,893 |
| Эм Жи Эл Эл | 7,407,715 | 2,860,446 | 6,768,049 | 2,268,114 |
| ННК | 6,253,272 | (2,460,144) | 4,114,361 | (2,766,693) |

**7 Зээл ба урьдчилгаа**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 3,002,411,299 | 2,953,228,405 |
| Гүйцэтгэх удирдлага, захирлууд болон ажилчдад олгосон зээл | 30,495,732 | 35,505,538 |
| | 3,032,907,031 | 2,988,733,943 |
| Зээлийн болзошгүй эрсдэлийн сан | (267,932,462) | (153,566,637) |
| | 2,764,974,569 | 2,835,167,306 |

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилүүдийн зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 153,566,637 | 98,140,610 |
| Нэмж байгуулсан | 114,365,825 | 91,794,836 |
| Эрсдэлийн сангаас хаасан | - | (36,368,809) |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 267,932,462 | 153,566,637 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**7 Зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)**

Групп нь 2017 онд 170,632,476 мянган төгрөг, 2016 онд 61,043,170 мянган төгрөгийн дансны үнэ бүхий ипотекийн зээлийг тус тус МИК ТЗК-д шилжүүлсэн ба энэ ажил гүйлгээ нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан.

Групп нь 2017 онд 5,370,059 мянган төгрөгийн дансны үнэтэй орон сууцны зээлийг Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК руу шилжүүлсэн боловч зээлүүдийн холбогдох эрсдэл, өгөөжийг Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК руу шилжүүлээгүй тул санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй. Тиймээс Групп энэхүү ажил гүйлгээг барьцаат санхүүжилтээр бүртгэсэн ба 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 5,224,622 мянган төгрөг байна. (Тодруулга 18)

Групп 2016 оны 6 дугаар сард Монголбанктай "Дотоодын актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ" ("ДАЧЭБАХ") хөтөлбөрийн гэрээг байгуулсан. ДАЧЭБАХ хөтөлбөрийн зорилго нь нэрлэсэн эдийн засгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, дунд хугацаанд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн эргүүлэн төлөх боломжгүй хоёр зээлдэгчид тусламж үзүүлэх явдал юм. Энэ гэрээний дагуу Монголбанк нь Группын гаргасан өрийн үнэт цаасыг худалдан авсан ба Групп нь зарим зээлийг нэмж олгосон. Түүнчлэн, Групп нь холбогдох зээлдэгчийн активын ангилал, холбогдох эрсдэлийн санг Монголбанкнаас тусгайлан заасан хувь хэмжээгээр байгуулах шаардлагатай ба энэ нь Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журамд заасан хувь хэмжээнээс өндөр байсан.

Монголбанк уул уурхайн салбарын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж Группын уул уурхайн салбарт олгосон стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүдэд олгосон зээлүүдийн зээл, хүүгийн эргэн төлөлтийн зөрчлийг 2017 оны нэгдүгээр улиралд багтаан арилгах үүрэг өгсөн. Түүнчлэн, Монголбанк нь барилгын салбарт олгосон зээлүүдийн ангилалыг бууруулахгүйгээр тогтмол хянаж, тухайн зээлдэгч нарын эргэн төлөлт, бизнесийн үйл ажиллагаа, борлуулалт, санхүүгийн үзүүлэлт, зээлийн төлөлтийн явцыг сар бүр Монголбанкинд тайлагнаж байх үүрэг өгсөн.

**8 Буцаан худалдах нөхцөлтэй гэрээгээр авсан үнэт цаас**

| Харилцагч | Худалдсан огноо | Дуусах огноо | Хүүгийн түвшин | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|---|---|---|
| Транс Банк | 2017.12.28 | 2018.01.02 | 11.0% | 11,981,945 | - |

**9 Хоёрдогч зээл**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Улаанбаатар Хотын Банк | - | 4,000,000 |

Улаанбаатар Хотын Банкинд олгосон зээл нь жилийн 8 хувийн тогтмол хүүтэй, 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр бүрэн төлөгдөж дуусгах нөхцөлтэй.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**10 Үндсэн хөрөнгө**

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

**2017 оны 12 дугаар сарын 31**
***(Мянган төгрөгөөр)***

| | Барилга(*1) | Машин, тоног төхөөрөмж | Компьютер, дагалдах хэрэгсэл | Дуусаагүй барилга (*2) | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Өртөг/дахин үнэлгээ** | | | | | |
| Өртгөөр | 48,018,214 | 13,804,225 | 23,829,662 | 142,199,641 | 227,851,742 |
| Дахин үнэлгээгээр | 126,150,568 | 841,556 | - | - | 126,992,124 |
| 2017.01.01-нээр | 174,168,782 | 14,645,781 | 23,829,662 | 142,199,641 | 354,843,866 |
| Нэмэгдсэн | 161,589 | 274,927 | 2,922,553 | 621,050 | 3,980,119 |
| Хасагдсан | - | (34,071) | (3,786) | - | (37,857) |
| Данснаас хассан | (128,825) | (45,463) | (346,870) | - | (521,158) |
| Нэгтгэлийн цар хүрээний өөрчлөлт | (6,069,773) | (3,283,356) | (75,303) | - | (9,428,432) |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 419,503 | (841,556) | - | - | (422,053) |
| Дахин үнэлгээний алдагдал | (79,865) | - | - | - | (79,865) |
| 2017.12.31-нээр | 168,471,411 | 10,716,262 | 26,326,256 | 142,820,691 | 348,334,620 |
| Үүнээс: | | | | | |
| Өртөг | 41,901,340 | 10,716,262 | 26,326,256 | 142,820,691 | 221,764,549 |
| Дахин үнэлгээ | 126,570,071 | - | - | - | 126,570,071 |
| | 168,471,411 | 10,716,262 | 26,326,256 | 142,820,691 | 348,334,620 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | | |
| 2017.01.01-нээр | 1,366,583 | 4,852,103 | 15,065,697 | - | 21,284,383 |
| Нэмэгдсэн | 3,222,472 | 955,438 | 3,946,573 | - | 8,124,483 |
| Хасагдсан | - | (34,071) | (944) | - | (35,015) |
| Данснаас хассан | - | (38,986) | (341,638) | - | (380,624) |
| Нэгтгэлийн цар хүрээний өөрчлөлт | (355,921) | (763,783) | (35,733) | - | (1,155,437) |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | (3,444,252) | - | - | - | (3,444,252) |
| Дахин үнэлгээний олз | (197,508) | - | - | - | (197,508) |
| 2017.12.31-нээр | 591,374 | 4,970,701 | 18,633,955 | - | 24,196,030 |
| **Үлдэгдэл өртөг** | | | | | |
| 2017.12.31-нээр | 167,880,037 | 5,745,561 | 7,692,301 | 142,820,691 | 324,138,590 |

(*1) Групп нь 2017 онд барилга байгууламжийн ашиглалтын хугацааг хянаж, ижил төрлийн барилга байгууламжийн хувьд тооцоолсон ашиглалтын хугацааг 40 жилээс 60 жил хүртэл нэмсэн. НББОУС 8-ын дагуу өөрчлөлтүүдийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж бүртгэсэн. Эдгээр өөрчлөлтийн үр дүнгээр бодит болон хүлээгдэж буй элэгдлийн зардалд үзүүлэх нөлөө нь материаллаг биш гэсэн хүлээлттэй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**10 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)**

(*2) Дуусаагүй барилга данс нь Группын шинэ оффисын болон салбарын барилгуудаас бүрдэнэ. 2016 оны 6 дугаар сард Групп шинэ оффисын барилгын гэрээг Риверстоун Проперти ХХК-тай байгуулж 136,973,200 мянган төгрөг төлсөн. Риверстоун Проперти ХХК нь одоогоор туслан гүйцэтгэгчдийг томилох үйл ажиллагааг хийж байгаа бөгөөд барилгын үндсэн ажлыг 2018 онд эхлүүлж, 2022 онд дуусгах төлөвлөгөөтэй байна.

**2016 оны 12 дугаар сарын 31**
***(Мянган төгрөгөөр)***

| | Барилга | Машин, тоног төхөөрөмж | Компьютер, дагалдах хэрэгсэл | Дуусаагүй барилга | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Өртөг/дахин үнэлгээ** | | | | | |
| Өртгөөр | 45,524,298 | 13,137,013 | 20,184,676 | 6,258,473 | 85,104,460 |
| Дахин үнэлгээгээр | 134,378,958 | 919,916 | - | - | 135,298,874 |
| 2016.01.01-нээр | 179,903,256 | 14,056,929 | 20,184,676 | 6,258,473 | 220,403,334 |
| Нэмэгдсэн | 3,783,471 | 1,169,320 | 4,535,493 | 137,183,731 | 146,672,015 |
| Хасагдсан | (736,446) | (413,526) | (121,958) | - | (1,271,930) |
| Данснаас хассан | - | (88,582) | (768,549) | - | (857,131) |
| Дахин ангилсан (*1) | 2,574,949 | - | - | (1,242,563) | 1,332,386 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | (11,356,448) | (78,360) | - | - | (11,434,808) |
| 2016.12.31-нээр | 174,168,782 | 14,645,781 | 23,829,662 | 142,199,641 | 354,843,866 |
| Үүнээс: | | | | | |
| Өртөг | 51,146,272 | 13,804,225 | 23,829,662 | 142,199,641 | 230,979,800 |
| Дахин үнэлгээ | 123,022,510 | 841,556 | - | - | 123,864,066 |
| | 174,168,782 | 14,645,781 | 23,829,662 | 142,199,641 | 354,843,866 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | | |
| 2016.01.01-нээр | 305,392 | 3,778,341 | 11,434,824 | - | 15,518,557 |
| Нэмэгдсэн | 4,717,407 | 1,260,513 | 4,494,624 | - | 10,472,544 |
| Хасагдсан | (528,158) | (106,207) | (96,670) | - | (731,035) |
| Данснаас хассан | - | (80,544) | (767,081) | - | (847,625) |
| Дахин ангилсан (*1) | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | (3,128,058) | - | - | - | (3,128,058) |
| 2016.12.31-нээр | 1,366,583 | 4,852,103 | 15,065,697 | - | 21,284,383 |
| **Үлдэгдэл өртөг** | | | | | |
| 2016.12.31-нээр | 172,802,199 | 9,793,678 | 8,763,965 | 142,199,641 | 333,559,483 |

(*1) Группын барилгын зарим хэсгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө рүү дахин ангилсан бөгөөд энэхүү дахин ангилсан хөрөнгийн нийт дүн нь 1,332,386 мянган төгрөг байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**10 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)**

Хараат бус, мэргэжлийн үнэлгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн барилгын хамгийн сүүлийн үеийн үнэлгээний дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

| Үнэлгээний огноо | Хөрөнгийн нэр | Үнэлгээний суурь |
|---|---|---|
| 2015 оны 12 дугаар сарын 31 | Барилга | Зах зээлийн үнэ |
| 2016 оны 12 дугаар сарын 31 | Барилга | Зах зээлийн үнэ |
| 2017 оны 12 дугаар сарын 31 | Барилга | Зах зээлийн үнэ |

Барилгын зах зээлийн үнийг тооцоолсон үнэлгээний арга болон тооцоолол хийхэд ашиглагдсан ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

| Үнэлгээний арга | Ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлт | Ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлт болон бодит үнэ цэнийн хэмжилтийн хоорондын хамаарал |
|---|---|---|
| Зах зээлийн үнийн арга | Жишиг борлуулалтын дундаж үнэ (нэгж: мянган төгрөгөөр 1 м$^2$); Барилга: 300 ~ 7,540 Орон сууц: 937 ~ 4,130 | Тооцоолсон бодит үнэ цэнэ өсնө (буурна) хэрэв: Газар эзэмших эрх, барилга, орон сууцны жишиг зах зээлийн үнэ илүү өндөр (бага) байх |

**11 Биет бус хөрөнгө болон гүүдвилл**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| **Өртөг** | | |
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 14,386,501 | 8,949,905 |
| Нэмэгдсэн | | |
| Программ хангамж | 446,628 | 4,634,105 |
| Патент | - | 802,491 |
| Хасагдсан | (5,676) | - |
| Нэгтгэлийн цар хүрээний өөрчлөлт | (1,796,909) | - |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 13,030,544 | 14,386,501 |
| **Хорогдуулга болон үнэ цэнийн бууралтын алдагдал** | | |
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 9,338,385 | 7,500,166 |
| Тайлант жилийн хорогдуулалт(*1) | 1,480,796 | 1,838,219 |
| Хасагдсан | (5,676) | - |
| Нэгтгэлийн хамрах хүрээний өөрчлөлт | (370,147) | - |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 10,443,358 | 9,338,385 |
| **Үлдэгдэл өртөг** | | |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 2,587,186 | 5,048,116 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

(*1) Программ хангамж болон патентад хорогдуулга тооцсон.

**12 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 88,932,950 | 99,789,000 |
| Худалдсан | - | (588,240) |
| Данснаас хассан | - | (1,151,774) |
| Дахин ангилсан (*) | - | (1,332,386) |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт | 3,027,463 | (7,792,650) |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 91,951,413 | 88,923,950 |

(*) Группын оффисын барилгын зарим хэсэг нь 2016 онд хөрөнгө рүү дахин ангилагдсан.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг хараат бус мэргэжлийн үнэлгээний компани үнэлсэн. Хараат бус, мэргэжлийн үнэлгээчин Группын хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг жил бүр тогтоодог.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн шатлал нь үнэлгээ хийхэд ашиглагдсан мэдээллээс хамаарч гуравдугаар шатлалд ангилагдсан

2017 болон 2016 оны туршид гуравдугаар шатлалаас эсвэл гуравдугаар шатлал руу шилжсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө байгаагүй.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолсон үнэлгээний арга болон тооцоолол хийхэд ашиглагдсан ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

| Үнэлгээний арга | Ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлт | Ажиглах боломжгүй нөлөө бүхий үзүүлэлт болон бодит үнэ цэнийн тооцооллын хоорондын хамаарал |
|---|---|---|
| Зах зээлийн үнийн арга | Жишиг борлуулалтын дундаж үнэ (нэгж: мянган төгрөгөөр 1 м$^2$); Барилга: 5,653 ~ 7,540 | Тооцоолсон бодит үнэ цэнэ өснө (буурна) хэрэв: Барилгуудын жишиг зах зээлийн үнэ өндөр (бага) байх |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**13 Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга | 12,129,207 | 10,960,459 |
| Амины болон нийтийн орон сууц | 1,358,786 | 1,069,616 |
| Хасах нь: Үнэлгээний хасагдуулга | (10,679,687) | (9,835,466) |
| | 2,808,306 | 2,194,609 |

2017 болон 2016 оны тайлант жилд 481,869 мянган төгрөг болон 504,653 мянган төгрөгийн эрсдэлийн санг холбогдох өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө нь төлөгдсөн тул буцаасан ба өмчлөх бусад хөрөнгийн болзошгүй эрсдэлийн сангаас хаагдсан хөрөнгө байхгүй.

**14 Бусад хөрөнгө**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Үнэт металл | 32,149 | 31,334 |
| Хуримтлагдсан хүүгийн авлага | 170,379,528 | 141,186,879 |
| Урьдчилгаа | 3,634,799 | 23,378,378 |
| Хангамжийн материал | 871,872 | 1,954,431 |
| Спот арилжааны авлага | - | 9,146,782 |
| Арилжаалах үүсмэл санхүүгийн хөрөнгө | - | 70,898,721 |
| Хейджийн хэрэглүүр (*1) (*2) (*3) | 314,341,681 | 288,075,402 |
| Дотоод арилжааны тооцооны авлага | 14,042,067 | 13,974,953 |
| Бусад авлага, цэвэр (*4) | 12,119,858 | 53,896,146 |
| | 515,421,954 | 602,543,026 |

(*1) Хейджийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт дэх хойшлогдсон олзын өөрчлөлт дараах байдалтай байна:

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 61,359,941 | 79,843,677 |
| Хойшлуулсан | - | - |
| Хорогдуулга (*) | (18,433,233) | (18,483,736) |
| Эцсийн үлдэгдэл | 42,926,708 | 61,359,941 |

(*) 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд хойшлогдсон олзын хорогдуулгыг мөнгөн гүйлгээний хейджтэй холбоотойгоор үүсмэл санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн үр ашигтай хэсэг гэж үзэн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгэсэн.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**14 Бусад хөрөнгө (үргэлжлэл)**

(*2) Групп 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ам.долларын өрийн бичгээс үүдэлтэй гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалахын тулд 500,000 ам.долаарн үүсмэл хэрэглүүр (Гадаад валютын своп) ашиглан мөнгөн гүйлгээний хейджийг хэрэглэсэн.

(*3) 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилүүдийн мөнгөн гүйлгээний хейджийн үр ашигтай хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн бусад дэлгэрэнгүй орлогын өөрчлөлт дараах байдалтай байна:

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 14,905,402 | 39,938,362 |
| Өссөн | 26,266,279 | 221,742,040 |
| Дахин ангилсан (*) | 31,200,000 | (246,775,000) |
| Эцсийн үлдэгдэл | 72,371,681 | 14,905,402 |

(*) 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилүүдэд ашиг, алдагдал руу дахин ангилагдсан үнэлгээний олз. Хейджийн хэрэглүүрийн олз, гарзын үр ашиггүй хэсгийн хүлээн зөвшөөрсөн дүн нь тэг байна. Групп 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар мөнгөн гүйлгээ өөрчлөгдөх эрсдэлтэй мөнгөн гүйлгээний хейджээр тодорхойлогдсон дериватив хэлцлүүдийн хугацаа нь 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хүртэл байна гэж таамаглаж байна.

(*4) Бусад авлага нь 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 795,115 мянган төгрөг болон 443,131 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралтын гарзыг тус тус хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн.

**15 Харилцагчдын харилцах, хадгаламж**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Харилцах данс | 1,243,670,776 | 857,112,725 |
| Хугацаагүй хадгаламж | 256,649,910 | 272,206,435 |
| Хугацаатай хадгаламж | 1,507,655,252 | 1,181,790,112 |
| Бусад хадгаламж | 62,257,698 | 104,419,834 |
| | 3,070,233,636 | 2,415,529,106 |

Групп харилцах данс болон бусад хадгаламжид хүү тооцдоггүй боловч тогтоосон хязгаараас дээш үлдэгдэл байршуулсан харилцагчийн гадаад валют болон төгрөгийн харилцахад дунджаар жилийн 2.26% болон 3.54% (2016 онд 1.97% ба 3.35%) хувийн хүүг тус тус тооцож олгодог.

Гадаад валютын болон төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү ойролцоогоор 1.92% ба 5.95% (2016 онд 1.95% ба 6.42%) байна.

Гадаад валютын болон төгрөгийн хугацаатай хадгаламжийн жилийн хүү ойролцоогоор 6.23% ба 14.63% (2016: 6.69% ба 14.71%) байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**16 Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Харилцах данс: | | |
| Гадаад валютын харилцах | 34,606,332 | 46,329,176 |
| Төгрөгийн харилцах | 11,209,388 | 985,892 |
| Борлуулах гадаад валютын чек | 12,722 | 8,307 |
| Банкны хадгаламж | 198,079,149 | 95,884,296 |
| | 243,907,591 | 143,207,671 |

**17 Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас**

| Харилцагч | Худалдсан огноо | Дуусах огноо | Хүүгийн түвшин | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|---|---|---|
| МУХБ | 2016.02.08 | 2018.09.21 | 7.5% | 64,960,388 | 64,960,388 |
| МУХБ | 2016.02.08 | 2021.10.06 | 7.5% | 15,000,000 | 15,000,000 |
| МУХБ | 2016.02.25 | 2021.11.23 | 7.5% | 20,000,000 | 20,000,000 |
| МУХБ | 2016.03.03 | 2021.11.29 | 7.5% | 20,000,000 | 20,000,000 |
| МУХБ | 2016.03.23 | 2021.12.14 | 7.5% | 10,000,000 | 10,000,000 |
| | | | | 129,960,388 | 129,960,388 |

Групп Монгол Улсын Хөгжлийн Банк ("МУХБ")-тай байгуулсан буцаан худалдах нөхцөлтэй гэрээний дагуу 129,960,388 мянган төгрөгийн МУХБ үнэт цаасыг буцаан худалдаж авах нөхцөлтэйгээр худалдсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Kreditanstalt fuer Wiederaufbau (KfW) | 4,165,879 | 6,007,564 |
| Дэлхийн Банк | 594,945 | 1,158,663 |
| Азийн Хөгжлийн Банк | 15,359,262 | 4,200,842 |
| Олон Улсын Хөгжлийн Ассоциаци | 1,115,842 | 1,189,341 |
| БНСУ-ын Экспорт, Импортын Банк | - | 1,665,936 |
| БНХУ-ын Экспорт, Импортын Банк | 3,890,984 | 4,537,157 |
| Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг | 27,131,236 | 26,997,352 |
| Атлантик Forfaitierungs AG | 16,807,091 | 13,697,560 |
| ЖДҮХС, Аж үйлдвэрийн яам | 3,307,611 | 9,605,783 |
| Commerzbank AG | 55,695,530 | 103,966,539 |
| ING Bank | - | 1,866,397 |
| Baoshang Bank | 2,687,071 | 35,796,000 |
| Sumitomo Mitsui Banking Corporation | 70,995,831 | 61,483,128 |
| Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани | 4,045,217 | 12,447,650 |
| Монголбанк | - | 1,081,325 |
| Монгол Улсын Хөгжлийн Банк | 261,291,378 | 293,811,162 |
| МБ-ны Ипотекийн Зээлийг Санхүүжүүлэх Хөтөлбөр | 163,720,745 | 217,607,766 |
| Эм Жи Лизинг Корпорэйшн | - | 12,352,880 |
| ХХБ-ны Хамтын Санхүүжилтийн Зээл | 28,173,139 | 57,482,926 |
| Cargill TSF Asia Pte.Ltd | 58,814,851 | 60,164,529 |
| Cargill Financial Services International, Inc | 127,424,325 | 252,189,389 |
| Bank of Tokyo-Mitsubishi UFJ | - | 46,006,219 |
| China Trade Solutions | 1,510,436 | - |
| Exim Bank of Russia | - | 944,196 |
| Erste Group Bank | 1,440,677 | 5,866,636 |
| Banca Popolare Di Sondrio | 27,613,115 | 55,189,158 |
| Banco Popular Espanol | 16,572,301 | 28,106,741 |
| UBI Banca | - | 212,398 |
| OPEC Fund for International Development | 60,405,858 | 61,637,113 |
| Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк | 20,325,499 | 4,249,666 |
| БНХАУ-ын Худалдаа, Аж үйлдвэрлэлийн Банк | - | 1,727,515 |
| БНХАУ-ын Хөдөө Аж Ахуйн Банк | - | 835,336 |
| Монголын Ипотекийн Корпораци ХХК | 5,224,622 | 504,930 |
| Natixis Банк | - | 1,003,229 |
| Чайлизинг Олон Улсын Санхүүгийн Үйлчилгээ | 4,235,559 | 5,713,521 |
| БНХАУ-ын Хөгжлийн Банк | 48,205,091 | - |
| ӨМӨЗО-ы Банк | 1,751,112 | - |
| Promsvyazbank | 12,135,650 | - |
| Transkapitalbank | 15,776,345 | - |
| Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк | 8,252,242 | - |
| Бусад | - | 870,344 |
| | 1,068,669,444 | 1,392,176,891 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Kreditanstalt fuer Wiederaufbau (“KfW”)**

(а) Групп нь Жижиг, дунд үйлдвэрийн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготойгоор ХБНГУ-ын KfW банктай Санхүүжилтийн Гэрээг Монголбанкаар дамжуулан 1997 онд байгуулсан бөгөөд 4,345,981 евро хүртэлх эх үүсвэртэй зээлийн хүрээнд, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч буюу Монголбанкаар дамжуулан жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдад хөнгөлөлттэй нөхцөл, хүүтэйгээр уг төслийн зээлийг олгодог. KfW банкны зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 408,572 евро (1,183,988 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 1,522,389 евро (3,967,025 мянган төгрөг) тус тус байсан. Уг зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 1.25%. Үндсэн зээлийн эргэн төлөлт хагас жил тутамд байдаг бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байдаг.

(б) Дээрх (а) хэсэгт дурьдсан Санхүүжилтийн гэрээний зээлийн эх үүсвэрийн төгрөгөөрх үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 2,981,891 мянган төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 2,040,539 мянган төгрөг байна. Уг төгрөгийн зээлийн эх үүсвэрийн хүү нь Монголбанкны бодлогын хүүтэй тэнцүү байна. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

**Дэлхийн Банк**

(а) Групп нь Сангийн Яамаар дамжуулан хувийн хэвшлийг хөгжүүлэх хоёр дахь төслийн хүрээнд харилцагчдын зээлийг эргэлтийн сангийн хөрөнгөөс 4,000,000 ам.доллар хүртэлх хэмжээгээр санхүүжүүлэх зорилгоор Дэлхийн Банктай дамжуулан зээлдэх гэрээг 2006 онд байгуулсан. Дэлхийн Банкны ам.долларын зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 36,000 ам.доллар (87,377 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 180,000 ам.доллар (448,115 мянган төгрөг) тус тус байна. Тус зээлийн хүү Лондонгийн банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам.долларын (LIBOR) зээлийн хүү дээр жилийн 1 хувийг нэмсэнтэй тэнцүү байх ба үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

(б) Групп дээрх (а) хэсэгт дурьдсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Сангийн Яамаар дамжуулан тодорхой хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор төгрөг болон гадаад валютаар нийт 6,250,000 зээлжих тусгай эрхээс хэтрэхгүй дүнгээр буюу нэмж хуваарилагдах эх үүсвэрээс зээлдэх эрхтэй. Дэлхийн Банкны төгрөгийн зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 156,000 мянган төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 300,000 мянган төгрөг тус тус байна. Энэхүү зээлийн хүү нь Монголбанкнаас зарласан төгрөгийн хугацаагүй хадгаламжийн өмнөх 12 сарын хугацааны дундаж хүүгээр тодорхойлогдох ба үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

(в) Групп Сангийн Яамаар дамжуулан Дэлхийн Банкны сургалтын хөтөлбөрийн зээлийн хүрээнд байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлэх, үүн дотороо зээлийн шинжилгээ, судалгаа, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан дотоод аудитын чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн сургах зорилготойгоор Дэлхийн Банкнаас 300,000 ам.долларын зээлийг авсан. Тус хөтөлбөрийн хүрээнд авсан Дэлхийн Банкны зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 144,849 ам.доллар (351,568 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 164,909 ам.доллар (410,548 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 2% бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлт хагас жил тутам төлөгдөж, 2025 оны 5 дугаар сард дуусгавар болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Азийн Хөгжлийн Банк**

(а) Группын нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийг шинэчлэх зорилгоор Монголбанкаар дамжуулан Азийн Хөгжлийн Банкнаас 134,164 ам.долларын зээлийг 1999 онд авсан. Зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 62,610 ам.доллар (151,962 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 67,082 ам.доллар (167,002 мянган төгрөг) тус тус байна. Тус зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 1% ба үндсэн зээлийн эргэн төлөлт 2002 онд эхэлж, 30 жилийн туршид жилд нэг удаа төлөгдсөнөөр 2031 онд дуусгавар болно.

(б) Групп хөдөө аж ахуй, хөдөөг хөгжүүлэх зорилготой оролцогч аж ахуйн нэгжүүдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх дэд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, ажил, зөвлөх үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх зорилгоор Сангийн Яамаар дамжуулан олгох Азийн Хөгжлийн Банкны эх үүсвэрээс 11,000,000 ам.доллар хүртэлх дүнтэй эх үүсвэр татан төвлөрүүлэхээр Азийн Хөгжлийн Банктай 2011 онд Санхүүжилтийн гэрээг байгуулсан. Зээл 2018 оны 6 дугаар сард эргэн төлөгдөж дуусах ба жилийн хүү нь 12% хүртэл байна. Групп мөн төгрөгийн зээл авч болно. Зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 250,000 мянган төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 675,000 мянган төгрөг тус тус байна. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

(в) 2016 онд өөр эх үүсвэрийн хөрөнгөөс зээл олгох нэмэлт санхүүжилтийн гэрээг Худалдаа Хөгжлийн Банк болон Сангийн Яам хооронд байгуулсан. Нэмэлт гэрээний дагуу Групп нь 41,187,500 ам.доллар хүртэл зээлийг Азийн Хөгжлийн Банкнаас хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн дэмжих зорилгоор Сангийн Яамаар дамжуулан авах боломжтой. Дэд зээлийн хугацаа 2024 оны 01 дүгээр сард дуусах ба жилийн тогтмол хүү нь төгрөгийн 8% ба ам.доллар-ийн 7% хүртэл байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 14,957,300 мянган төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,358,840 мянган төгрөг тус тус байна.

**Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (“ОУХА”)**

Групп Norwegian Banking Resources Ltd. ("NBR")-тэй байгуулсан Твининг гэрээг санхүүжүүлэхээр ОУХА-аас 600,000 ам.долларын зээлийг 1998 онд авсан. ОУХА-ын зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 459,737 ам.доллар (1,115,842 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 477,737 ам.доллар (1,189,341 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 1% бөгөөд үндсэн зээлийн эргэн төлөлт 2007 оны 8 дугаар сард эхэлж, 2037 оны 2 дугаар сард дуусгавар болно.

**БНСУ-ын Экспорт-Импортын Банк**

Групп 2004 онд БНСУ-ын Экспорт-Импортын Банктай Банк Хоорондын Экспортын Зээлийн Гэрээг байгуулсан ба уг гэрээний хүрээнд 2,000,000 ам.долларыг БНСУ-ын экспортлогчдоос бараа, ажил үйлчилгээ худалдан авах харилцагчдыг санхүүжүүлэх зорилготой. Зээлийн дээд хэмжээ 2012 оны 7 дугаар сараас 30,000,000 ам.доллар болж өссөн боловч 2016 оны 7 дугаар сард 20,000,000 ам.доллар болж буурсан. Зээлийн хүүгийн хэмжээг зээл авах бүрт Экспорт-Импортын Банк харилцан адилгүй тогтоодог. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна. Шугамын зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 669,177 ам.доллар (1,665,936 мянган төгрөг) байна. Зээл нь бүрэн эргэн төлөгдсөн бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр үлдэгдэлгүй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 <u>Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)</u>**

**БНХАУ (Тайвань)-ын Экспорт-Импортын Банк**

Групп 2004 онд БНХАУ-ын Экспорт-Импортын Банктай Дамжуулан Зээлдүүлэх Гэрээ байгуулсан ба уг гэрээний хүрээнд 5,000,000 ам.долларыг Тайвань Улсын экспортлогчдоос тоног төхөөрөмж болон бусад бараа материал худалдан авсан харилцагчдыг санхүүжүүлэх боломжтой юм.

Групп нь 2017 онд эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах зорилгоор Дамжуулан Зээлдүүлэх Хөтөлбөрт дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

(а) Ажил гүйлгээ бүрийн зээлийн хэмжээ:

Шаардлага хангасан импортын ажил гүйлгээ бүрт олгох зээлийн хэмжээ нь нийт худалдан авах үнийн дүнтэй тэнцэх хэмжээнээс хэтрэхгүй. Өмнөх санхүүжилтийн хувь хэмжээ нь нийт худалдан авах үнийн дүнгийн 85% хүртэлх хэмжээг нэмэгдүүлсэн.

(б) Зээлийн хугацаа:

Зээлийн бүрийн хугацаа нь Группын үндэслэлтэй хүсэлтийн дагуу зургаан (6) сараас таван (5) жил хүртэл байна. Хэрэглээний болон хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний өмнөх хязгаарлалтыг чөлөөлсөн.

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,603,121 ам.доллар (3,890,984 мянган төгрөг) болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,822,495 ам.доллар (4,537,157 мянган төгрөг)-ын зээлийн үлдэгдэлтэй байна. Тус зээлийн хүү нь Лондонгийн банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам.долларын (LIBOR) зээлийн суурь хүү дээр жилийн 1.25 хувийг нэмсэнтэй тэнцүү байна. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна.

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг ("ЖАЙКА")**

(а) Групп жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, байгаль орчныг хамгаалах зээлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор Сангийн Яамаар дамжуулан 2,981,000,000 иентэй тэнцэх хэмжээний төгрөгийн болон ам.долларын зээл авах эрхтэйгээр дамжуулан зээлдүүлэх гэрээг 2006 онд ЖАЙКА-тай байгуулсан. ЖАЙКА-ийн ам.долларын зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 53,500 ам.доллар (129,852 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 83,500 ам.доллар (207,876 мянган төгрөг) тус тус байна. Тус зээлийн хүү Лондонгийн банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам.долларын (LIBOR) зээлийн хүү дээр жилийн 1 хувийг нэмсэнтэй тэнцүү байх ба үндсэн зээлийн дуусгавар огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

(б) Дээрх зээлийн гэрээний дагуу авсан төгрөгийн зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,352,876 мянган төгрөг болон 1,951,120 мянган төгрөг тус тус байна. Төгрөгийн зээлийн хүү нь Монголбанкнаас зарласан төгрөгийн хугацаатай хадгаламжийн өмнөх 12 сарын хүүгийн дундаж хүүтэй тэнцүү байна. Үндсэн зээлийн дуусгавар огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 <u>Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)</u>**

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг ("ЖАЙКА") (үргэлжлэл)**

(в) Групп жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, байгаль орчныг хамгаалах зээлийн төслийн хоёрдугаар үе шатыг санхүүжүүлэх зорилгоор Сангийн Яамаар дамжуулан 5,000,000,000 иентэй тэнцэх хэмжээний төгрөгийн болон ам.долларын зээл авах эрхтэйгээр дамжуулан зээлдүүлэх гэрээг 2011 онд ЖАЙКА-тай байгуулсан. ЖАЙКА-ийн ам.доллар болон төгрөгийн зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 873,000 ам.доллар (2,118,885 мянган төгрөг) болон 23,529,623 мянган төгрөг байсан ба 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,076,500 ам.доллар (2,679,979 мянган төгрөг) болон 22,158,377 мянган төгрөг тус тус байсан. Зээлийн хүү нь Монголбанкнаас зарласан төгрөгийн хугацаатай хадгаламжийн өмнөх 12 сарын хүүгийн дундаж хүүтэй тэнцүү байх ба үндсэн зээлийн дуусгавар огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

**Атлантик Forfaitierungs AG ("AF")**

Групп 2009 онд тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хэрэглэгчдийн зээлийг санхүүжүүлэх зорилгоор AF-тэй зээлийн гэрээ байгуулсан. Энэхүү зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6,924,677 ам.доллар (16,807,091 мянган төгрөг) болон 5,502,067 ам.доллар (13,697,560 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн хүүгийн хэмжээг зээл авах бүрт AF харилцан адилгүй тогтоодог. Үндсэн зээлийн дуусгавар огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Аж үйлдвэрийн яам**

(а) Групп 2009 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-тай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. ХХААХҮЯ нь энэхүү хөтөлбөрт зориулж 30,000,000 мянган төгрөг төсөвлөсөн ба батлагдсан санхүүжилтийн дүн нь Монгол Улсын бүх арилжааны банкуудад хамааралтай буюу арилжааны банк тус бүрт санхүүжилтийн эрх тусгайлан батлаагүй. 2010 болон 2011 онд Групп уг хөтөлбөрт үргэлжлүүлэн оролцож хамтран ажилласан бөгөөд хөтөлбөрийн нийт төсөв 2010 онд 60,000,000 мянган төгрөг, 2011 онд 150,000,000 мянган төгрөг болж нэмэгдсэн. Энэ зээл нь жилийн 1.2 хувийн тогтмол хүүтэй. Групп 2016 оны 02 дугаар сард жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-тай дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл нь 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,071,608 мянган төгрөг болон 1,619,017 мянган төгрөг тус тус байна. Зээлийн эх үүсвэрийн жилийн тогтмол хүү 7% байна. Үндсэн зээлийн дуусгавар огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Групп 2013 онд Аж Үйлдвэрийн Яамтай шинээр дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Зээлийн хугацаа 2017 оны 12 дугаар сард дуусах ба Монгол Улсын Хөгжлийн Банкны санхүүжилтээс хамааран жилийн 1.8 хувийн тогтмол хүүтэй олгогдсон. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар уг хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлт хийгдэж дууссан ба 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,548,930 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

(б) 2011 оны 10 дугаар сард Групп ХХААХҮЯ-тай ноос, ноолуурын салбарыг хөгжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. ХХААХҮЯ нь энэ хөтөлбөрт зориулж 150,000,000 мянган төгрөгийг төсөвлөсөн. Зээл нь жилийн 0.6 хувийн тогтмол хүүтэй бөгөөд зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,186,100 мянган төгрөг байсан ба төсөл 2017 онд дууссан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Аж үйлдвэрийн яам (үргэлжлэл)**

(в) Групп 2014 оны 8 дугаар сард Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор экспортыг дэмжих, импортыг орлох хөтөлбөр (888 төсөл)-ийн хүрээнд Аж Үйлдвэрийн Яамтай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Уг хөтөлбөрийн 2.0 тэрбум төгрөг хүртэлх дүнтэй төслүүдийг Аж Үйлдвэрийн Яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан хэрэгжүүлсэн ба Монгол Улсын Хөгжлийн Банк санхүүжүүлсэн. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31- ний өдрийн байдлаар 2,236,003 мянган төгрөг 3,251,736 мянган төгрөг тус тус байна. Тус зээлийн жилийн хүү тогтмол 3.0% ба үндсэн зээл эргэн төлөгдөх хугацаа нь дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна.

**Commerzbank AG**

Групп 2011 онд Commerzbank AG банктай импорт, экспортын ажил гүйлгээг санхүүжүүлэхээр харилцагчдад дамжуулан зээлдүүлэх зорилгоор Худалдааны Санхүүжилтийн Мастер Гэрээг байгуулсан. Зээлийн хэмжээ, зээл авах валют, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөгдөх огноо болон бусад нөхцлүүдийг Групп тухайн зээлдэгчийн нөхцлийг харгалзан тохиролцоно. Зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 16,241,605 ам.доллар (39,420,487 мянган төгрөг) болон 5,616,209 евро (16,275,043 мянган төгрөг) байна. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 34,209,760 ам.доллар (85,166,223 мянган төгрөг) болон 7,214,824 евро (18,800,316 мянган төгрөг) байна. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

**ING Bank**

Групп 2011 онд ING Банкнаас 15,000,000 евро хүртэлх зээл авах эрхтэй худалдааны санхүүжилтийн шугамын гэрээ байгуулсан ба дамжуулан зээлдүүлэх эсвэл аккредитив гаргах зорилготой. Зээлийн хэмжээ, зээл авах валют, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөгдөх огноо болон бусад нөхцлүүдийг Групп тухайн зээлдэгчийн нөхцлийг харгалзан тохиролцоно. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна. Энэхүү гэрээний дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 716,250 евро (1,866,397 мянган төгрөг)-ийн зээлийн үлдэгдэлтэй байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн бөгөөд үлдэгдэл байхгүй байна.

**Baoshang Bank**

(а) Групп 2016 оны 8 дугаар сард CNY банк хоорондын зээлийн Ерөнхий Нөхцөлтэй Мастер Гэрээг байгуулсан ба Baoshang Банкнаас юанийн санхүүжилт авах боломжтой болсон. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банк хоорондын зээл 100,000,000 юань (35,796,000 мянган төгрөг)-ийн зээлийн үлдэгдэлтэй байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн бөгөөд үлдэгдэлгүй байна.

(б) 2017 оны 5-р сард Групп нь Baoshang Банктай дахин санхүүжүүлэх гэрээг байгуулсан бөгөөд үүнд Баотош банкны зээлийг бусад зээлдэгчид олгохоор болсон. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 938,694 ам.доллар (2,278,333 мянган төгрөг) болон 1,100,000 юань (408,738 мянган төгрөг) тус тус байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Sumitomo Mitsui Banking Corporation ("SMBC")**

Групп 2012 оны 3 дугаар сард SMBC-тай Аккредитивын санхүүжилтийн гэрээг байгуулсан ба харилцагчдад дамжуулан зээлдүүлэх зорилгоор 45,000,000 ам.доллар хүртэлх зээлийн санхүүжилтийг авах боломжтой. Эргэн төлөлтийн хугацаа болон хүүгийн түвшин нь 12-оос 18 хүртэлх сарын зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 24,747,422 ам.доллар (60,065,211 мянган төгрөг) болон 507,692,500 иен (10,930,620 мянган төгрөг) байсан ба 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 18,654,494 ам.доллар (46,440,923 мянган төгрөг), 174,982 евро (455,966 мянган төгрөг) болон 688,354,815 иен (14,586,239 мянган төгрөг) байна. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн огноо харилцагчдад олгосон зээлийн огнооноос хамааран харилцан адилгүй байна.

**Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани (“НХСК”)**

Групп 2012 оны 6 дугаар сард НХСК-тэй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дамжуулан зээлдүүлэх зорилгоор 10,000,000 ам.доллар хүртэлх зээл авах гэрээ байгуулсан. Ам.долларын зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,666,667 ам.доллар (4,045,217 мянган төгрөг) болон 5,000,000 ам.доллар (12,447,650 мянган төгрөг) тус тус байна. Эргэн төлөлтийг хагас жил тутам хийх ба эргэн төлөлтийн сүүлийн хугацаа нь 2018 оны 4 дүгээр сар байна.

**Монголбанк**

“Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Групп Монголбанктай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан ба 2012 оноос хойш уг хөтөлбөрт оролцогч банкаар хамтран ажиллаж байгаа. Уг хөтөлбөр нь дараах дөрвөн дэд хөтөлбөрөөс бүрдэнэ: i) Хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах; ii) Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах; iii) Импортын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өртгийг бууруулах; iv) Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах. Групп ноолуурын салбарыг дэмжих зорилгоор 2014 онд Монголбанктай шинээр дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Энэхүү зээл нь жилийн 6.0-аас 9.5 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Групп Монголбанкны “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд 51 дэд зээлдэгчид уян хатан нөхцөл бүхий дэд хөтөлбөрийн зээлийг амжилттай дамжуулан зээлдүүлсэн. Дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас авсан зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,081,325 мянган төгрөг байсан бөгөөд 2017 оны 5 дугаар сард төсөл хэрэгжиж дууссан байна.

**Монгол Улсын Хөгжлийн Банк**

(а) Групп арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эд худалдан авалт, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2014 оны 7 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн Банктай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Энэ зээл нь жилийн 5.0 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Групп энэ хөтөлбөрийн хүрээнд 2014 болон 2015 онд 9 дэд зээлдэгчид санхүүжилтийг амжилттай дамжуулан зээлдүүлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн Банкнаас авсан зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,969,241 мянган төгрөг болон 2,874,994 мянган төгрөг тус тус байна. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Монгол Улсын Хөгжлийн Банк (үргэлжлэл)**

(б) Групп экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн төсөл (888 төсөл)-ийн хүрээнд өндөр дүнтэй төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн Банктай 2014 оны 7 дугаар сард дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Монгол Улсын Хөгжлийн Банк нь 2.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй төслийг санхүүжүүлсэн. Энэ зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 50,505,400 мянган төгрөг болон 56,573,000 мянган төгрөг тус тус байна. Энэ зээл нь жилийн 5.0 хувийн тогтмол хүүтэй. Үндсэн зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна.

(в) Групп экспортыг дэмжиж, импортыг орлох болон ажлын байр бий болгох хөтөлбөрийн хүрээнд 2015 оны 6 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн Банк, Аж Үйлдвэрийн Яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн Банк санхүүжүүлж, Аж Үйлдвэрийн Яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан хэрэгжүүлсэн. Энэ зээл нь жилийн 6.0 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй ба эргэн төлөлт хийх эцсийн хугацаа нь 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдөр байна. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 8,174,713 мянган төгрөг болон 13,331,652 мянган төгрөг тус тус байна.

(г) Групп ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсын Хөгжлийн Банктай 2015 оны 6 дугаар сард дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Монгол Улсын Хөгжлийн Банк энэхүү хөтөлбөрт зориулж 100,000,000 мянган төгрөг төсөвлөсөн. Энэ зээл нь жилийн 6.0 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 12,600,000 мянган төгрөг байсан бөгөөд төсөл 2017 онд хэрэгжиж дууссан байна.

(д) Групп экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих чиглэлийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн Банктай 2015 оны 9 дүгээр сард дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. 2017 оны 9 дүгээр сард зээлийн гэрээний тохиролцоонд ам.долларын өөрчлөлт орсон бөгөөд Групп нь зээлийг төгрөгөөс гадна ам.доллараар зээлэх боломжтой болсон. Монгол Улсын Хөгжлийн Банк энэ хөтөлбөрт зориулж 300,000,000 мянган тэрбум төгрөг төсөвлөсөн. 2017 оны 9 дүгээр сард зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, төгрөгийн зээлээс гадна ам.долларын зээл авахаар шинэчилсэн. Зээлийн хүү нь тогтмол бөгөөд төгрөгийн зээлийн хувьд жилийн 6.0 хувь, ам.долларын зээлийн хувьд 8.65 хувь байна. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төгрөгийн зээл 10,386,000 мянган төгрөг, ам.долларын зээл 776,528 ам.доллар (1,884,733 мянган төгрөг) болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 11,745,000 мянган төгрөг тус тус байна.

(е) Групп Ази, Европын дээд түвшний уулзалтанд зориулан барьж буй АСЕМ Вилла төсөл болон төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудыг санхүүжүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлэх зорилгоор 2015 оны 9 болон 12 дугаар саруудад Монгол Улсын Хөгжлийн Банктай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Монгол Улсын Хөгжлийн Банк энэ хөтөлбөрт зориулж нийт 275 тэрбум төгрөг төсөвлөсөн. Энэ зээл нь жилийн 4.5 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд дэд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 176,197,541 мянган төгрөг болон 182,836,816 мянган төгрөг тус тус байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Монгол Улсын Хөгжлийн Банк (үргэлжлэл)**

(ё) Групп 2016 оны 4 дүгээр сард шинэ зээлийн санхүүжилтийн гэрээг Монгол Улсын Хөгжлийн Банктай “Мах” хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан. Энэхүү санхүүжилтийн гэрээг Монгол Улсын Хөгжлийн Банк 25 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөсөн. Зээл нь жилийн 9.5 хувийн тогтмол хүүтэй ба зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 11,046,400 мянган төгрөг болон 11,681,400 мянган төгрөг тус тус байна.

(ж) Групп 2016 оны 4 дүгээр сард шинэ зээлийн санхүүжилтийн гэрээг Монгол Улсын Хөгжлийн Банктай “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулах” хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан. Энэхүү санхүүжилтийн гэрээг Монгол Улсын Хөгжлийн Банк 25 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөсөн. Зээл нь жилийн 9.0 хувийн тогтмол хүүтэй ба зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,127,350 мянган төгрөг болон 2,168,300 мянган төгрөг тус тус байна.

**Монголбанкны Ипотекийн Зээлийг Санхүүжүүлэх Хөтөлбөр**

Групп 2013 онд Монголбанктай “Монголбанкнаас арилжааны банкуудад олгох ипотекийн зээлийн санхүүжилт”-ийн гэрээг байгуулсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь амьжиргааны дундаж түвшний амьдралтай иргэдийг дэмжих болон эдгээр иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлснээр эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэх явдал юм. 2017 оны 6 дугаар сараас эхлэн Сангийн Яам санхүүжүүлж эхэлсэн. Уг зээлийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Монголбанкнаас санхүүжүүлсэн зээлийн үлдэгдэл 138,273,907 мянган төгрөг, Сангийн Яамнаас санхүүжүүлсэн зээлийн үлдэгдэл 25,446,838 мянган төгрөг бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл 217,607,766 мянган төгрөг тус тус байсан.

**Эм Жи Лизинг Корпорэйшн**

Групп Shima Seiki MFG Ltd компаниас машин механизм худалдан авч буй Монгол Улсын нэхмэлийн компаниудыг санхүүжүүлэх зорилгоор Эм Жи Лизинг Корпорэйшн-тай 2013 оны 9 дүгээр сард 1,000,000 ам.долларын зээлийн гэрээг байгуулсан. Энэхүү зээл нь 2015 оны 9 дүгээр сард бүрэн төлөгдөж дууссан. Групп мөн 2015 оны 12 дугаар сард 5,000,000 ам.долларын зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн хүүгийн хэмжээг зээл олгох бүрт Эм Жи Лизинг Корпорэйшн харилцан адилгүй тогтоодог. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,961,932 ам.доллар (12,352,880 мянган төгрөг) байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн бөгөөд үлдэгдэлгүй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)

**Худалдаа Хөгжлийн Банкны Хамтын Санхүүжилтийн Зээл**

Групп 2013 оны 9 дүгээр сард Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани (“НХСК”)-тай А/Б хамтын санхүүжилтийн нөхцөлтэй зээлийн гэрээ байгуулсан. Нийт 82,000,000 ам.долларын хамтын санхүүжилтийн нөхцөлтэй зээл нь 2 хэсгээс бүрдэнэ: НХСК-ийн зохион байгуулж, Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк хамтарсан 35,000,000 ам.долларын хөгжлийн зээлийн хэсэг (“А” зээл); ING Bank N.V болон Ти Ди Би Капитал ХХК-ийн зохион байгуулсан 47,000,000 ам.долларын арилжааны зээлийн хэсэг (“Б” зээл). “Б” зээлийн оролцогчид нь AKA Ausfuhrkredit, Bank of Tokyo-Mitsubishi UFJ, Ltd., VTB Moscow, Commerzbank, Атлантик Forfaitierungs, Эм Жи Лизинг Корпорэйшн болон Чайлизинг Групп зэрэг байна. Энэхүү зээлийг Группын харилцагчдад олгодог зээлийг оролцуулан ерөнхий санхүүжилтийн хэрэгцээг санхүүжүүлэхэд ашиглана. Зээлийн үндсэн төлбөр нь гэрээний дагуу төлөгдөх ба зээлийн хүүг 2018 оны 9 дүгээр сар хүртэл хагас жил тутам төлнө. Зээл бүрийн хүүгийн түвшин нь нэг жилд ногдох хувиар илэрхийлэгдэх ба LIBOR болон ахиу хүүгээс бүрдэнэ. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 11,607,594 ам.доллар (28,173,139 мянган төгрөг) болон 23,089,871 ам.доллар (57,482,926 мянган төгрөг) тус тус байна.

**Cargill TSF Asia Pte. Ltd**

Групп 2014 оны 5 дугаар сараас хойш импортын бараа материалын худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор худалдааны зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулсан. Зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 24,232,262 ам.доллар (58,814,851 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 24,167,023 ам.доллар (60,164,529 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн хүүгийн хэмжээг зээл олгох бүрт Cargill TSF Asia Pte.Ltd харилцан адилгүй тогтоодог. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна.

**Cargill Financial Services International, Inc**

Групп 2014 оны 12 дугаар сар, 2015 оны 5 дугаар сар болон 2015 оны 11 дүгээр саруудад импортын бараа материалын худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор худалдааны зээлийн санхүүжилтийн гэрээ байгуулсан. Энэхүү гэрээнүүд нь 2 жилийн хугацаатай тус бүр 25,000,000 ам.доллар, 8,800,000 ам.доллар болон 51,500,000 ам.долларын санхүүжилт байна. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 52,500,000 ам.доллар (127,424,325 мянган төгрөг) болон 101,300,000 ам.доллар (252,189,389 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн хүүгийн хэмжээг зээл олгох бүрт Cargill Financial Services International, Inc харилцан адилгүй тогтоодог.

**Bank of Tokyo-Mitsubishi UFJ**

Групп 2014 оны 3 дугаар сард зээлийн аккредитив, баталгаажуулалтын болон санхүүжилтийн зорилгоор 25,000,000 ам.долларын худалдааны санхүүжилтийн зээлийн шугам батлуулсан. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 17,316,743 ам.доллар (43,110,552 мянган төгрөг) болон 136,652,500 иен (2,895,667 мянган төгрөг) байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн бөгөөд үлдэгдэлгүй байна.

**China Trade Solutions**

Групп нь China Trade Solutions-тай Богино Хугацааны Худалдааны Санхүүжилтийн гэрээг байгуулсан. Зээлийн хэмжээ, зээл олгох валютын төрөл, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцлүүдийг Групп тухайн зээлдэгчийн нөхцлийг харгалзан тохиролцдог. Зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 622,313 ам.доллар (1,510,436 мянган төгрөг) байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)

**Exim Bank of Russia (“Rosexim Bank”)**

Групп ОХУ-ын Rosexim Bank-тай харилцагчдад дамжуулан зээлдүүлэх зорилгоор Банк Хоорондын Зээлийн гэрээг байгуулсан. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 379,267 ам.доллар (944,196 мянган төгрөг) байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн бөгөөд үлдэгдэлгүй байна.

**Erste Групп Банк**

Групп 2015 оны 2 дугаар сард нийт 5.0 сая еврогийн үнийн дүнтэй “Өр шилжүүлэх мастер гэрээ”-г Erste Групп Банк-тай байгуулсан ба тус гэрээгээр зүүн Европын 13 оронтой хамтран ажилладаг харилцагчдын импортыг санхүүжүүлэх боломжтой болсон. Энэхүү гэрээний дагуу зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 497,150 евро (1,440,677 мянган төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,900,119 евро (4,951,311 мянган төгрөг) болон 367,670 ам.доллар (915,325 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн хүүгийн хэмжээг зээл авах бүрт Erste Групп Банк-аас харилцан адилгүй тогтоодог. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна.

**Banca Popolare di Sondrio**

2015 оны 10 дугаар сараас хойш Итали Улсын Banca Popolare Di Sondrio банк Итали Улстай хийсэн болон бусад хэлцлүүд дээр импортын дараах санхүүжилтийг санал болгосоор ирсэн. Зээлийн хэмжээ, зээл олгох валютын төрөл, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцлүүдийг Групп тухайн зээлдэгчийн нөхцлийг харгалзан харилцагч тус бүртэй тохиролцдог. Зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6,957,724 ам.доллар (16,887,301 мянган төгрөг) болон 3,701,275 евро (10,725,814 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 20,697,683 ам.доллар (51,527,502 мянган төгрөг) болон 1,405,200 евро (3,661,656 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамаарах харилцан адилгүй байна.

**Banco Popular Espanol**

Banco Popular Espanol нь 2015 оны 9 дүгээр сараас эхлэн Испани Улстай хийж буй гадаад оролцогч талуудтай худалдааны хэлцлүүдийг санхүүжүүлэх тал дээр хамтран ажиллаж эхэлсэн. Зээлийн хэмжээ, зээл олгох валютын төрөл, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцлүүдийг Групп тухайн зээлдэгчийн нөхцлийг харгалзан харилцагч тус бүртэй тохиролцдог. Зээлийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 10,188 евро (29,523 мянган төгрөг) болон 6,815,777 ам.доллар (16,542,778 мянган төгрөг), 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,512,622 евро (3,941,575 мянган төгрөг) болон 9,706,718 ам.доллар (24,165,166 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна.

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**UBI Banca**

2015 оны 11 дүгээр сараас эхлэн Итали Улсын UBI Banca нь Итали Улсаас эх үүсвэртэй импортуудыг санхүүжүүлэхээр импортын дараах санхүүжилтийг санал болгосон. Зээлийн хэмжээ, зээл олгох валютын төрөл, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцлүүдийг Групп нь тухайн зээлдэгчийн нөхцлийг харгалзан харилцагч тус бүртэй тохиролцдог. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 43,993 ам.доллар (109,522 мянган төгрөг) болон 39,480 евро (102,876 мянган төгрөг) байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн ба үлдэгдэлгүй байна. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээл олгосон өдрөөс хамааран харилцан адилгүй байна.

**Олон Улсын Хөгжлийн ОПЕК-ийн Сан ("ОУХОС")**

Групп 2015 оны 8 дугаар сард ОУХОС-тай худалдааны санхүүжилтийн зээлийн гэрээг байгуулсан ба тус гэрээгээр дотоод компаниуд болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн гадаад худалдааны санхүүжилтийг дэмжих зорилгоор 25,000,000 ам.долларын зээл авсан. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 24,887,772 ам.доллар (60,405,858 мянган төгрөг) болон 24,758,534 ам.доллар (61,637,113 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн хүүг эргэн төлөгдөх сүүлийн хугацаа буюу 2018 оны 10 дугаар сар хүртэл хагас жил тутам төлөх бөгөөд зээлийн үндсэн төлбөр нь хугацааны эцэст төлөгдөнө.

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк**

Групп Японы экспортлогчдын үйлдвэрлэсэн бараа, ажил үйлчилгээ, машин, механизм болон тоног төхөөрөмжийг авч буй зээлдэгчдийг санхүүжүүлэх зорилгоор Японы Олон улсын хамтын ажиллагааны банк болон Монгол Улсын Засгийн Газар хооронд 2013 онд байгуулагдсан Экспортын Шугамын Зээлийн гэрээн дээр үндэслэн Сангийн Яамтай 2013 онд дамжуулан зээлдүүдэх гэрээ байгуулсан. Групп нийт санхүүжилтийн дүн болох 8 тэрбум хүртэлх иенийн зээлийг иен болон ам.доллараар авч болно. Зээлийн үлдэгдэл 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 944,054,778 иен (20,325,499 мянган төгрөг) болон 200,550,552 иен (4,249,666 мянган төгрөг) тус тус байна. Зээлийн эргэн төлөгдөх сүүлийн хугацаа нь 2020 оны 7 дугаар сар бөгөөд зээлийн үндсэн хүүгийн түвшин 3.13 хувь байна.

**БНХАУ-ын Худалдаа, Аж үйлдвэрлэлийн банк**

Групп 2010 онд БНХАУ-ын Худалдаа, Аж үйлдвэрлэлийн банктай харилцагчдад санхүүжилтийг дамжуулан олгохоор Дамжуулан Зээлдүүлэх Гэрээг байгуулсан. Зээлийн хүүгийн түвшин, олгох огноо болон эргэн төлөлтийн огноонуудыг ICBC банк хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тохирдог. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлдэгчдэд зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,826,000 юань (1,727,515 мянган төгрөг) байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн ба үлдэгдэлгүй байна.

**БНХАУ-ын Хөдөө Аж Ахуйн Банк**

Групп 2011 онд БНХАУ-ын Хөдөө Аж Ахуйн Банктай импортыг санхүүжүүлэх гэрээ байгуулсан ба тус гэрээгээр бараа материал импортлож буй харилцагчдад санхүүжилт олгох юм. Зээлийн эргэн төлөгдөх хугацааны хувьд зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна. Зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,333,600 юань (835,338 мянган төгрөг) байсан байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн ба үлдэгдэлгүй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Монголын Ипотекийн Корпораци ХХК ("МИК ОССК ХХК")**

Групп 2016 оны 3 дугаар сард 367,314 мянган төгрөг, 6 дугаар сард 245,839 мянган төгрөг, 2017 оны 8 дугаар сард 5,370,059 мянган төгрөгийн дансны үнэтэй орон сууцны зээлийг МИК ОССК ХХК-руу шилжүүлсэн. Зээлүүдийг эх үүсвэрт нь үндэслэн шилжүүлсэн ба зээлтэй холбогдох эрсдэл, өгөөж нь МИК ОССК ХХК руу шилжүүлээгүй тул санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй. Тиймээс Групп энэхүү ажил гүйлгээг барьцаат санхүүжилтээр бүртгэсэн ба 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 5,224,622 болон 504,930 мянган төгрөг байна.

**Natixis Банк**

2016 оны 11 дүгээр сараас хойш Сингапур Улсын Natixis Банк нь импортын ажил гүйлгээг санхүүжүүлэхээр импортын дараах санхүүжилтыг санал болгосон. Санхүүжилт бүрээр татан авах дүн, валют, хүүгийн хувь, зээл олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон санхүүжилт бүрийн бусад нөхцлийг тухайн нөхцөл байдалд нь тулгуурлан Групп болон харилцагч харилцан зөвшилцөнө. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 385,000 евро (1,003,229 мянган төгрөг) байсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийг бүрэн эргэн төлсөн ба зээлийн үлдэгдэлгүй байна.

**Чайлизинг Олон Улсын Санхүүгийн Үйлчилгээ**

Групп 2016 оны 01 дүгээр сард 2,500,000 ам.долларын хоёр талын зээлийн гэрээг Чайлизинг Олон Улсын Санхүүгийн Үйлчилгээний байгууллагатай байгуулсан. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа 2 жил бөгөөд хагас жил тутамд 5%, 12.5%, 12.5% болон 70%-аар 4 удаа хэсэгчлэн эргэн төлнө. 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 1,745,090 ам.доллар (4,235,559 мянган төгрөг) болон 2,295,020 ам.доллар (5,713,521 мянган төгрөг) тус тус байна.

**БНХАУ-ын Хөгжлийн Банк**

2016 оны 7 дугаар сард Групп нь БНХАУ-ын Хөгжлийн Банктай 20,000,000 ам.долларын байгууламжийн хугацааны гэрээ дотоодын компаниудад дэмжлэг үзүүлэхээр байгуулсан. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа 3 жил бөгөөд хагас жил тутамд зээлийн хугацаа дуусах хүртэл сүүлийн эргэн төлөлтийг хийнэ. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 19,860,943 ам.доллар (48,205,091 мянган төгрөг) байна.

**Өвөр Монгол Банк**

2016 оны 11 дүгээр сард Групп нь Өвөр Монгол Банктай Худалдааны Санхүүжилтийн Хэлэлцээрийн Гэрээ байгуулсан. Зээлийн нөхцөл бүрт хөрвөх валютын хэмжээ, валют, холбогдох хүүгийн хэмжээ, зарцуулалтын огноо, эргэн төлөлтийн огноо, бусад тодорхой нөхцлүүдийг Банк, хэрэглэгчид харилцан тохиролцсоны үндсэн дээр тохиролцоно. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 1,786,890 юань (663,973 мянган төгрөг) болон 447,911 ам.доллар (1,087,139 мянган төгрөг) байна.

**Promsvyazbank**

ОХУ, Монгол Улсын хооронд экспорт, импортыг дэмжих зорилготойгоор 2017 онд Promsvyazbank нь худалдааны санхүүжилтийг хязгаарыг зөвшөөрсөн. 2017 оны 9 дүгээр сард Групп нь ОХУ-д газрын тосны бүтээгдэхүүн худалдан авдаг Монголын компаниудад хөрөнгө олуулахаар 5,000,000 ам.долларын зээлийг 1 жилийн эргэн төлөгдөх хугацаагаар авсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 5,000,000 ам.доллар (12,135,650 мянган төгрөг) байна.

**18 Санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)**

**Транскапитал Банк**

2017 онд Групп нь Транскапитал Банктай импортын болон экспортын гүйлгээг санхүүжүүлэхэд харилцагчдад дахин зээлдүүлэх зорилготойгоор мастер гэрээ байгуулсан. Зээлийн хүүгийн түвшин Транскапитал Банкны тодорхойлсон зээлийн нөхцөл бүрт өөр өөр байна. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь зээлдэгчдэд олгосон зээлийн хугацаанаас хамааран өөр байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 6,500,000 ам.доллар (15,776,345 мянган төгрөг) байна.

**Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Олон Улсын Банк**

2017 онд Групп нь харилцагчдын гадаад эдийн засгийн гүйлгээний санхүүжилтийн зорилгоор Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банктай Мастер санхүүжилтийн гэрээ байгуулсан. Зээл нь жилийн 5.5 хувийн тогтмол хүүтэй ба хүүгийн эргэн төлөлтийг 2018 оны 12 дугаар сард төлнө. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 3,400,000 ам.доллар (8,252,242 мянган төгрөг) байна.



**19 Гаргасан өрийн үнэт цаас**

| | 2017<br>Мян.төг | 2016<br>Мян.төг |
|---|---|---|
| Гаргасан өрийн бичиг, хорогдуулсан өртгөөр | 1,344,633,676 | 1,569,366,930 |

Групп 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хэрэгжиж эхэлсэн 700,000,000 ам.долларын Евро Дунд Хугацааны Өрийн Бичиг ("ЕДХӨБ") хөтөлбөрийн хүрээнд 2014 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр 700,000,000 юанийн давуу эрхийн бондыг нэрлэсэн үнийн 99.367 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2017 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр байна. Эдгээр бонд нь жилийн 10.0 хувийн хүүтэй ба хүүг хагас жил тутамд төлнө. 2017 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөгдөж дууссан ба үлдэгдэлгүй байна.

Групп 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хэрэгжиж эхэлсэн 500,000,000 ам.долларын Глобал Дунд Хугацааны Өрийн Бичиг ("ГДХӨБ") хөтөлбөрийн хүрээнд 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр 500,000,000 ам.долларын баталгаажсан бондыг (аливаа нөхцөлгүй, буцалтгүй Засгийн Газрын баталгаатай) нэрлэсэн үнийн 100 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдөр байна. Эдгээр бонд нь жилийн 9.375 хувийн хүүтэй ба хүүг хагас жил тутамд төлнө.

Групп 2016 оны 6 дугаар сарын 28-ны өдөр "Дотоодын актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ" ("ДАЧЭБАХ") хөтөлбөрийн хүрээнд 160,000,000,000 төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнийн 100 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдөр байна.

2017 болон 2016 оны тайлант жилүүдэд өрийн үнэт цаасны дансны үнэ нь үр ашигт хүүгийн аргаар тооцоход 9,493,265 мянган төгрөг ба 11,947,629 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн болно.

Групп нь Монгол Улс болон холбогдох орнуудын хооронды байгуулагдсан давхар татварын хэлэлцээрийн дагуу давуу эрхийн бондын тодорхой хөрөнгө оруулагчид төлж буй хүүгийн зардлаас гадна суутган татвар төлөх үүрэгтэй. Эдгээр нэмэлт мөнгөн гүйлгээний зардал нь бондын бодит хүүгийн хувийг нэмэгдүүлж байгаа болно.

**20 Хоёрдогч өглөг**

| | 2017<br>Мян.төг | 2016<br>Мян.төг |
|---|---|---|
| Хоёрдогч өглөг, хорогдуулсан өртгөөр | - | 24,895,300 |

2012 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Групп 10,000,000 ам.долларын хоёрдогч өглөгийг нэрлэсэн үнээр нь гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдөр бөгөөд хагас жил тутамд төлөгдөнө. 2017 оны 6 дугаар сарын 06-нд төлөгдөх хоёрдогч өглөг нь хуваарийн дагуу төлөгдөж дууссан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**21 Бусад өр төлбөр**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Хуримтлагдсан хүүгийн өглөг | 92,667,854 | 94,075,114 |
| Клирингийн саатал | 16,051,052 | 23,241,786 |
| Спот арилжааны өглөг | - | 9,173,670 |
| Арилжаалах үүсмэл санхүүгийн өр төлбөр | 6,750 | 47,289,538 |
| Санхүүгийн түрээсийн өглөг | 2,591,014 | 5,723,739 |
| Дотоод арилжааны төлөх өглөг | 11,197,320 | 8,347,828 |
| Бусад | 19,453,657 | 21,521,912 |
| | 141,967,647 | 209,373,587 |

**22 Хувьцаат капитал**

| | Энгийн хувьцааны тоо 2017 | Энгийн хувьцааны тоо 2016 | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|---|---|
| 01 дүгээр сарын 01 | 3,305,056 | 3,305,056 | 50,000,011 | 50,000,011 |
| Нэмж гаргасан | - | - | - | - |
| 12 дугаар сарын 31 | 3,305,056 | 3,305,056 | 50,000,011 | 50,000,011 |

Группын 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт зөвшөөрөгдсөн 4,000,000 ширхэг хувьцаанаас 3,305,056 ширхэг хувьцааг гаргасан байна. Групп 2015 онд хуримтлагдсан ашигаа капиталжуулах замаар хувьцаат капиталын дүнгээ 16,525,280 мянган төгрөгөөс 50,000,011 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн. 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт гаргасан хувьцааны төлбөр бүрэн төлөгдсөн ба нэгжийн нэрлэсэн үнэ нь тус бүр 15,128 төгрөг байна.

**23 Халаасны хувьцаа**

Групп 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар халаасны хувьцааны үлдэгдэлгүй байсан байна.

**24 Капитал тохируулга**

2016 онд, ННК ХХК нь Улаанбаатар Хотын Банкнаас 10,000 ширхэг халаасны хувьцааг 1,583,600 мянган төгрөгөөр авсан ба энэ нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт энгийн хувьцааны 8.04 хувийг эзэлж байсан.

2017 онд ННК ХХК-ийг Группын охин компаниас хассанаар 1,583,600 мянган төгрөгөөр буурсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**25 Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй орлого**

| 2017 Мян.төг | Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт | Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний цэвэр өөрчлөлт | Дахин үнэлгээний нөөц | Дүн |
|---|---|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 30,219,254 | 14,905,402 | 126,992,124 | 172,116,780 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт | 4,180,431 | - | 4,419,681 | 8,600,112 |
| Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хэрэгжээгүй цэвэр олз | - | 57,466,279 | - | 57,466,279 |
| Худалдсан болон данснаас хассанаас үүссэн өөрчлөлт | (20,678,016) | - | - | (20,678,016) |
| Нэгтгэлийн цар хүрээний өөрчлөлт | - | - | (1,397,482) | (1,397,482) |
| Эцсийн үлдэгдэл | 13,721,669 | 72,371,681 | 130,014,323 | 216,107,673 |

| 2016 Мян.төг | Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт | Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний цэвэр өөрчлөлт | Дахин үнэлгээний нөөц | Дүн |
|---|---|---|---|---|
| Эхний үлдэгдэл | (23,831,129) | 39,938,362 | 135,298,874 | 151,406,107 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт | 41,197,955 | - | (7,317,887) | 33,880,068 |
| Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хэрэгжээгүй цэвэр олз | - | (25,032,960) | - | (25,032,960) |
| Худалдсан болон данснаас хассанаас үүссэн өөрчлөлт | 12,852,428 | - | (988,863) | 11,863,565 |
| Эцсийн үлдэгдэл | 30,219,254 | 14,905,402 | 126,992,124 | 172,116,780 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**26 Хүүгийн орлого**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Зээл ба урьдчилгаа | 365,018,080 | 371,947,581 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 230,974,639 | 196,953,296 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 16,618,825 | 18,496,759 |
| Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас | 33,343 | 5,494,386 |
| Хоёрдогч зээл | 237,333 | 325,333 |
| | 612,882,220 | 593,217,355 |

**27 Хүүгийн зардал**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Хадгаламж | 193,364,035 | 160,758,871 |
| Авсан зээл, эх үүсвэр | 86,085,993 | 79,979,835 |
| Буцаан худалдах гэрээгээр борлуулсан үнэт цаас | 9,786,092 | 13,955,270 |
| Гаргасан өрийн бичиг | 143,782,741 | 143,606,860 |
| Хоёрдогч өглөг | 1,102,970 | 2,531,855 |
| | 434,121,831 | 400,832,691 |

**28 Шимтгэл, хураамжийн цэвэр орлого**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| **Шимтгэл, хураамжийн орлого** | | |
| Банкны шилжүүлэг | 7,309,924 | 5,717,728 |
| Картын үйлчилгээ | 18,175,047 | 13,565,508 |
| Зээлийн үйлчилгээ | 17,565,787 | 14,620,895 |
| Бусад | 4,088,163 | 4,752,873 |
| Шимтгэл, хураамжийн орлогын дүн | 47,138,921 | 38,657,004 |
| **Шимтгэл, хураамжийн зардал** | | |
| Картын үйлчилгээний зардал | 7,846,858 | 5,072,975 |
| Бусад | 2,252,107 | 2,965,429 |
| Шимтгэл, хураамжийн зардлын дүн | 10,098,965 | 8,038,404 |
| **Шимтгэл, хураамжийн цэвэр орлого** | 37,039,956 | 30,618,600 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**29 Үйл ажиллагааны бусад орлого, цэвэр**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Ханшийн тэгшитгэлийн олз (гарз), цэвэр | 15,437,750 | (15,653,147) |
| Үнэт металлын арилжааны олз, цэвэр | 273,581 | 1,598,180 |
| Үнэт цаас худалдсаны олз, цэвэр | 14,168,548 | 21,827,163 |
| Охин болон хараат компанид оруулсан хөрөнгийг борлуулсанаас үүссэн олз | 8,556,355 | 8,907,904 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний олз (гарз) | 3,027,463 | (7,792,650) |
| Үндсэн хөрөнгө борлуулсанаас үүссэн олз (гарз), цэвэр | 4,868 | (9,348) |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсанаас үүссэн гарз | - | (1,252,400) |
| Ноогдол ашгийн орлого | 49,705 | - |
| Бусад | 6,455,953 | 4,395,303 |
| | 47,974,223 | 12,021,005 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**30 Үйл ажиллагааны зардал**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Боловсон хүчний зардал | 35,705,209 | 32,355,970 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 10) | 8,124,483 | 10,472,544 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тодруулга 11) | 1,480,796 | 1,838,219 |
| Зар сурталчилгааны зардал | 8,504,537 | 7,955,187 |
| Түрээсийн зардал | 4,635,169 | 4,882,541 |
| Мэргэжлийн үйлчилгээний хөлс | 6,762,240 | 10,051,702 |
| Техникийн туслалцаа болон гадаадын банкны гүйвүүлгын шимтгэл | 1,545,020 | 1,148,260 |
| Данснаас хассан үндсэн хөрөнгө | 140,534 | 9,380 |
| Данснаас хассан ХОЗҮХХ | - | 1,151,774 |
| Даатгал | 7,035,315 | 6,339,408 |
| Албан томилолт | 1,406,406 | 1,393,627 |
| Бэлэн мөнгө цуглуулах зардал | 521,433 | 491,057 |
| Бичиг хэргийн зардал | 1,440,236 | 1,046,893 |
| Харилцаа холбооны зардал | 1,359,876 | 1,201,448 |
| Сургалтын зардал | 99,916 | 275,808 |
| Ашиглалтын зардал | 824,774 | 884,237 |
| Засвар үйлчилгээний зардал | 1,158,944 | 427,957 |
| Харуул, хамгаалалтын зардал | 152,168 | 249,835 |
| Зочин төлөөлөгчийн зардал | 762,026 | 965,919 |
| Тээврийн зардал | 374,389 | 306,142 |
| Мэдээлэл технологийн засвар үйлчилгээ | 3,378,004 | 1,770,654 |
| Бусад (*1) | 4,518,606 | 7,431,475 |
| | 89,930,081 | 92,650,037 |

(*1) Бусад үйл ажиллагааны зардалд зээл барагдуулахтай холбоотой зардал, цэвэрлэгээ болон удирдлагын бусад нэмэгдэл зардал орно.

**31 Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Зээлийн үнэ цэнийн бууралтын нөөцийн зардал | 114,365,825 | 91,794,836 |
| Бусад хөрөнгө болон өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын нөөцийн зардал | 1,196,206 | 202,796 |
| | 115,562,031 | 91,997,632 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**32 Түрээс**

Групп нь зарим салбар, нэгжийн оффисын байрыг төрөл бүрийн түрээсийн гэрээгээр түрээсэлдэг. 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэг жилээс дээш хугацаатай, гэрээг цуцлах боломжгүй үйл ажиллагааны түрээсийн гэрээгээр түрээсэлсэн түрээсийн хамгийн бага үүрэг амлалт дараах байдалтай байна:

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Нэг жилийн доторхи | 4,304,763 | 3,260,901 |
| 1 – 5 жил | 5,555,693 | 4,589,308 |
| | 9,860,456 | 7,850,209 |

**33 Орлогын татварын зардал**

**Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн:**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Орлогын татварын зардал – тайлант жил | 381,360 | 212,876 |

**Орлогын албан татварын зардлын тохируулга:**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Татварын өмнөх ашиг | 74,141,306 | 67,673,085 |
| Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан орлогын албан татвар (*1) | 18,085,327 | 16,468,271 |
| Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардалд ногдох татвар | 2,860,828 | 8,478,009 |
| Татвар ногдохгүй орлогод ногдох татвар | (20,928,695) | (24,929,456) |
| Тусгай хувь хэмжээгээр тооцсон орлогын албан татварын ногдох татвар (*2) | 363,900 | 136,247 |
| Охин компаниуд дахь татварын хувь, хэмжээний үр нөлөө | - | (36,678) |
| Бусад | - | 96,483 |
| | 381,360 | 212,876 |

(*1) Групп нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу 3 тэрбум хүртэлх төгрөгийн татвар ногдуулах орлогод 10 хувийн татвар, 3 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 3 тэрбумаас давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж татвар ногдуулж, төлөх үүрэгтэй.
(*2) Групп нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу зарим татвар ногдуулах орлогын төрөлд тусгай хувь хэмжээгээр тооцсон орлогын албан татвар төлөх үүрэгтэй.

**34 Ногдол ашиг**

Групп 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдэд ногдол ашиг зарлаагүй болно.

**35 Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс**

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах зүйлс нь касс дахь бэлэн мөнгө болон ямар нэгэн хязгаарлалт хийгдээгүй төлбөр гүйцэтгэхэд бэлэн, бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах дансанд байршуулсан 3 сар хүртэлх хугацаатай мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ. 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан мөнгө, түүнтэй адилтгах зүйлс дараах байдалтай байна:

| | 2017<br>Мян.төг | 2016<br>Мян.төг |
|---|---|---|
| Бэлэн мөнгө, банкинд байршуулсан мөнгө (Тодруулга 5) | 1,073,933,382 | 1,188,822,410 |
| Монголбанкин дахь заавал байлгах нөөц | (368,398,156) | (297,533,953) |
| Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс | 705,535,226 | 891,288,457 |

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бэлэн бус томоохон ажил гүйлгээний дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

| | 2017<br>Мян.төг | 2016<br>Мян.төг |
|---|---|---|
| Үндсэн хөрөнгө рүү шилжүүлсэн хөрөнгө оруулалтын зориулалтай үл хөдлөх хөрөнгө | - | 1,332,386 |
| Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн үнэлгээний олз | 16,497,110 | 54,050,383 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ | 4,419,681 | (7,317,887) |
| Мөнгөн хөрөнгийн хейджийн үнэлгээний олз (гарз) | 57,466,279 | (25,032,960) |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**36 Сегментийн тайлагнал**

Сегментийн мэдээллийг Группын бизнесийн сегментэд үндэслэн тайлагнасан. Групп нь тайлангийн хэлбэр болон үйл ажиллагааны сегментийг Группын удирдлагын болон дотоод тайлагналын бүтэц зохион байгуулалтанд үндэслэн тодорхойлдог.

Үйл ажиллагааны сегментүүд нь капитал болон санхүүжилтийн өртгийн хуваарилалтыг тусгахын тулд Хөрөнгө зохицуулалтын газарт хүү төлж, мөн хүлээн авдаг.

Сегментийн капитал зардал нь тайлант жилд гүйдвиллээс бусад биет бус хөрөнгө, үндсэн хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан нийт зардлыг хэлнэ.

**Үйл ажиллагааны сегмент**

Группын үйл ажиллагааны сегмент нь дараах үндсэн сегментүүдээс бүрдэж байна:

- *Байгууллагын Банк* — Байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ. Групп 3,000,000 мянган төгрөгөөс дээш зээлийн санхүүжилт олгосон эсвэл 6,000,000 мянган төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой харилцагчидаа энэхүү ангилалд оруулдаг.
- *Жижиг, Дунд Байгууллагын Банк* — Жижиг, Дунд байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ. Групп 350,000 - 3,000,000 мянган төгрөгийн хооронд зээлийн санхүүжилт олгосон эсвэл 1,500,000-6,000,000 мянган төгрөгийн борлуулалтын орлоготой харилцагчидаа энэхүү ангилалд оруулдаг.
- *Иргэдийн Банк* — Карт эзэмшигчдийн карт, иргэдийн харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ. Групп 350,000 мянган төгрөгөөс доош зээлийн санхүүжилт олгосон эсвэл 1,500,000 мянган төгрөгөөс доош борлуулалтын орлоготой харилцагчидаа энэхүү ангилалд оруулдаг.
- *Олон Улсын Байгууллагын Банк* — Олон Улсын санхүүгийн зах зээлд бонд гаргах, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах, уг зах зээл дээр арилуаа хийх үйл ажиллагааг хариуцдаг.
- *Хөрөнгө Зохицуулалт* — Зээл авах, өрийн үнэт цаас гаргах, эрсдэлийн удирдлагын зорилгоор дериватив хэрэгсэл хэрэглэх, богино хугацаат хадгаламж хийх, Засгийн Газрын болон компанийн өрийн үнэт цаас зэрэг түргэн хөрвөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх зэргээр Группын санхүүжилт, эрсдэлийн төвлөрсөн удирдлагаар хангах үүрэгтэй. Үйл ажиллагаа нь Группын хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа байдаг.
- *Бусад* — Төв оффисын үйл ажиллагаа болон арын албаны үйлчилгээний хэсгийн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Энэ нь Группын үл хөдлөх хөрөнгө болон холбогдох тогтмол гардаг зардлуудыг хянаж, зохицуулдаг.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

## 36 Сегментийн тайлагнал (үргэлжлэл)

*(Мянган төгрөгөөр)*

| 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | Байгууллагын Банк | Жижиг, Дунд Байгууллагын Банк | Иргэдийн Банк | Олон Улсын Байгууллагын Банк | Хөрөнгө Зохицуулалт | Бусад | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Сегментийн үр дүн | | | | | | | |
| Гадаад орлого | | | | | | | |
| Хүүгийн цэвэр орлого (зардал) | 278,262,879 | 15,552,882 | (84,868,718) | (194,359,740) | 163,978,029 | 195,057 | 178,760,389 |
| Хураамж, шимтгэлийн цэвэр орлого | 12,191,151 | 178,243 | 23,546,117 | 218,814 | 420,181 | 485,450 | 37,039,956 |
| Үйл ажиллагааны бусад орлого (зардал) | 3,741,982 | - | 7,636,144 | 22,319 | 43,395,478 | (6,821,700) | 47,974,223 |
| Сегмент хоорондын орлого (зардал) | (203,285,065) | (3,056,824) | 155,244,277 | 202,315,302 | (151,177,554) | (40,136) | - |
| Нийт сегментийн орлого (зардал) | 90,910,947 | 12,674,301 | 101,557,820 | 8,196,695 | 56,616,134 | (6,181,329) | 263,774,568 |
| Үйл ажиллагааны зардал | (1,095,474) | - | (37,140,649) | (2,382,991) | (2,629,961) | (46,681,006) | (89,930,081) |
| Хараат болон хамтарсан компанийн ашгийн эзлэх хувь | - | - | - | - | - | 15,858,850 | 15,858,850 |
| Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдлийн буцаалт | (115,375,819) | 1,854,266 | (1,714,331) | - | 287,274 | (613,421) | (115,562,031) |
| Татварын өмнөх цэвэр ашиг (алдагдал) | (25,560,346) | 14,528,567 | 62,702,840 | 5,813,704 | 54,273,447 | (37,616,906) | 74,141,306 |
| Орлогын албан татварын зардал | | | | | | | (381,360) |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | | | | | | 73,759,946 |
| Хяналтын эрхгүй хувь | | | | | | | - |
| Сегментийн хөрөнгө | 2,306,831,075 | 101,353,005 | 544,270,813 | - | 3,341,934,943 | 580,535,480 | 6,874,925,316 |
| Сегментийн өр төлбөр | 44,115,297 | 48,063 | 2,947,572,185 | 1,851,389,691 | 1,153,469,237 | 2,798,212 | 5,999,392,685 |
| Элэгдэл, хорогдол | (6,989) | - | (3,556,518) | (6,869) | (10,693) | (6,024,210) | (9,605,279) |
| Капиталын зардал | 29,913 | - | 1,930,982 | 13,655 | 5,108 | 2,447,089 | 4,426,747 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

## 36 Сегментийн тайлагнал (үргэлжлэл)

***(Мянган төгрөгөөр)***

| **2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр** | **Байгууллагын Банк** | **Жижиг, Дунд Байгууллагын Банк** | **Иргэдийн Банк** | **Олон Улсын Байгууллагын Банк** | **Хөрөнгө Зохицуулалт** | **Бусад** | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|
| Сегментийн үр дүн | | | | | | | |
| Гадаад орлого | | | | | | | |
| Хүүгийн цэвэр орлого (зардал) | 288,769,011 | 16,003,139 | (48,489,425) | (197,813,173) | 134,015,463 | (100,351) | 192,384,664 |
| Хураамж, шимтгэлийн цэвэр орлого | 8,809,563 | 156,656 | 20,080,641 | 246,751 | 752,647 | 572,342 | 30,618,600 |
| Үйл ажиллагааны бусад орлого (зардал), цэвэр | - | 28 | 6,568,014 | 2,541,530 | 9,259,921 | (6,348,488) | 12,021,005 |
| Сегмент хоорондын орлого (зардал) | (190,407,980) | (3,709,253) | 111,133,003 | 205,424,542 | (122,402,115) | (38,197) | - |
| Нийт сегментийн орлого (зардал) | 107,170,594 | 12,450,570 | 89,292,233 | 10,399,650 | 21,625,916 | (5,914,694) | 235,024,269 |
| Үйл ажиллагааны зардал | (1,030,426) | (59) | (32,792,390) | (5,832,779) | (2,895,301) | (50,099,082) | (92,650,037) |
| Хараат болон хамтарсан компанийн ашгийн эзлэх хувь | | | | | | 17,296,485 | 17,296,485 |
| Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдлийн буцаалт | (82,736,618) | (3,428,822) | (5,553,953) | - | (287,274) | 9,035 | (91,997,632) |
| Татварын өмнөх цэвэр ашиг (алдагдал) | 23,403,550 | 9,021,689 | 50,945,890 | 4,566,871 | 18,443,341 | (38,708,256) | 67,673,085 |
| Орлогын албан татварын зардал | | | | | | | (212,876) |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | | | | | | 67,460,209 |
| Хяналтын эрхгүй хувь | | | | | | | 505,332 |
| Сегментийн хөрөнгө | 2,319,752,370 | 92,531,517 | 566,119,424 | - | 3,069,522,050 | 597,259,545 | 6,645,184,906 |
| Сегментийн өр төлбөр | 86,132,136 | 58,995 | 2,223,315,735 | 2,346,004,571 | 1,213,756,686 | 16,766,058 | 5,886,034,181 |
| Элэгдэл, хорогдол | (4,482) | - | (3,130,419) | (5,576) | (9,669) | (9,160,617) | (12,310,763) |
| Капиталын зардал | 220 | - | 4,774,835 | 127 | 5,017 | 147,328,412 | 152,108,611 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилдийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**37 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (хүлээгдэж байгаа)**

Дараах байгууллагууд нь Группын холбоотой талууд болно. Үүнд:

| | |
|---|---|
| • *Улаанбаатар Хотын Банк болон түүний охин компани* | Группын ТУЗ-ын дарга Улаанбаатар Хотын Банкны ТУЗ-ын гишүүн юм. |
| • *МИК Холдинг ХК болон түүний охин компаниуд ("МИК")* | Групп нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ойролцоогоор МИК-ийн энгийн хувьцааны 21.85 хувийг эзэмшиж байна. (тодруулга 6) |
| • *Монгол Женерал Лизинг ХХК болон түүний охин компани ("Эм Жи Эл Эл")* | Групп нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Женерал Лизинг ХХК-ийн энгийн хувьцааны 55.0 хувийг эзэмшиж байна. (тодруулга 6) |
| • *Нейшнал Ньюс Корпораци болон түүний охин компани ("ННК")* | Групп нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ННК-ийн энгийн хувьцааны 38.64 хувийг эзэмшиж байна. (тодруулга 6) |
| • *JCDecaux ХХК* | ННК нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар JCDecaux ХХК-ийн энгийн хувьцааны 49 хувийг эзэмшиж байна. |
| • *Монголиан Нейшнал Рейр Эйрт Корпораци ХХК ("Эм Эн Ар И Си")* | Групп нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголиан Нейшнал Рейр Эйрт Корпораци ХХК-ийн энгийн хувьцааны 100 хувийг эзэмшиж байна. |
| • *Валиант Арт ХХК* | 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд Группын төлөөлөн удирдах гишүүний ойрын хамаатан нь Валиант Арт ХХК-ийг эзэмшиж байна. |

Группын гүйцэтгэх удирдлагууд болон тэдгээрийн ойрын хамаатан садангууд нь мөн Группын холбоотой талууд юм.

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ нь дараах байдалтай байна:

| | 2017<br>Мян.төг | 2016<br>Мян.төг |
|---|---|---|
| **Улаанбаатар Хотын Банк болон түүний охин компани:** (*1): | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил*** | | |
| Хүүгийн орлого | 5,139,394 | 8,245,657 |
| Хүүгийн зардал | (758,866) | (1,275,662) |
| Шимтгэл, хураамжийн цэвэр орлого | (188) | (16) |
| ***12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*** | | |
| Банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж | 70,660,743 | 124,349,012 |
| Банк болон бусад санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө | 26,452,916 | 14,264,457 |
| Зээл ба урьдчилгаа | 21,028 | 12,696,580 |
| Хоёрдогч өглөг (Тодруулга 9) | - | 4,000,000 |
| Хуримтлагдсан хүүгийн орлого | 35,607 | 102,182 |
| Хуримтлагдсан хүүгийн зардал | (20,348) | 18,784 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилдийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**37 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)**

| | 2017<br>Мян.төг | 2016<br>Мян.төг |
|---|---|---|
| **МИК** (*1): | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил*** | | |
| Хүүгийн орлого | 10,676,275 | 6,301,629 |
| Хүүгийн зардал | (6,124,278) | (4,566,995) |
| Шимтгэл, хураамжийн орлого | 2,447,216 | 1,968,540 |
| ***12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*** | | |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 105,177,000 | 57,919,000 |
| Банк болон бусад санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө | 72,113,000 | 31,610,000 |
| Хуримтлагдсан хүүгийн орлого | 1,356,440 | 794,143 |
| Хуримтлагдсан хүүгийн зардал | 2,754,264 | 760,716 |
| Зээл | 5,224,622 | 504,930 |
| Авлага | 1,028,399 | 729,578 |
| **Эм Жи Эл Эл:** | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил*** | | |
| Цэвэр хураамж, шимтгэлийн орлого | 300,000 | 310,000 |
| Хүүгийн орлого | 63,707 | 147,705 |
| Хүүгийн зардал | (281,871) | (92,461) |
| Үйл ажиллагааны зардал | - | (153) |
| ***12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*** | | |
| Банк болон бусад санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө | 10,271,553 | 5,505,292 |
| Зээл ба урьдчилгаа | 615,773 | 237,754 |
| Хуримтлагдсан хүүгийн орлого | 4,466 | 1,234 |
| Авлага | 82,500 | 1,634,160 |
| Бусад өр төлбөр | - | 654 |
| Хуримтлагдсан хүүгийн зардал | 11,293 | - |
| Түрээсийн өглөг | 2,591,014 | 5,742,678 |
| **ННК:** | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил*** | | |
| Хүүгийн зардал | (1,985) | - |
| ***12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*** | | |
| Банкинд байршуулсан хадгаламж | 84,641 | - |
| Авлага | 432,000 | - |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилдийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**37 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)**

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| ***JCDecaux ХХК:*** | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил*** | | |
| Үйл ажиллаганы зардал | (163,768) | (10,071) |
| **МНРИК:** | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*** | | |
| Авлага | 249,774 | - |
| **Валиант Арт ХХК:** | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил*** | | |
| Хүүгийн орлого | 310,442 | 255,283 |
| ***12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*** | | |
| Зээл ба урьдчилгаа | 1,966,763 | 1,968,240 |
| Хуримтлагдсан хүүгийн орлого | 2,150 | - |
| **Гүйцэтгэх удирдлага:** | | |
| ***12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил*** | | |
| Хүүгийн орлого | 626,577 | 644,200 |
| ***12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар*** | | |
| Зээл ба урьдчилгаа | 7,039,486 | 7,526,693 |
| Хуримтлагдсан хүүгийн орлого | 28,063 | 38,256 |

(*1) Бусад гүйлгээ

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| **Улаанбаатар Хотын Банк болон түүний охин компани:** | | |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаасны борлуулалт | 12,961,642 | - |
| **МИК:** | | |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаасны борлуулалт | 11,428,685 | - |

Гүйцэтгэх удирдлагад олгосон зээл нь Группын зээл ба урьдчилгааны дунд багтсан ба гүйцэтгэх удирдлагад олгосон ипотекийн болон бусад зээлийн хүү нь зах зээлийн хүүгээс доогуур байна. Ипотекийн зээлд зээлдэгчдийн худалдан авч буй үл хөдлөх хөрөнгүүдийг барьцаалсан.

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдэд гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдэд төлсөн нийт цалин хөлс урамшуулал, тэтгэмж нь 7,844,245 мянган төгрөг болон 6,612,414 мянган төгрөг тус тус байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

## 38 Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

*(Мянган төгрөгөөр)*

| **2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар** | **Арилжаа** | **Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт** | **Зээл ба авлага** | **Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө** | **Санхүүгийн өр төлбөр (хорогдуулсан өртгөөр)** | **Хейджийн зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэглүүр** | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | | | | |
| Бэлэн мөнгө, бусад банкинд байршуулсан хөрөнгө | - | - | 1,073,933,382 | - | - | - | 1,073,933,382 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | - | 1,119,096,011 | - | 907,190,696 | - | - | 2,026,286,707 |
| Зээл ба урьдчилгаа | - | - | 2,764,974,569 | - | - | - | 2,764,974,569 |
| Буцаан зарах гэрээгээр худалдан авсан үнэт цаас | - | - | 11,981,945 | - | - | - | 11,981,945 |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | - | - | - | - | - | 314,341,681 | 314,341,681 |
| Бусад хөрөнгө (*1) | - | - | 196,541,453 | - | - | - | 196,541,453 |
| | - | 1,119,096,011 | 4,047,431,349 | 907,190,696 | - | 314,341,681 | 6,388,059,737 |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | | | | |
| Хадгаламж | - | - | - | - | 3,070,233,636 | - | 3,070,233,636 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө | - | - | - | - | 243,907,591 | - | 243,907,591 |
| Буцаан худалдан авах гэрээгээр борлуулсан үнэт цаас | - | - | - | - | 129,960,388 | - | 129,960,388 |
| Зээлийн эх үүсвэр | - | - | - | - | 1,068,669,444 | - | 1,068,669,444 |
| Гаргасан өрийн бичиг | - | - | - | - | 1,344,633,676 | - | 1,344,633,676 |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | 6,750 | - | - | - | - | - | 6,750 |
| Бусад өр төлбөр (*2 | - | - | - | - | 141,953,944 | - | 141,953,944 |
| | 6,750 | - | - | - | 5,999,358,679 | - | 5,999,365,429 |

(*1) Урьдчилж төлсөн зардал, үнэт металл, бараа материал, үүсмэл санхүүгийн хөрөнгө болон спот хэлцлийн авлага ороогүй болно.
(*2) Урьдчилж төлөгдсөн орлого, үүсмэл санхүүгийн өр төлбөр болон спот хэлцлийн өр төлбөр ороогүй болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**38 Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал (үргэлжлэл)**

***(Мянган төгрөгөөр)***

| **2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар** | **Арилжаа** | **Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт** | **Зээл ба авлага** | **Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө** | **Санхүүгийн өр төлбөр (хорогдуулсан өртгөөр)** | **Хейджийн зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэглүүр** | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | | | | |
| Бэлэн мөнгө, бусад банкинд байршуулсан хөрөнгө | - | - | 1,188,822,410 | - | - | - | 1,188,822,410 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | - | 1,115,728,071 | - | 409,707,146 | - | - | 1,525,435,217 |
| Зээл ба урьдчилгаа | - | - | 2,835,167,306 | - | - | - | 2,835,167,306 |
| Хоёрдогч зээл | - | - | 4,000,000 | - | - | - | 4,000,000 |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | 70,898,721 | - | - | - | - | 288,075,402 | 358,974,123 |
| Спот хэлцлийн авлага | - | - | 9,146,782 | - | - | - | 9,146,782 |
| Бусад хөрөнгө (*1) | - | - | 209,057,978 | - | - | - | 209,057,978 |
| | 70,898,721 | 1,115,728,071 | 4,246,194,476 | 409,707,146 | - | 288,075,402 | 6,130,603,816 |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | | | | |
| Хадгаламж | - | - | - | - | 2,415,529,106 | - | 2,415,529,106 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө | - | - | - | - | 143,207,671 | - | 143,207,671 |
| Буцаан худалдан авах гэрээгээр борлуулсан үнэт цаас | - | - | - | - | 129,960,388 | - | 129,960,388 |
| Зээлийн эх үүсвэр | - | - | - | - | 1,392,176,891 | - | 1,392,176,891 |
| Гаргасан өрийн бичиг | - | - | - | - | 1,569,366,930 | - | 1,569,366,930 |
| Хоёрдогч өглөг | - | - | - | - | 24,895,300 | - | 24,895,300 |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | 47,289,538 | - | - | - | - | - | 47,289,538 |
| Спот хэлцлийн өр төлбөр | - | - | - | - | 9,173,670 | - | 9,173,670 |
| Бусад өр төлбөр (*2) | - | - | - | - | 152,906,967 | - | 152,906,967 |
| | 47,289,538 | - | - | - | 5,837,216,923 | - | 5,884,506,461 |

(*1) Урьдчилж төлсөн зардал, үнэт металл, бараа материал, үүсмэл санхүүгийн хөрөнгө болон спот хэлцлийн авлага ороогүй болно.
(*2) Урьдчилж төлөгдсөн орлого, үүсмэл санхүүгийн өр төлбөр болон спот хэлцлийн өр төлбөр ороогүй болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**38 <u>Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал (үргэлжлэл)</u>**

2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн хэрэглүүрийн төрлөөрх цэвэр олз (гарз) дараах байдалтай байна:

***(Мянган төгрөгөөр)***

**2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар**

| | Хүүгийн орлого | Хүүгийн зардал | Шимтгэл, хураамж-ийн орлого | Үйл ажиллагааны бусад орлого | Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал | Цэвэр олз (гарз) | Бусад дэлгэрэнгүй орлого |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт | 183,851,050 | - | - | - | - | 183,851,050 | - |
| Зээл ба авлага | 381,907,581 | - | 17,587,535 | - | (114,717,809) | 284,777,307 | - |
| Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө | 47,123,589 | - | - | 14,168,548 | - | 61,292,137 | (16,497,110) |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө болон спот хэлцэл | - | - | - | 15,437,750 | - | 15,437,750 | 57,466,279 |
| Санхүүгийн өр төлбөр (хорогдуулсан өртгөөр) | - | (434,121,831) | - | - | - | (434,121,831) | - |
| | 612,882,220 | (434,121,831) | 17,587,535 | 29,606,298 | (114,717,809) | 110,236,413 | 40,969,169 |

**2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар**

| | Хүүгийн орлого | Хүүгийн зардал | Шимтгэл, хураамж-ийн орлого | Үйл ажиллагааны бусад орлого | Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал | Цэвэр олз (гарз) | Бусад дэлгэрэнгүй орлого |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт | 163,215,917 | - | - | - | - | 163,215,917 | - |
| Зээл ба авлага | 396,264,059 | - | 14,620,895 | - | (92,201,226) | 318,683,728 | - |
| Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө | 33,737,379 | - | - | 21,827,163 | - | 55,564,542 | 54,050,383 |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө болон спот хэлцэл | - | - | - | (15,653,147) | - | (15,653,147) | (25,032,960) |
| Санхүүгийн өр төлбөр (хорогдуулсан өртгөөр) | - | (400,832,691) | - | - | - | (400,832,691) | - |
| | 593,217,355 | (400,832,691) | 14,620,895 | 6,174,016 | (92,201,226) | 120,978,349 | 29,017,423 |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**39 <u>Санхүүгийн эрсдэлийн удирдлага</u>**

**(a) Оршил**

Групп нь санхүүгийн хэрэгслүүдийг ашигласнаар дараах эрсдэлүүдийг хүлээж байдаг.

- Зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Зах зээлийн эрсдэл

Энэхүү тодруулга нь дээрх эрсдэл тус бүрийн Группт нөлөөлөх нөлөөлөл, үг эрсдэлийг тооцоолох, удирдах Группын зорилго, бодлого, авах арга хэмжээ, мөн Группын хөрөнгийн удирдлагын талаарх мэдээллийг агуулсан.

*Эрсдэлийн удирдлагын тогтолцоо*

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Группын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өөр өөрийн ажлын чиг хүрээнд банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулж, хянах үүрэг бүхий Актив, Пассивын Удирдлагын Хороо (АПУХ) болон Зээлийн Хороог байгуулсан.

Группын эрсдэлийн удирдлагын бодлого нь Группт тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон системийг зах зээлийн нөхцөл байдал болон Группын үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд тогтмол хянаж байдаг. Групп өөрийн сургалт, удирдлагын стандарт болон журамыг ашиглан ажилчид нь өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ойлгосон, дэг журамтай, бүтээлч хяналтын орчныг бий болгохоор зорьж ажилладаг.

Группын Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Группын эрсдэлийн удирдлагын бодлого, журам хэрхэн хэрэгжиж байгааг хянах, Группт тулгарч буй эрсдэлд эрсдэлийн удирдлагын ерөнхий тогтолцоо тохирч буй эсэхийг хянан хэлэлцэх үүрэгтэй. Төлөөлөн Удирдах Зөвлөлийг энэ үүргээ биелүүлэхэд нь Дотоод Аудитын Газар туслалцаа үзүүлдэг. Дотоод Аудитын Газар нь эрсдэлийн удирдлагын хяналт, горимыг тогтмол болон тусгайлан тодорхой тохиолдлуудад хянан үзэж, үр дүнг нь Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнадаг.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**39 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**(б) Зээлийн эрсдэл**

Зээлийн эрсдэл гэдэг нь Группын зээл, урьдчилгаа болон хөрөнгө оруулалтын үнэт цаас зэргээс харилцагч эсвэл санхүүгийн хэрэгслийн холбогдох тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйгээс Групп санхүүгийн алдагдал хүлээх эрсдэл юм.

*Зээлийн эрсдэлийн удирдлага*

Төлөөлөн Удирдах Зөвлөл зээлийн эрсдэлийн удирдлагын талаарх өөрийн үүргийг Зээлийн Хороонд төлөөлүүлсэн байна. Салбар бүр Группын Зээлийн Хорооноос тогтоосон зээл олгох эрх мэдлийн хүрээнд Группын зээлийн бодлого, журамыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн салбар нэг бүр нь өөрийн зээлийн багцын чанар, гүйцэтгэл болон багц дахь зээлийн эрсдэлийг хянан, удирдах үүрэг хүлээдэг.

Дотоод Аудитын Газраас зээлийн үйл явц болон салбаруудад тогтмол аудит хийдэг.

Тайлагналын өдрөөрх зээл болон хөрөнгө оруулалтыг хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр харуулбал дараах байдалтай байна. “Дотоодын актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ” (“ДАЧЭБАХ”) хөтөлбөрийн гэрээ болон Монголбанкны тушаалаар ангилал хийсэн. (Тодруулга 7)

| *(Мянган төгрөгөөр)* | Зээл ба урьдчилгаа | | Хөрөнгө оруулалтын үнэт цаас | |
|---|---|---|---|---|
| | 2017 | 2016 | 2017 | 2016 |
| Дансны үнэ | 2,764,974,569 | 2,835,167,306 | 1,910,686,942 | 1,329,001,579 |
| Хэвийн зээл | 2,477,772,798 | 2,495,898,306 | 1,910,686,942 | 1,329,001,579 |
| Хугацаа хэтэрсэн зээл (*) | 330,117,241 | 269,964,291 | - | - |
| Чанаргүй зээл. Үүнээс: | | | | |
| а) Хэвийн бус зээл | 46,097,859 | 101,288,684 | - | - |
| б) Эргэлзээтэй зээл | 55,778,226 | 105,022,665 | - | - |
| в) Муу зээл | 123,140,907 | 16,559,997 | - | - |
| Нийт дүн | 3,032,907,031 | 2,988,733,943 | 1,910,686,942 | 1,329,001,579 |
| Эрсдэлийн сан ба хасагдуулга | (267,932,462) | (153,566,637) | - | - |
| Цэвэр дүн | 2,764,974,569 | 2,835,167,306 | 1,910,686,942 | 1,329,001,579 |
| Санхүүгийн батлан даалт | 471,676,191 | 639,918,016 | - | - |
| Зээл болон кредит картын үүрэг хариуцлага | 166,400,776 | 172,678,391 | - | - |
| Санхүүжүүлээгүй хамтын эрсдэлийн оролцоо | 70,325,790 | 111,791,240 | - | - |
| | 708,402,757 | 924,387,647 | - | - |

(*) Энэ ангилалд багтаж буй зээлүүд нь гэрээгээр тогтсон зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлөлт нь хугацаа хэтэрсэн боловч барьцаа хөрөнгийн байдал болон Группт төлөх мөнгөн дүнгийн цуглуулалтын үе шатанд үндэслэн Групп үнэ цэнийн бууралт тооцох нь зохисгүй гэж үзсэн зээлүүд юм.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**39 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**(б) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

*Үнэ цэнэ буурсан зээл болон үнэт цаас*

Үнэ цэнэ нь буурсан зээл, үнэт цаас гэдэг нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа алдагдалд хүргэх үйл явдал тохиолдсон бөгөөд уг алдагдалд хүргэх үйл явдал нь хөрөнгийн найдвартайд тооцогдох ирээдүйн мөнгөн урсгалд нөлөө үзүүлэх үндэслэлтэй нотолгоо бүхий зээл, үнэт цаасыг хэлнэ.

Доорх хүснэгтэд хугацаа хэтэрсэн эсвэл үнэлгээ буурсан хөрөнгийн дүнг нийт болон цэвэр (зээлийн болзошгүй эрсдийн сан байгуулсны дараах) дүнгээр ангилал тус бүрээр нь үзүүлэв.

| | 2017 Мян.төг | | | 2016 Мян.төг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нийт | Цэвэр | Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ (*) | Нийт | Цэвэр | Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ (*) |
| Хугацаа хэтэрсэн | 330,117,241 | 252,004,180 | 242,316,653 | 269,964,291 | 223,146,289 | 197,553,676 |
| Хэвийн бус | 46,097,859 | 32,182,273 | 32,086,793 | 101,288,684 | 75,966,513 | 75,803,959 |
| Эргэлзээтэй | 55,778,226 | 16,246,030 | 16,152,788 | 105,022,665 | 52,511,332 | 49,853,563 |
| Муу(*2) | 123,140,907 | (1,040,231) | - | 16,559,997 | - | - |
| | 555,134,233 | 299,392,252 | 290,556,234 | 492,835,637 | 351,624,134 | 323,211,198 |

(*1) Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь барьцаа хөрөнгийн зүйл тус бүрээрх зээлийн эрсдэлээс хамгаална гэдгийг илэрхийлнэ. Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэд зээлийн чанар сайжруулалтын бусад төрлүүд болох хөвөгч хүү, гуравдагч этгээдийн баталгаа батлан даалт болон бусад биет хөрөнгийн зээлийн эрсдэлийн хамгаалалт багтаагүй болно.
(*2) Эрсдэлийн санд хэрэгжээгүй зээлийн үүргүүд орсон болно.

Групп нь харилцагчдад зээл ба урьдчилгааг олгохдоо үл хөдлөх эд хөрөнгө, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас барьцаанд авах ба баталгаа гаргуулдаг. Ерөнхийдөө буцаан борлуулахаар худалдан авсан гэрээ болон үнэт цаасаарх санхүүжилтийн үйл ажиллагаанаас бусад тохиолдолд бусад банкинд зээл, санхүүжилт олгоход барьцаа авдаггүй. 2017 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын үнэт цаасанд барьцаа аваагүй.

Зээл бүрэн төлөгдөх эсэх нь хэд хэдэн хүчин зүйлсээс хамаарах ба түүний дотор батлагдсан эсвэл хэлцлийн шатандаа байгаа бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний хүрээнд харилцагч амжилттай ажиллаж чадах эсэх, Монгол Улсын одоогийн эдийн засгийн нөхцөл байдлын хүрээнд зээлдэгчид зээлийн төлбөрөө барагдуулж чадах эсэх, сөрөг хандлагууд болон бусад тааламжгүй үр дагаврууд хэдий удаан үргэлжлэх зэрэг хүчин зүйлүүдээс хамаардаг. Тиймээс ойрын ирээдүйд Группын нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц дүнгээр чанаргүй зээлийн алдагдлын сан болон хөрөнгө оруулалтын дансны үнэд залруулга хийж болох үндэслэлтэй юм.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**39 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**(б) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

Групп нь зээлийн эрсдэлийн төвлөрлийг эдийн засгийн салбаруудаар удирддаг. Тайлант жилийн зээлийн эрсдэлийн төвлөрлийг харуулсан шинжилгээг дор харуулав:

| | 2017 Мян.төг | 2016 Мян.төг |
|---|---|---|
| Хөдөө аж ахуй | 16,092,838 | 15,714,040 |
| Уур уурхай ба олборлолт | 255,823,865 | 240,828,986 |
| Үйлдвэрлэл | 340,965,750 | 274,246,131 |
| Түлшний импорт ба худалдаа | 80,263,373 | 91,124,769 |
| Худалдаа | 602,055,280 | 494,210,051 |
| Барилга | 389,100,404 | 456,448,086 |
| Цахилгаан, эрчим хүч ба дулаан | 1,387,672 | 67,796,130 |
| Зочид буудал, ресторан ба аялал зуучлал | 189,522,217 | 221,693,441 |
| Санхүүгийн үйлчилгээ (*) | 303,438,332 | 341,952,173 |
| Тээвэр | 41,955,252 | 42,641,764 |
| Эрүүл мэнд | 16,165,173 | 19,419,045 |
| Боловсрол | 4,344,363 | 22,357,776 |
| Орон сууц | 247,491,200 | 343,081,723 |
| Төлбөрийн карт | 112,245,734 | 82,231,423 |
| Барьцаалсан хадгаламж | 39,676,520 | 22,195,922 |
| Бусад | 124,446,596 | 99,225,846 |
| Нийт | 2,764,974,569 | 2,835,167,306 |

(*) Группын санхүүгийн салбарын кодчилолын дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэж буй холдинг компанийг санхүүгийн үйлчилгээний салбарт ангилсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**39 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**(б) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

Банкны тухай хуулийн дагуу Группээс нэг зээлдэгч болон түүнтэй холбоотой бүлэг этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, батлан даалтын нийлбэр дүн нь тухайн Группын өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй. Группын хувь нийлүүлэгч, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүн, Гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон тэдгээрт холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, батлан даалтын дээд хэмжээ нь Группын өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтэрч болохгүй. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн төвлөрүүлэлтэнд тавигдах дараах шалгуур үзүүлэлтүүд байна:

| Үзүүлэлт | Тохиромжтой харьцаа | 2017.12.31 | Зөрчил |
|---|---|---|---|
| Нэг зээлдэгчид олгосон зээл ба батлан даалт | <ӨХ 20% | 18.77% | - |
| Холбоотой нэг этгээдэд олгосон зээл ба батлан даалт | <ӨХ 5% | 0.24% | - |
| Холбоотой талуудад олгосон зээл ба батлан даалт | <ӨХ 20% | 1.48% | - |

**(в) Хөрвөх чадварын эрсдэл**

Хөрвөх чадварын эрсдэл нь санхүүгийн өр төлбөртэй хамаарал бүхий үүрэг хариуцлагаа биелүүлэхэд Группт тулгарч болох аливаа хүндрэлүүд юм. Группын хөрвөх чадвараа удирдах арга хандлага нь хэвийн болон ачаалалтай аль ч үед аль болох хугацаанд нь өөрийн өр төлбөрийг барагдуулах хангалттай хөрвөх чадвартай байх, үл хүлээн зөвшөөрөгдөх аливаа алдагдлыг хүлээхгүй байх, Группын нэр хүндэд сэв суулгахгүй байх явдал юм.

Групп нь тайлант үеийн хадгаламж, хугацаа нь дуусч буй хадгаламж болон зээлийн төлөлт зэрэгт хангалттай хэмжээний бэлэн мөнгөний нөөцийг тогтмол байршуулах шаардлагатай байдаг. Группын Актив, Пассивын Удирдлагын Хороо (АПУХ) нь бэлэн мөнгөний гадагш урсгалд хүрэлцэхүйц хэмжээний мөнгийг бэлэн байлгахын тулд хугацаа нь дуусч буй эх үүсвэрийн доод хэмжээнд хязгаар тогтоохын зэрэгцээ гэнэтийн их хэмжээний гүйлгээ хийхэд хөрөнгийг бэлэн байлгах үүднээс банк хоорондын болон бусад зээлдэгч байгууллагын өрийн хэрэгслийн доод хэмжээг тогтоодог.

*Хөрвөх чадварын эрсдэлд өртөх нь*

Группын хөрвөх чадварын эрсдэлийг удирдахад ашигладаг гол хэмжүүр нь Банкны тухай хуулийн дагуу хөрвөх активыг нийт пассивтай харьцуулсан харьцаа юм.

Энэхүү зорилгын хүрээнд Групп хөрвөх чадварын харьцааг хадгалж байдаг ба Группын хөрвөх чадварын харьцааг тооцоход хөрвөх активыг (бэлэн мөнгө, банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, Монголбанкинд байршуулсан мөнгө болон хөрөнгө оруулалтын үнэт цаас) хөрвөх пассивт (харилцагчийн харилцах, хадгаламж, банк болон бусад санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээл, татварын өр төлбөр болон гаргасан өрийн үнэт цаас) харьцуулдаг.

Тооцоолсон харьцаанууд тайлагналын өдрөөр дараах байдалтай байна:

| | 2017 | 2016 |
|---|---|---|
| 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 46% | 47% |

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулга**

**39 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**(в) Хөрвөх чадварын эрсдэл (үргэлжлэл)**

Дараах хүснэгтэнд Группын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг төлөгдөх үлдсэн хугацаанд нь үндэслэн холбогдох дуусгавар болох хугацаагаар нь бүлэглэн ангилсан шинжилгээг харууллаа:

*(Мянган төгрөгөөр)*

| 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар | 3 хүртэлх сар | 3-6 сар | 6 сараас 1 жил | 1-5 жил | 5-аас дээш жил | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс | 62,641,118 | - | - | - | - | 62,641,118 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 218,623,755 | - | - | - | - | 218,623,755 |
| Монголбанк дахь үлдэгдэл | 792,668,509 | - | - | - | - | 792,668,509 |
| Буцаан борлуулах гэрээгээр худалдан авсан үнэт цаас | 11,981,945 | - | - | - | - | 11,981,945 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 684,543,820 | 1,863,585 | 64,731,736 | 822,689,169 | 452,458,397 | 2,026,286,707 |
| Зээл ба урьдчилгаа | 252,267,353 | 266,652,507 | 425,932,380 | 1,448,374,385 | 371,747,944 | 2,764,974,569 |
| Хоёрдогч зээл | - | - | - | - | - | - |
| Бусад хөрөнгө (*1) | 152,896,045 | 70,626 | 2,442,016 | 345,377,776 | 10,096,671 | 510,883,134 |
| | 2,175,622,545 | 268,586,718 | 493,106,132 | 2,616,441,330 | 834,303,012 | 6,388,059,737 |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 891,225,663 | 599,280,346 | 665,078,478 | 912,015,449 | 2,633,700 | 3,070,233,636 |
| Банк, бусад санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламж | 52,048,414 | 30,584,572 | 137,257,221 | 24,017,384 | - | 243,907,591 |
| Буцаан худалдах гэрээгээр борлуулсан үнэт цаас | - | - | 64,960,388 | 65,000,000 | - | 129,960,388 |
| Санхүүгийн байгууллагуудаас авсан зээл | 142,351,013 | 95,361,575 | 378,200,684 | 280,595,934 | 172,160,237 | 1,068,669,443 |
| Гаргасан өрийн үнэт цаас | - | - | - | 1,344,633,676 | - | 1,344,633,676 |
| Хоёрдогч өглөг | - | - | - | - | - | - |
| Бусад өр төлбөр (*2) | 75,868,662 | 16,902,622 | 28,155,663 | 20,691,917 | 341,830 | 141,960,694 |
| Гаргасан санхүүгийн батлан даалт | 471,676,191 | - | - | - | - | 471,676,191 |
| Хүлээн зөвшөөрөөгүй зээлийн үүрэг | 166,400,776 | - | - | - | - | 166,400,776 |
| Эх үүсвэргүй нэгдсэн эрсдэлийн оролцоо | 70,325,791 | - | - | - | - | 70,325,791 |
| | 1,869,896,510 | 742,129,115 | 1,273,652,434 | 2,646,954,360 | 175,135,767 | 6,707,768,186 |
